



**MONGOLIAN ACTION PROGRAMME FOR THE 21<sup>ST</sup> CENTURY**  
**МОНГОЛ УЛСЫН XXI ЗУУНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН**  
**ХӨТӨЛБӨР**



**Prof.DAIRIJAVIIN DAGVADORJ**

**Проф. ДАЙРИЙЖАВЫН ДАГВАДОРЖ**

**SUSTAINABLE DEVELOPMENT – MONGOLIAN FUTURE**

**ТУЛХТАЙ ХӨГЖИЛ – МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ**

**ULAANBAATAR 2002**

УЛААНБААТАР 2002



МОНГОЛ УЛСЫН ХХІ ЗУУНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН  
ХӨТӨЛБӨР

MONGOLIAN ACTION PROGRAMME FOR THE 21<sup>ST</sup> CENTURY



Проф. ДАЙРИЙЖАВЫН ДАГВАДОРЖ

Prof.DAIRIJAVYN DAGVADORJ

ТУЛХТАЙ ХӨГЖИЛ – МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ

SUSTAINABLE DEVELOPMENT – MONGOLIAN FUTURE

Эмхтгэж, хянан тохиолдуулсан: Док.Л.Нямцэрэн

Editor: Dr.Lhamsurengiin Nyamtseren

ISBN 999929 720 17

## ULAANBAATAR 2002

### ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	5
НЭГ. ДАЯН ДЭЛХИЙН ТУЛХТАЙ ХӨГЖИЛ БА МОНГОЛ УЛС	
1. ДАЯН ДЭЛХИЙН ХӨГЖИЛД ХӨЛ НИЙЛҮҮЛЭХ АЛХАА	8
2. МОНГОЛЫН БА ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ: ТҮҮХЭН ҮЙЛ ЯВЦ, СУРГАМЖ, ДҮГНЭЛТҮҮД	11
3. ТУЛХТАЙ ХӨГЖИЛ БА НҮҮДЭЛЧ МАЛЧИД	18
4. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН УДИРДЛАГА БА НҮҮДЛИЙН НИЙГЭМ	25
4. ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТЭДИЙН VIII ИХ ХУРЛЫН «ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН АСУУДАЛД: ХҮНИЙ ХӨГЖИЛ БА ОРЧИН» СЭДВЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН ДӨРӨВДҮГЭЭР САЛБАР ХУРАЛДААНЫ ТОЙМ, ҮР ДҮН, САНАЛ, ДҮГНЭЛТҮҮД	29
6. ДАЯН ДЭЛХИЙН ТУЛХТАЙ ХӨГЖИЛ БА МОНГОЛ УЛС	33
7. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТУЛГАМДАЖ БУЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	39
8. ОЛОН УЛС, БҮС НУТАГ, ҮНДЭСНИЙ ТҮВШИН ДЭХЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА	45
9. ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛД	48
10. МОНГОЛ УЛСЫН XXI ЗУУНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ, БОДЛОГЫН ЧИГЛЭЛҮҮД	63
11. БАРУУН БҮСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД	79
<b>ХОЁР. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ ХОРООНЫ ЧУУЛГАНУУДАД МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦСОН НЬ</b>	
1. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ ХОРООНЫ 2 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГАНД	88
2. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ ХОРООНЫ 3 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГАНД	92
3. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ ХОРООНЫ 4 ДЭХ УДААГИЙН БЭЛТГЭЛ ЧУУЛГАНД	97
4. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ ЧУУЛГА УУЛЗАЛТАД МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦСОН НЬ	103
<b>ГУРАВ.. ДАЯН ДЭЛХИЙН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН ТАЛААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ӨГСӨН ЯРИЛЦЛАГА</b>	
<b>1. "ТУЛХТАЙ" ХӨГЖИЛ БА МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ</b>	<b>110</b>
2. МОНГОЛ УЛС АЗИ ТИВД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫГ ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА ГЭДГИЙГ ЧУУЛГАНЫ ДАРГА ОНЦЛОН ТЭМДЭГЛЭСЭН	114
3. ЛИДЕР ЭДИЙН ЗАСАГЧ БАЙЯ ГЭВЭЛ БАЙГАЛЬ, НИЙГМЭЭ СУДАЛ	116
4. ЦЭРЭГ ДАЙНЫ ЗАРДЛАА БАГАСГАЖ, БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛАХАД ЗОРИУЛАХ ТУХАЙ ЯРИЛЦЛАА	118
5. ТУЛХТАЙ ХӨГЖИЛ ДАЯН ДЭЛХИЙН № 1 АСУУДАЛ	119
<b>ДӨРӨВ. АНГЛИ ХЭЛЭЭР БЭЛТГЭЖ, ТАВЬСАН ИЛТГЭЛҮҮД</b>	
1. МОНГОЛЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ОДООГИЙН БАЙДАЛ	123
<b>2. ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛД</b>	<b>135</b>
3. МОНГОЛЫН ТУЛХТАЙ ХӨГЖИЛД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ ЗАРИМ САНАА	149
4. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЛААРХИ ДЭЛХИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТАД БЭЛТГЭХ ХОРООНЫ ХОЁРДУГААР ХУРАЛДААНЫ ОРОЛЦОГЧДОД ХАНДАЖ ХЭЛСЭН ҮГ	156
5. ТУЛХТАЙ ХӨГЖИЛ БА НҮҮДЛИЙН МАЛЧИД	158

## CONTENTS

<b>Foreword</b>	6
<b>First. World Sustainable Development and Mongolia</b>	
1. Step in tune with the world development	8
2. Mongolian and World sustainable development: Historical process, lessons learned and conclusions	11
3. Sustainable development and nomadic herders	18
4. International management of sustainable development and nomadic society	24
5. Review, results, opinions and conclusions reached from 4th session "Sustainable Development Issues: Human Development and Environment" at 8th International Congress of Mongolists	29
6. World sustainable development and Mongolia	32
7. National level sustainable development issues and ways to resolve them	39
8. Sustainable development management at international, regional and national levels	45
9. Cooperation of North East Asia towards sustainable development	48
10. Critical issues and policy directions of national strategy of sustainable development in Mongolia	63
11. Issues and ways to resolve Mongolian western regions sustainable development	79
<b>Second. Participations of Mongolian Delegation in the Preparatory Committee Meetings and in the World Summit on Sustainable Development</b>	
1. At the 2nd preparatory committee meeting for WSSD	88
2. At the 3rd preparatory committee meeting for WSSD	92
3. At the 4th preparatory committee meeting for WSSD	97
4. At the World Summit on Sustainable Development	103
<b>Three. Interviews given in newspaper and other media on World and Mongolian sustainable development</b>	
1. Sustainable Development and Mongolian future	110
2. The committee chairman noted that Mongolia successfully organizes sustainable development management in the Asian continent	114
3. If you want to become a leader economist study nature and society Interview about reduction of military expenses and increase of resources for nature protection	116 118
5. Sustainable development Number 1 issue of the world	119
<b>Four. Speeches prepared and delivered in English language</b>	
1. Current Status of the NCS in Mongolia	123
2. Northeast Asian Cooperation Towards sustainable development	135
3. Some ideas in investing for sustainable development of Mongolia	149
4. Speech addressed to the participants of the second session of the preparatory committee for the world summit on sustainable development	156
5. Sustainable development and nomadic herders	158

## ӨМНӨХ ҮГ

Рио Де Жанеро хотноо 1992 онд болсон «Орчин ба Хөгжил» сэдэвт НҮБ-ийн бага хурлын дараахь 10 жил, ялангуяа 2002 он бол дэлхий нийтээр тогтвортой хөгжлийн үзэл санааны хэрэгжилтийн явцад хүрсэн амжилт, алдаа дутагдал, сурсан сургамж, байгаль орчны өнгөрсөн, одоо, ирээдүйн төлөв байдлыг үнэлж цэгнэсэн, цаашид яах асуудлаа олон түвшинд хэлэлцэн тохиролцсон, маргаж мэтгэсэн бодит үйл ажиллагааны давалгаалсан он байлаа. Энэ ч зүйн хэрэг байв. Учир нь 2002 онд Өмнөд Африкийн Иоханнесбург хотноо дэлхийн улс орнуудын тэргүүн нар чуулж, Риогоос хойшхи 10 жилийн хугацаанд дэлхийн хэмжээнд тогтвортой хөгжлийн талаар хүрсэн амжилтаа дүгнэн, цаашид дэлхийн хүн төрөлхтөн яаж хөгжих төлөвлөгөөг хэлэлцэж баталсан юм.

Дэлхий ертөнц орших, эс орших, хөгжих, эс хөгжих арга замыг сонгох энэхүү давалгаан дунд Монгол улс хоцролгүй өөрийн гэсэн далбаат хөлөг/ 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр/-өө бүтээж, түүнийг Монгол улсын Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл зохион байгуулж хэрэгжүүлдэг юм /Ерөнхий сайдаараа удирдуулан/. Энэ хөлгийн капитан /үндэсний зохицуулагч/-аар Проф. Д.Дагвадорж 2001 оны төгсгөлөөс орж ажилласан бөгөөд эрхэм уншигч танд толилуулж буй энэхүү номд орж буй бүтээлүүд бол сүүлийн нэг жилд даян дэлхийн хөгжилд Монгол улсын хөлийг нийлүүлэх талаар хүчин чармайсан түүний хувь нэмрийг бага ч болов илэрхийлэх буй заа. Тэрбээр 2002 онд Нью Иорк, Индонезийн Бали хотуудад болсон тогтвортой хөгжлийн 3 удаагийн бэлтгэл чуулган, Өмнөд Африкийн Иоханнесбургт болсон Дээд хэмжээний чуулга уулзалтад биечлэн оролцсоны хувьд энэхүү номд орсон илтгэл, өгүүлүүддээ бодитой, тодорхой дүгнэлт, саналууд дэвшүүлэх боломж олгосон юм. Энэхүү номд «тогтвортой хөгжил» гэдгийг гол төлөв «тулхтай хөгжил» гэж нэрлэснийг эрхэм уншигч авгай та анхааран соёрхоно уу. Анхнаасаа бид «тогтвортой хөгжил» гэж орчуулан заншсан нь “sustainable development” гэсэн үгийн жинхэнэ агуулгыг бүрэн илэрхийлж чадахгүй байгаа юм. Иймд бид үгийн агуулгыг бүрнээр нь илэрхийлж чадах «тулхтай хөгжил» гэсэн шинэ нэр томъёог хэрэглэсэн болно. Энэхүү номыг Монгол орноо хөгжүүлэх чин эрмэлзэл өвөрлөн бүтээл туурвиж буй эрдэмтэн мэргэд, судлаачид, төрийн

болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн ажилтнууд, их дээд сургуулийн профессор, багш нар, оюутан залуусын гарын авлага болгох зорилготойгоор бүтээв. Эрхэм уншигч авгай та өөрийн оюуныхаа мэргэн шүүлтүүрээр шүүж, бодол саналаа болон Монгол орноо дэлхийн хөгжлөөс хоцроохгүй явуулах өөрийн арга, ухааны ундрагаасаа бидэнтэй хуваалцана гэдэг гүнээ итгэж байна.

Хянан тохиолдуулсан, Док (PhD). Л.Нямцэрэн

## **FOREWORD**

The 10 years after the UN Conference “Environment and Development” in Rio De Janeiro, 1992, in particular the year 2002 was a year of waves of practical activities of evaluations of achievements, failures, lessons learned and the past, current and future state of the environment and discussions, debates and negotiations of future problems at all levels in all the world. Because, the World Summit on Sustainable Development was convened by the leaders of countries of the world in Johannesburg, South Africa in 2002 and approved the plan of implementation, how further to develop our planet assessing the achievements on sustainable development during 10 years after Rio.

Mongolia did not stay behind in this waves that our planet would choose its way whether the planet will exist or not, whether the planet will develop or not, but Mongolian had built its ship (Mongolian Action Programme for 21<sup>st</sup> century) with its flag and organized and implemented them by its Council for Sustainable Development of Mongolia (led by Prime Minister). Prof.D.Dagvadorj has joined as Capitan (national coordinator) of this ship since the end of 2001 and the articles included in this book could express at least his contribution in efforts to bring Mongolia's step in tune with the world development in a period of one year. It makes possible that to raise practical and concrete conclusions and proposals in papers and articles included in this book as he was participated in three preparatory meetings of sustainable development in New York and Bali, Indonesia and WSSD in Johannesburg, South Africa in 2002.

This book is intended to be a guideline for scientists, researchers, officers of state, non-governmental and private sector organization, professors, teachers, students and youths in universities who have a firm aspirations to develop Mongolia and work for them. I am in intensely thrust that you, my honorable reader will filter this book through your wise sieve of your wisdom and to share your opinion, your methods and intellectual thoughts that let Mongolia not left behind from the world development.

## НЭГ. ДАЯН ДЭЛХИЙН ТУЛХТАЙ ХӨГЖИЛ БА МОНГОЛ УЛС

### 1. ДАЯН ДЭЛХИЙН ХӨГЖИЛД ХӨЛ НИЙЛҮҮЛЭХ АЛХАА

#### **Step in tune with the world development**

/Published in the "Unen" newspaper, No.251, 27 December 2001/

Mongolian Action Program on Sustainable Development for 21st century represents the step of Mongolia in tune with the world development, which was developed with active participation of multi-stakeholders including scientists, governmental and non-governmental officials and as well with support of international agencies. Therefore, this has a crucial importance for the Mongolian development as a complete product of many multi-stakeholders. The program originated in Mongolia from the world healthy inspiration to develop the country economically and socially in harmony with environmental protection and it is adequately linked with the world development trends. There are many things that have been done by the policy makers, however they should realize the essence of the issues, in that case the program will be implemented well in the future. Especially, there is a need to use the potential of national scientists for the country's sustainable development regulation by unified human resource policies and utilization. Finally, both our future generation and our self will benefit from sustainable development.

Зах зээлийн харилцаанд шилжин орох үйл явц манай оронд олон шинэ зүйлийг бий болгосны нэг нь хөгжлийнхээ чиг баримтлалыг тогтоох эрэл хайгуул, түүний үр дүнд бий болсон бодлогын шинжтэй хөтөлбөрүүд юм. Тэр бүхний тухай өгүүлбэл олон арван боть ном гарна. Би энд даян дэлхийн хөгжилд Монгол орноо хөл нийлүүлэн алхлуулах чиг баримтлалыг багтаасан Монгол улсыг 21-р зуунд тогтвортой хөгжүүлэх хөтөлбөрийн тухай онцлон ярьж бодож байна. 1996 оноос эхэлж боловсрогдон олон арван эрдэмтэд, төр засгийн зүтгэлтнүүд, Монголын хөгжлийг дэмжих сайн санаа өвөрлөсөн гадаадын байгууллага хүмүүсийн оюун ухаанаар бүтээгдсэн энэ хөтөлбөр хэмжээ далайц Монголын хөгжилд үзүүлэх ач холбогдлын хувьд үнэхээр томоохон нь юм.

Байгаль орчиндоо зохицсон хөгжлийн асуудал гол агуулгыг нь бүрдүүлж буй энэ хөтөлбөр иж бүрэн шинжтэй улс орны хэтийн хөгжлийг 2020 он хүртэл харахыг хичээснээрээ нэн өргөн цар хүрээтэй юм. Хөтөлбөрийг 21-р зууны Монголын хөгжил гэдэг үгийн товчилсон нэр "МХ-21" гэдгээр нэрлэж заншаад байгаа билээ. Бас «Монголын хөгжлийн хөтөлбөр» гэдэг хэллэгийн «МАР-21» гэж нэрлэдэг. Энэ хөтөлбөр Монгол орны төдий бус ертөнцийн хүн ардын байгальтайгаа зохицон хөгжих гэсэн шинэ санаанаас урган гарсанаараа дэлхий дахины эрүүл саруул сэтгэлгээнээс үүдэлтэй гэж үзэж болно. Зөвхөн өнөө үеийнхний сайн сайхан амьдралыг хангахыг гол болгоод зогсохгүй ирээдүй үеийн цэцэглэл хөгжлийн асуудлыг хамтад нь бодолцож хийснээрээ энэ хөтөлбөр далайцтай болсон юм.

Улс орон бүр тогвортой хөгжлийнхөө асуудлаар боловсруулсан стратеги бодлогоо үндэсний хэмжээний болон яам газруудынхаа үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлж байна. Жишээ нь өмнөт хөрш Хятад улс гэхэд л "Тогтвортой хөгжлөөс өөр арга зам байхгүй" гэдэг уриаг бүх шатандаа хэвшүүлж энэ үйл хэрэгт засгийн газар, иргэний нийгэм түүнийг төлөөлсөн төрийн бус байгууллагууд, бизнесийн хүрээнийхэн өргөнөөр оролцож хэрэгжүүлдэг ажээ.

Манайд ч энэ чиглэлээр доривтой алхмууд хийсэн байна. Тогтвортой хөгжлийн асуудал, ухагдахуун үндэсний төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгагдах боллоо. Жишээ нь, 2001 оны үндсэн чиглэлд газар тариалангийн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжих нөхцөлийг хангахад чиглэсэн эрхзүй, эдийн засгийн таатай орчин бүрдүүлнэ гэж тусгасан байна.

Мөн олон талууд, оролцогчидтой ярилцлага явуулж, зөвлөгөөн хийсний үр дүнд УИХ-ын сонгуульд оролцсон олон намууд сонгуулийн мөрийн хөтөлбөртөө тогтвортой хөгжлийн асуудлыг тусган өрсөлдсөн нь энэ үзэл баримтлал олны хүртээл болох чиглэлд хийсэн нэгэн томоохон алхам болж байна .

Сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан шинэ Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт байгалийн баялгийг түүний даац, чадавхитай нь нийцүүлэн зохистой ашиглах, нөхөн сэргээх замаар экологийн баримжаатай хөгжлийг хангана гэж оржээ. Энэ Засгийн газар МХ-21 төслийн туслалцаатайгаар Үндэсний байгаль орчны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулсан юм. Энэ төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн гол асуудлыг тусган, шаардлагатай арга хэмжээг тодорхойлон заасан байна. Аймгийн засаг дарга нарын 2001-2004 оны хөтөлбөрт аймгуудын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн асуудлууд тусгагдсан байна. Тухайлбал, Баянхонгор аймгийн хөтөлбөрт ойн нөөцийн экологи, эдийн засгийн үнэлгээг хийж, ойжуулах, ойн нөөцийг зохистой ашиглаж хамгаалах арга хэмжээг дэмжиж ажиллахаах тусгажээ.



2000 оны 10-12 сард, МХ-21 төсөл “Хүний хөгжлийн төлөө сайн засаглал” хөтөлбөр боловсруулах ажилд оролцсон ажээ. Одоо сайн засаглал хөтөлбөрийг тогтвортой хөгжлийн чиглэлээр нэгэнт хийгдсэн судалгааны ажлууд төслийн тооцоонуудтай уялдуулах хэрэгтэй байна.

Мөн МХ-21 хөтөлбөрт үндэслэн Монголын Шинжлэх Ухааны Академи “Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн 20 жилийн төлөвлөгөө” боловсруулсан байна. Эрчимт мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийн загвар сэдэвт жижиг төслийг Төв аймгийн Эрдэнэ сум, Өвөрхангай аймгийн Баян-Өндөр, Баянхонгор аймгийн Баацагаан суманд тус тус хэрэгжүүлж байгаа нь бэлчээр хамгаалах, өнөөгийн түвшинд хадгалах загварын туршилт болж газрын шинэтгэлийн үйл явцад хувь нэмэр оруулж байна. Төслийн анхны үе шатанд хэрэгжсэн жижиг төслийн хөрөнгийг буцаан төвлөрүүлж орон нутагт тогтвортой хөгжлийн эргэлтийн сан байгуулж байна.

Үндэсний хөгжлийн ирээдүйтэй холбоотой глобал асуудлыг хөндөж байгаагаараа МХ-21 төсөл ирээдүйг харсан чиглэлтэй юм. МХ-21-ийн оролцоотойгоор Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн үндэсний тайланг боловсруулжээ.

Өөр нэг ялгагдах онцлог бол МХ-21 төслийн үр дүн бүх аймаг, Улаанбаатар хотыг хамарч байгаад оршино. 21 аймаг, нийслэлийн 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж тухайн аймаг хот хөгжлийнхөө чиг баримжаа болгож байна.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг олон түмний хүртээл болгоход төрөл бүрийн чиглэлээр зохион байгуулсан сургалт нэн чухал учир холбогдолтой. Стратегийн төлөвлөлт, цэвэр үйлдвэрлэл, үндэсний чадавхи бүрдүүлэх болон төслийн удирдлагын сэдвээр хийсэн сургалт семинарууд амжилттай болжээ. Хоёр хүн Залуучуудын тогтвортой хөгжил сэдвээр Турк улсад богино хугацааны сургалтад хамрагдаж, нэг хүн Израиль улсад цөлжилттэй тэмцэх сэдвээр 2 жилийн сургалтад оролцож байна. Иргэдийн дунд төрөл бүрийн уралдаан, тэмцээн явуулж телевиз радиогийн нэвтрүүлэг, нийтлэл хийж байна. Энэ оны зун тогтвортой хөгжлийн сурах бичиг зохиох нээлттэй тендэр зарлаж "Эко-Ази" дээд сургуулийн баг шалгараад байна. Энэ сурах бичиг их дээд сургуулийн оюутан багш нарын үнэ цэнтэй гарын авлага байх болно.

Хийж хэрэгжүүлж байгаа зүйл багагүй байгаа боловч бодлого боловсруулагчид, төлөвлөгчид энэ асуудлын ач холбогдлыг бүрэн утгаар нь нь ойлгож хэрэгжүүлэх талаар илүүтэй анхаарах хэрэгтэй байна. Ялангуяа үндэсний эрдэмтдийн нээлт бүтээлийн үр дүнг улс орны тогтвортой хөгжлийн ирээдүйд ашиглах нь хойшлуулшгүй зорилт болон тавигдлаа. Манай эрдэмтэд уламжлалт билчээрийн мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэх, биотехнологийн

ололтыг хэрэглэх, өөрчлөгдөж байгаа зах зээлийн шаардлагад нийцсэн удирдлага төлөвлөлтийн шинэ механизм бий болгох , ховор эмийн бодисууд гаргаж авах зэргээр байгаль нийгмийн шинжлэх ухааны салбарт маш олон нээлт бүтээл гаргаад байна. Энэ бүхнийг нэгдмэл бодлогоор хэрэгжүүлж шинэ зууны тогтвортой хөгжлийн стратегид ашиглаж чадвал бид төдийгүй бидний хойч үеийнхэн хожино.

/Үнэн сонины 2001 оны 12 дугаар сарын 27-ны 251 дугаарт/

## **2. МОНГОЛЫН БА ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ:**

### **ТҮҮХЭН ҮЙЛ ЯВЦ, СУРГАМЖ, ДҮГНЭЛТҮҮД**

/2002 оны 8 дугаар сард Улаанбаатар хотноо болсон Монголч эрдэмтэдийн 8 дугаар их хуралд тавьсан илтгэл/

This paper reflects the results of the study of implementation processes of the concept “Sustainable Development”, which is the new comprehension of the humanity in coherence with historical and logical connections. The key principles of the sustainable development are reflected in the “Concept of national security”, the “Concept of national development”, the “Program for human security and good governance” and the “Concept for regional development” of Mongolia. Mongolian Action Programme (MAP)-21 is the most significant strategic document for the development of Mongolia, which was approved by the government of Mongolia in 1998 and corresponds with the tendencies of global sustainable development. In process of implementing of MAP-21, there are emerging many economic, social and environmental issues in Mongolia, which are reflections as part of global problems of the world. The author recommended number of policy measures to resolve the emerging problems.

**Оршил:** Дэлхий дахины ухаант хүн ард жирийн нэгэн хөгжлийн тухай бус тулхтай хөгжлийн талаар зөвлөн ярилцаж эрдэм ухааныхаа дээж бүхнийг энэ үйлсэд зориулах боллоо.

Улс орны хөгжлийн төвшинг зөвхөн эдийн засгийн өсөлтөөр хэмждэг хандлагаас хүн, байгаль орчин, нийгэм-эдийн засгийн хүчин зүйлийг цогц байдлаар харилцан хамааралтай авч үздэг тулхтай хөгжлийн шинэ хандлага руу хүн төрөлхтөн шилжин ороод 10 жил болж эхний үр дүнгээ энэ 8-р сарын эцсээр Өмнөт Африкт эхлэх Төр Засгийн Тэргүүн нарын Дээд Хэмжээний Уулзалтаар нэгтгэн дүгнэх юм. Энэхүү Уулзалтын бэлтгэл чуулганууд Нью-Йорк хотноо 3 удаа, Индонезийн Бали хотод нэг удаа болж сүүлчийн 3 чуулганд нь биечлэн оролцох үедээ дэлхийн хүн ард цэнхэр гаригаа хамгаалан хөгжихийн төлөө хэрхэн хамтран ажиллаж байгааг нүдээр үзэж биеэр мэдэрсэн билээ. Иймээс би илтгэлдээ хүн төрөлхтний шинэ ухаарал болсон тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг манай улсад болон даян

дэлхийд хэрэгжүүлж ирсэн үйл явцыг түүхэн ба логик уялдаа холбоонд нь авч судалсан үр дүнгээ тусгаж байна.

**Даян дэлхийн баримтлал Монгол хөрсөн дээр:** Монгол орон хүн төрөлхтний жам ёсны хөгжлийн гольдролын гадна үлдээгүй юм.. Даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг Монгол улс цогцоор нь хүлээн авч УИХ-аар 1994 онд "Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал", 1996 онд "Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал", 2001 онд "Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр", "Бүсийн хөгжлийн үзэл баримтлал"-уудыг тус тус батлан гаргаж, тэдгээрт дэлхий дахины XXI зууны тогтвортой хөгжлийн түгээмэл чиг хандлагыг ерөнхийдөө тусгасан билээ. Монгол улсын Засгийн газраас 1998 онд сайшаасан "Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр" нь эдийн засгийн өсөлт, нийгмийн тэгш байдал, байгаль орчны зүй зохистой ашиглалтыг нэгдмэл байдлаар тодорхойлсон, дэлхий тогтвортой хөгжлийн түгээмэл хандлагад бүрэн нийцсэн хөгжлийн стратеги болсон юм. Энэхүү хөтөлбөр нь НҮБХХ-ийн "Чадавхи 21" сангийн тусламжтайгаар боловсруулагдаж, үндэсний болон орон нутгийн түвшинд хэрэгжиж эхэлснээр 3-4 жилийн нүүр үзэж байна.

**Даян дэлхийн тогтвортой хөгжил ба Монгол:** Байгаль орчны даац, цаг уурын өөрчлөлтөд нийцүүлэн хүн ардынхаа амьдралыг баталгаажуулахын зэрэгцээ эдийн засгаа хөгжүүлж, нөөц баялгаа шавхалгүйгээр байгаль дэлхийгээ унаган төрхөөр нь хойч үедээ өвлүүлэн үлдээх нь тулхтай хөгжлийн тулгуур зарчим юм. Нийгэм, эдийн засгийн хөгжилтэй холбоотойгоор хүн төрөлхтөнд нааштай олон ахиц гарсан хэдий ч хүн амын өсөлт, хотжих үйл явц, орчны бохирдол, амьдралын хүчин зүйл, шинжлэх ухаан, техник технологийн хөгжлийн өндөр хурдацаас шалтгаалан дэлхий ертөнцийн унаган төрх алдагдсаар байна. Тухайлбал, дэлхийн гол мөрний тэн хагас нь ноцтой бохирдсон буюу ширгэж алга болжээ. Дэлхийн хамгийн том гэгдэх 227 гол мөрний 60 хувь нь далан болон инженерийн бусад байгууламжуудаар таслагдаж, энэ нь хүнс, цахилгаан хангамжийг нэмэгдүүлж байгаа боловч намгархаг газар, бусад эко тогтолцоонд эргэж буцалтгүй хохирол үүсгэж байна. Ази, Африкийн орнуудад ойролцоогоор 1,1 сая хүн ундны цэвэр усаар гачигдаж 2,4 сая хүн ариун цэврийн боловсон үйлчилгээнд хүрэх боломжгүй байна.

Рио де Жанейро хотноо "Хөгжил ба орчин" сэдвээр хуралдсан НҮБ-ын чуулганаас хойших 10 жил нь хүн төрөлхтний хувьд хөгжлийн шинэ хандлага, үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлэх, улс үндэстэн бүр өөрийн орны онцлогт зохицуулан Тулхтай хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлэх ажилд шуурхайлан орсон он жилүүд байлаа. Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг ЗГ, ТББ, Иргэний нийгмийн оролцоотой зохион байгуулдаг удирдлагын өвөрмөц хэлбэр-Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл /ТХҮЗ/ дэлхийн 100 орчим оронд байгуулагджээ. Үндэсний хэмжээнд болон орон нутгийн төвшинд хэрэгжүүлж буй үйл ажиллагааны далайц, өвөрмөц шинж байдлаараа Монгол

улсын Тогтвортой Хөгжлийн Үндэсний Зөвлөл Ази болон дэлхий дахинд зохих хүндэтгэлийг хүлээгээд байгаа юм. Нөгөөтэйгүүр, нүүдэлч Монголчууд байгальтайгаа олон мянган жилийн турш зохицон амьдарч ирсэн хэдий ч социализм ба зах зээлийг туршиж ирсэн сүүлийн 80 жилд онгон байгаль, газар нутаг маань ихэд талхлагдсаныг баримт гэрчилж байна. Жишээ нь, Манай орны ой нь нийт нутаг дэвсгэрийн дөнгөж 8,1 хувийг эзэлдэг бөгөөд ойн түймэр,алсын хараагүй мод бэлтгэл, хортон шавьжийн хөнөөл зэргээс болж экосистемийн тэнцвэрт байдал алдагдан сүүлийн 25 жилд 1,6 сая га устаж үгүй болсон байна. Бас сүүлийн жилүүдэд 400 гаруй гол горхи ширгэж алга болсныг БОЯ тогтоосон нь анхаарал татаж байна.

Монголын малчид нүүдэлчин амьдралын хэв маягаа хадгалан үлдэж зардал хамгийн бага шаардах, байгаль орчинтойгоо зохицсон аж ахуй эрхэлж хэрэглээгээ өөрийн үйлдвэрлэлээр үндсэнд нь хангадаг. Гэвч нөгөө талаар өнөөгийн даяарчлал, зах зээлийн нөлөө, дэлхийн цаг уурын өөрчлөлт нүүдэлчин малчдын амьдралд хүндээр тусаж давхар давхар бэрхшээлүүдийг үүсгэж байна.

Тухайлбал:

1. Мал хувьчлалын дүнд малчдын ихэнх нь цөөн тооны малтай, билчээр ашиглах уламжлалт технологийн дадлага туршлагагүй өрхүүд болон задарсны зэрэгцээ төв рүү тэмүүлэх хөдөлгөөн өрнөж Төв аймаг болон бусад суурин газруудад малын тоо билчээрийн даацаас хэтрэх хандлагатай болсон байна. Энэ нь экологийн тэнцвэрийг алдагдуулах нэг шалтгаан болж байна.
2. Малчдын хамтарсан амьдралын хэв маяг, түүхий эд бэлтгэл, барааны хангалтын улсын төвлөрсөн систем задарч түүнийг орлох шинэ механизм бүрэлдээгүйгээс малчдын амьдрал үндсэндээ тусгаарлагдмал, тархай бутархай, хөрөнгө мөнгөний дутагдалтай болсон байна.
3. Дэлхийн цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан байгалийн гамшигийн давтамж, түүний үзүүлэх хор уршиг улам нэмэгдэж байна.

Энэ мэтээр дэлхий дахинд нүүрлээд байгаа тогтвортой бус хөгжил Монголд нэгэн адил бүр түүнээс ч хурцаар тавигдаж байгааг судалгаа нотолж байна. Энэ бүхнийг даван туулах үндсэн арга нь Монгол орны тулхтай хөгжлийг даян дэлхийн тогтвортой хөнжлийн гольдролд нийцүүлэн хөгжүүлэхэд оршино. Энэ талаар бид чамгүй арга туршлага хуримтлуулаад байгаа билээ.

Бодит амьдралд хүндрэл бэрхшээл учирч байгаа боловч "Монголын тогтвортой хөгжлийн хөтөлбөр" нь бусад стратегийн баримт бичигтэй харьцуулахад дараах давуу талтай болно. Үүнд:

- Хөтөлбөр нь доороос дээш зарчмаар, олон нийтийн хүсэл сонирхлыг нэгтгэн оролцооны аргаар боловсруулагдсан тул бодит амьдралд тулгуурлаж, зорилтуудаа оновчтой тодорхой тодорхойлж чадсан болно.
- Байгаль орчныг зүй зохистой ашиглах, хамгаалах асуудлыг чухалчласнаараа өнөө үеийн дэлхий нийтийн шаардлагад нийцсэн болно.
- Энэ хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлсэн үйл явц засаглалын залгамж чанарыг хадгалж байгаагаараа нэн өвөрмөц юм. Угаас дэлхий дахины эрүүл саруул сэтгэлгээний үр дүн болж үүссэний хувьд ийм байхаас ч өөр аргагүй юм.

Монгол улс 2002 онд НҮБ-ийн тогтвортой хөгжлийн комиссын гишүүн орон болсон нь Монгол орны олон улсын нэр хүнд өссөний бодит баталгаа болсон юм.

**Тогтвортой хөгжил хөтөлбөрийн хэрэгжилт, сургамжууд:** Хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээг үндэсний хэмжээнд болон Увс, Архангай, Дорноговь, Сүхбаатар аймгууд, Улаанбаатар хотыг хамруулан хийх ажлыг 2002 оны эхний хагас жилд багтаан гүйцэтгээд байгаа билээ. Эндээс дараах урьдчилсан дүгнэлт гарч байна. Үүнд:

1. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх 11 чиглэлийн дотор тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн гол 6 зорилтыг багтаасны зэрэгцээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилтуудын 80 гаруй хувь нь туссан учраас ирээдүйд чиглэсэн хөтөлбөртэй ажиллаж байна гэж үзэх үндэстэй юм.
2. Салбарын үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөнд тогтвортой хөгжлийн зорилтуудыг тусган хэрэгжүүлж байгааг СЭЗЯ, ҮХЯ, ДБЯ, БОЯ, НХХЯ, ЭМЯ, БСШУЯ, ГХЯ, ХХААЯ-ны үйл ажиллагааны үндсэн чиглэл, хөтөлбөр, төлөвлөгөөнөөс харж болохоор байна.
3. Засгийн газраас дэмжин хэрэгжүүлж байгаа томоохон хөтөлбөр, төслүүд, тухайлбал, хуучнаар ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, одоогийн Өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх хөтөлбөр болон эдийн засгийн өсөлтийг хангах, ядуурлыг бууруулах, боловсрол, эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах, үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, Монгол улсын хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр зэрэг нь тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй ямар тодорхой хэмжээгээр уялдсан байна.
4. Аймгийн Засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт тухайн аймгийн тогтвортой хөгжлийн зорилтуудын 50 гаруй хувь нь тусгагдан хэрэгжиж байна. Ялангуяа Засаг дарга нар өөрсдийн дунд хугацааны мөрийн хөтөлбөрөө боловсруулахдаа уг хөтөлбөрт тулгуурласан нь орон нутгийн хөгжлийн хандлагыг зөв чиглүүлэхэд чухал үр дүн өгч байна.

Үйл ажиллагааны ололт байгаа боловч цаашдын хөгжилд анхаарах шаардлагатай олон асуудал байгааг хөтөлбөрийг хэрэгжүүлсэн 3 жилийн туршлага харуулав. Үүнд:

- Өнөөдөр манай оронд хөгжлийн асуудлаар олон байгууллага, хүрээлэнгүүд ажилладаг боловч үйл ажиллагаагаа зохицуулах талаар бага анхаарч ажиллаж байна.

- Ядуурал, ажилгүйдэл дорвитой буурахгүй, нэг хүн амд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ өсөхгүй байна. Экспортод олборлох аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, мал аж ахуйн түүхий эд зонхилсон хэвээр байна.

- Байгаль орчны асуудал ч ихээхэн бэрхшээлтэй байна. Зуд, ган гачиг байнга тохиолдож байгаа нь байгаль цаг уураас гадна зарим тохиолдолд орон нутгийн удирдлага, зохион байгуулалт, хүмүүсийн өөрсдийн үйл ажиллагаанаас хамаарч байна.

- Төвлөрлийг сааруулах, нутгийн өөрөө удирдах ёсыг хэвшүүлэх явдал тун хангалтгүй, тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилтуудыг бүх түвшний жил бүрийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, хөтөлбөр төсөл, төсөвт тусган хэрэгжүүлэх, биелэлт үр дүнг нь тооцох ажил шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

**Монголын тогтвортой хөгжлийн зорилтууд:** Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт үндэсний болон орон нутгийн хэмжээнд ид эхлэлтийн шатандаа байгаа өнөө үед өмнөх туршлагадаа тулгуурлахын хамт сул талаа даван туулж байнга өөрчлөгдөн байгаа дэлхий нийтийн тулхтай хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн шуурхай ажиллах шаардлагатай боллоо. МХ-21 ийг санхүүгийн хувьд дэмжиж ирсэн "Чадавхи 21" сангийн зарчим, туршлага, амжилтад тулгуурлан "Чадавхи 2015" сан шинээр үйл ажиллагаагаа эхлээд байгаа билээ. "Чадавхи 2015" сан нь хөгжиж байгаа болон шилжилтийн орнуудад 21-р зууны тогтвортой хөгжлийн зорилт, мянганы зорилтыг хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэх ерөнхий зорилготой юм. Иймээс "Чадавхи --2015" сангай хамтран ажиллахын тулд цаашдын зорилгоо нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. "Чадавхи-2015" сангаас дэмжлэг авахыг хүссэн орнууд түүний зарчмуудыг зөвшөөрч дэмжэх шаардлагатай байдаг. Зарчмуудыг дурдвал :

- Орон нутгийн болон үндэсний хэрэгжүүлэгчид нь хэрэгцээгээ өөрсдөө тодорхойлж, түүнийг хангах асуудлыг мөн өөрсдөө шийдэх замаар сангийн тусламжид өөрсдөө эзэн нь болох.
- Чадавхийн хөгжлийг шилжилтийн үргэлжилсэн үйл ажиллагааны явц болгох .
- Тулгамдсан богино хугацааны ядуурал болон тогтвортой хөгжлийн урт хугацааны асуудлуудыг бие биенээс нь салангид шийдвэрлэх боломжгүй тул тэдгээрийг хооронд нь нягт уялдуулан шийдвэрлэх.
- Нийгэм, эдийн засаг, байгаль орчны бодлого, бодит үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих асуудлыг шийдвэрлэхэд иргэний идэвхтэй оролцоог чухалчлан үзэх.

- Нийгмийн бүлэг, улс орон бүрийн тогтвортой хөгжлийн тэргүүлэх чиглэлийн өөр өөр зорилтуудыг онцгойлон авч үзсэн, нийтлэг, гэхдээ уян хатан арга хэрэгслийг хэрэглэх.
- Мэдлэг эзэмших сүлжээний үүрэг ролийг онцгойлсон түншлэл, стратегийн холбоод байгуулах замаар үйл ажиллагаагаа явуулах.
- Чадавхи хөгжүүлэхэд бүх түвшний зайлшгүй шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх явдлыг хамааруулах.
- Байгаа чадавхийг орлуулах бус, хөгжүүлэх.
- Соёлын үнэт зүйлс, хувь хүний соёлыг хүлээн зөвшөөрч хүндэтгэн үзэх.

Эдгээр зарчмууд нь Монгол улсын тогтвортой хөгжлийн цаашдын алхамд чухал ач холбогдолтой юм.

Тогтвортой хөгжлийн үйл хэргийг цаашид тууштай үргэлжлүүлж амжилтад хүрэхэд дараах асуудлуудад анхаарч ажиллах нь зохистой байна. Үүнд:

- Үндэсний хэмжээнд Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн үзэл санааг хүлээн зөвшөөрөх үүднээс Улсын Их Хуралд төрөөс Тогтвортой хөгжлийн талаар баримтлах бодлогыг боловсруулан оруулж батлуулахын хамт Монгол улсын Ерөнхийлөгч зарлигаараа Засгийн Газарт үүрэг болгосон 2020 он хүртэл улсаа хөгжүүлэх хөтөлбөрийг тулхтай хөгжлийн баримтлалд тулгуурлан боловсруулах.

- Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгдсэн бодлого, удирдлага, зохион байгуулалтаар хангах, хариуцлага тооцох, хэрэгжилтийг хангах арга механизмыг тогтоох, салбарын уялдаа холбоог сайжруулах, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлж дүгнэх, хөгжлийн асуудлыг нэг мөр зангидан зохицуулах үүргийг тодорхой байгууллагад хариуцуулах шаардлагатай байна. Ялангуяа, бүх түвшинд хэрэгжиж байгаа санхүүжилт, хөрөнгө оруулалт, зээл тусламжийн асуудлуудыг нэг мөр төвлөрүүлэн зохицуулах, бүсийн болон аймгийн удирдлагын хэвтээ тогтолцоог бэхжүүлэх, төвлөрлийг эрс сааруулж орон нутгийн удирдлага зохион байгуулалтын эрх хэмжээ, санаачлагыг өрнүүлэх, аймаг, салбарын удирдлага хоорондын үйл ажиллагааг уялдуулах хэрэгтэй байна. Ийм учраас Монгол улсад тогтвортой хөгжлийг гүнзгийрүүлж, дэмжих зорилготой, сургалт, удирдлагаар нэгэн зэрэг хангах үүрэг бүхий Тогтвортой хөгжлийн Газар буюу хүрээлэнг байгуулах асуудлыг шийдвэрлэж үйл ажиллагааг нь эхлүүлэх хэрэгтэй байна.

- Монгол улсын Тогтвортой хөгжлийн Үндэсний Зөвлөл, Монгол улсын Засгийн газар тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн зорилтуудыг улам тодорхой болгон, өнөөгийн хөгжлийн байдал, бусад хөтөлбөр, төслийн үйл ажиллагаатай уялдуулан тодотгол хийх зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал, олон улсын нийгэм, эдийн засаг, байгаль орчны салбар дахь хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд ихээхэн эрчимжиж, энэ чиглэлээр олон тооны хөтөлбөр төсөл хэрэгжиж байгаа нөхцөлд энэ асуудал нэн чухал юм.

- Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн үйл ажиллагааг дотооддоо идэвхижүүлэх, сургалт сурталчилгааг үр дүнтэй зохион байгуулах, олон нийтэд тогтвортой хөгжлийн боловсролыг системтэй олгох, аливаа үйл ажиллагаанд хөгжлийн хэтийн хандлага үр дүнг харгалзах, олон нийтийн хяналттай болох явдал чухал байна.

- Тогтвортой хөгжлийн асуудлаар олон улсын байгууллагага, бусад орнуудтай хамтран ажиллах чиглэлийг тодорхой болгох шаардлагатай байна. Бид чадавхи-2015 сангийн хүрээнд хамтран ажиллах чиглэлээ боловсруулж байгаа бөгөөд уг үйл явцын чухал эхлэл болно.

Энэ оны 8-р сарын эцсээр Өмнөт Африкт эхлэх даян дэлхийн дээд хэмжээний уулзалтын зорилго нь нэгдүгээрт дэлхий нийтээрээ хүн төрөлхтний амьдралын хэв маягийг бодитойгоор өөрчлөх тогтвортой хөгжлийн замыг тодорхойлогч тодорхой, бодитой хэрэгжилтийн төлөвлөгөөтэй болох, хоёрдугаарт, засгийн газар, олон улсын байгууллагууд, гол бүлэглэлүүд тодорхой үйл ажиллагааны хамтын түншлэлийг бий болгох явдал юм. Монголчууд бид бүхэн энэ чуулга уулзалтыг Монгол улсын цаашдын хөгжлийн гол гарц болгон ашиглах стратегийн зорилтыг тавьж байгаа билээ.

### **3. ТУЛХТАЙ ХӨГЖИЛ БА НҮҮДЭЛЧ МАЛЧИД**

/2002 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо болсон

«Зах зээлийн эдийн засаг - Нүүдэлчин малчид - Технологи» онол практикийн бага хуралд тавьсан илтгэл/

Хамтран зохиогч: А.Баярмаа

1.

Хүн байгалийн хуулийг танин мэдэж, түүний тусламжтайгаар хүчирхэг техник технологи зохион бүтээснээр эдийн засгийн хурдац эрчимжин , хүн , байгаль орчны харьцаанд өөрчлөлт орж хүн төрөлхтөн байгалийг эрхшээлдээ оруулах гэсэн ойлголт түгээмэл болсон. Байгальтай харьцаж буй энэхүү харьцаа нь цаашдаа хүн төрөлхтнийг мөхөлд хүргэж болзошгүй болоод байна. Энэ бол хүн төрөлхтний соёл иргэншлийн 5000 гаруй жилийн түүхэн үр дагавар юм. Чухамхүү энэ хөгжлийн төлөв нь хүн төрөлхтнийг хүрээлэн буй орчинтойгоо ухаалгаар харьцах, байгаль хүн хоёрын оршин тогтнолын зохистой харьцааг баталгаажуулсан тулхтай хөгжлийн замд шилжин орох зайлшгүй шаардлагатай байгааг харуулж буй юм.

1992 онд Рио де Жанейро хотноо "Хүн ам ба хөгжил" сэдвээр хуралдсан НҮБ-ын бага хурлаар тулхтай хөгжлийн үзэл баримтлалыг дэлхий дахинаа тунхаглан зарласан билээ. Сүүлийн 10-аад жилд хүн төрөлхтний хөгжил, соёл иргэншилд бий болсон сөрөг байдал нь хүрээлэн буй орчноо хамгаалан хөгжих тулхтай хөгжлийн замыг сонгохоос өөр хувилбар байхгүйг тодорхой нотолж байна.



Хөгжлийн асуудал нь маш өргөн хүрээтэй бөгөөд тулхтай хөгжлийн үзэл баримтлалын дагуу хүрээлэн буй орчин, нийгмийн болон эдийн засгийн хөгжлийг цогцоор уялдуулан хөгжүүлж чадсан цагт дэлхий нийтээрээ урт удаан хугацаанд оршин тогтнох нөхцлийг бүрдүүлж чадах юм.

Хүн төрөлхтний ойрын ирээдүйн зорилт бол тулхтай хөгжлийн тухай ойлголтыг улс орон бүр тодорхой ажил хэрэг болгож, амьдралын зохистой хэлбэрт шилжих явдал болоод байна.

Өнөөдөр дэлхий нийтээрээ тулхтай хөгжлийн чиглэлээр олсон ололт амжилт, саад бэрхшээл, сургамжийг дүгнэн дэлхийн өмнө хүлээсэн үүргээ тайлагнах цаг нэгэнт болоод байна Иймээс ч 2002 оны 8-р сард Дэлхийн дээд хэмжээний уулзалтыг Африкийн Иоханнесбург хотноо зохион байгуулахаар төвлөсөн юм. Дэлхийн энэ түүхэн үйл явцыг угтсан чуулга, уулзалтуудыг тив бүрд хийж, улмаар Нью Йорк хотноо НҮБ-ын тулхтай хөгжлийн бэлтгэл хорооны чуулга уулзалт 2 дахь удаагаа зохиогдоод байна.

Өнгөрсөн онд Дэлхийн дээд хэмжээний чуулганыг уган Ази ба Номхон далайн улсуудын байгаль орчин ба хөгжлийн талаар Сайд нарын 4 дэх удаагийн уулзалтыг Япон улсад, Зүүн хойд Ази, Өмнөд Номхон Далай, Төв Ази, Зүүн ба Зүүн өмнөд Азийн бүсчилсэн 5 удаагийн бэлтгэл уулзалт , 2 удаагийн бүсийн дугуй ширээний ярилцлага, тулхтай хөгжлийн үнэлгээний асуудлаархи Понемфений уулзалт, энэ онд Банконгийн бүсийн уулзалтыг зохион байгуулан тулхтай хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, бүсийн тулхтай хөгжлийн тэргүүлэх талбарууд, олсон ололт амжилт, алдаа дутагдал сургамжийг нэгтгэн дүгнэж, бүсийн тулхтай хөгжлийн илтгэлийн төслийг хэлэлцэн дүгнэсэн байна. Дээрхи бүсийн уулзалтуудад Монгол улсын төлөөлөгчид оролцон өөрсдийн илтгэлийг хэлэлцүүлсэн бөгөөд Монгол улсын Тогтвортой хөгжлийн Үндэсний зөвлөл түүний бүтэц үйл ажиллагааны талаар тавьсан илтгэл олны анхаарлыг татсан бөгөөд Азийн болон дэлхийн хөгжиж буй орнууд Монгол улсад тулхтай хөгжлийн үйл явцыг удирдаж буй туршлагыг ихээхэн сонирхох боллоо.

Тухайн улс орон бүрийн тодорхой нөхцөл байдлаас шалтгаалан хөгжлийн үйл явцын ерөнхий зүй тогтлууд өвөрмөц байдлаар илэрдэг. Иймээс ч Монгол улс өөрийн өвөрмөц онцлогт нийцүүлэн Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө боловсруулан, хэрэгжүүлэх ажлаа эхлээд даруй дөрвөн жил болоод байна. Мөн түүнчлэн аймаг бүр өөрийн тулхтай хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх шатандаа ажиллаж байна. Саяхнаас Зүүн бүсийн тулхтай хөгжлийн хөтөлбөр боловсруулах ажил эхлээд байна. Энэ хөтөлбөрийг боловсруулснаар Монгол улс, үндэсний болон аймгуудын хөтөлбөртэй төдийгүй бас бүсийн хөтөлбөртэй орон болж, дэлхий дахины тогтвортой хөгжлийн үйл явцын удирдлагад өөрийн хувь нэмрийг оруулах юм. Нью Йорк хотноо НҮБ-

ын тулхтай хөгжлийн бэлтгэл хорооны 2 дахь удаагийн чуулга уулзалт болж Монгол улсаа төлөөлөн 21-р зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн Үндэсний зохицуулагч оролцоод ирсэн билээ.

Тулхтай хөгжил хийгээд түүний үзэл баримтлалыг Монгол хөрсөн дээр хэрэгжүүлэхэд нүүдэлчин малчид ,нүүдлийн соёл иргэншлийн өнөө ирээдүйг заавал харгалзан үзэх учиртай. Нүүдлийн мал аж ахуй болон түүнтэй холбоо бүхий нүүдлийн амьдралын хэв маяг нь хүн төрөлхтний нийгмийн оршин тогтнох нэг хэлбэр маяг юм.

Тогтвортой төлөв аль эртнээс нүүдлийн соёл иргэншлийн замналыг чиглүүлэгч болон үйлчилсээр байсныг дурьдах хэрэгтэй. Нүүдлийн амьдралын хэв маяг газар зүй, байгаль орчин ,цаг агаарын нөлөөлөл асар их байдаг. Үүнийг нь нүүдэлч малчид хэдэн зуун жилийн өмнөөс мэдэж аж ахуйгаа түүнд зохицуулан эрхэлж ирснээр барахгүй энэ талаар цэгцтэй сургааль ном боловсруулж, эзэмшиж иржээ. Үүний нэг жишээ нь 1797- 1887 онд амьдарч байсан Сэцэн хан аймгийн Тогтохтөр ван буюу То вангийн аж төрөх ухааны сургааль юм. Тэрээр 11 зүйлт сургааль айлдсан байдгийн 10-11-р зүйлд мал маллагааны арга барилын талаар өгүүлжээ. Тэрээр бэлчээрийг жигд нямбай ашиглах, малыг зөв услах явдлыг онцгой анхааран аль болох олон нүүдлэхийг сануулсан байна.

Нүүдлийн соёл иргэншлийн оршин тогтнох чадвар нь байгаль орчинтойгоо зохицон амьдрах , байгалийн сүр хүчийг бишрэх далд оюун ухаанд оршиж байдаг. Нүүдэлчид түүхэн хөгжлийнхөө ихэнх үед тогтвортой зарчмын ойлголтын совингоор амьдарч ирсэн. Нүүдлийн амьдрал нь байгалийн өөрчлөгдөн буй нөхцөлд зохицох арга болж үүсээд мөн тэрхүү зохицлын үндсэн дээр зуун зууныг илээсэн билээ. Нүүдлийн амьдралын хэв маяг нь хэдийгээр газар зүйн зохистой орчин, хүрээлэн буй байгаль орчинтой үлэмж холбоотой боловч уг чанартаа эдийн засгийн хөгжлөөр нөхцөлдсэн байна. Нүүдлийн мал аж ахуйн үндэс нь малыг адгуулах, үржүүлэх бэлчээр нутагтай салшгүй холбоотой юм. Нүүдлийн мал аж ахуй эрхлэхэд мал нь дангаар бус бэлчээртэй хослож байж үйлдвэрлэлийн хэрэгсэл болох юм. Бэлчээр, түүний даацын асуудал нь нийтийг хамарсан тулгамдсан шинжтэй болж ,мал аж ахуйн салбарын удаан хугацааны тогтвортой байдлыг хангаж чадахгүй болоод байна. Малын ашиг шим, бүтээгдэхүүний чанар, үүлдэр угсаа буурах хандлагатай болж байгаа бөгөөд малын тоог ихэсгэх замаар орлогоо нэмэгдүүлэх гэсэн оролдлогоос болж бэлчээр ашиглах нүүдлийн уламжлалт сайн технологи алдагдаж, экологийн тэнцвэр алдагдан, ургамлын бүтцэд өөрчлөлт орон, цөлжилт хурдсаж байна. Ганцхан жишээ дурьдахад 1990-ээд оны эхээр Баянхонгор аймаг 300 мянган ямаатай байсан ба сүүлийн 10 жилд энэ тоо 4 дахин өсөж 1,2 саяад хүрсэн нь малчдын амжиргаа дээшилэхэд чухал хөшүүрэг болсон ч бэлчээр ихээхэн талхлагдаж, цөлжилт эрс хурдацтай нэмэгдэж, сүүлийн

2 жилд тус аймагт зуд турхнаас салсангүй. Үүний дээр зээргэнэ, чихэр өвс түүж ашиг хөөцөлдөгчдийн үйл ажиллагаа том нэрмээс болсон.

Уламжлалт мал аж ахуй нь хэд хэдэн өрх айл хамтран буудалж, нэгэн хот айл болон малаа ээлжлэн хариулах заншилтай байсан. Өнөөдрийн өрхийн аж ахуйн тархай бутархай зохион байгуулалт нь нийгмийн үйлчилгээ хүртэх, байгалийн болон бусад эрсдлийг даван туулахад хүчин мөхөсдөж, чухамдаа тулхтай хөгжлийн нийгэм, эдийн засгийн үзүүлэлт хангагдах боломжгүй байна.

Нүүдэлчдийн язгуур онцлог нь байгаль орчинтой зохицон амьдарч түүнийг хамгаалах, нөхөн сэргээх замаар амьдралын баталгаагаа хангадаг. Монголчуудын хувьд нүүдлийн соёл иргэншил нь малчин хүн мал сүргээ адгуулан түүний ашиг шимээр эдийн засгийн хэрэгцээгээ хангах, мал нь байгаль орчиндоо дасан зохицож өсөн үржиж, байгаль нь нүүдлийн соёл иргэншлийнхээ ачаар унаган төрхөө хадгалан үлдэж, байгалийн унаган төрх нь ирээдүйн малчдын болон малын хэрэгцээг хангахад чиглэсэн иргэншлийн энэхүү хэв маяг нь нүүдлийн соёл иргэншил ,мал аж ахуй тогтвортойгоор оршин тогтнох нөхцлийг бүрдүүлдэг. ХҮН - МАЛ - БАЙГАЛЬ гэсэн энэхүү бигүү цагриган хэлхээ нь нүүдлийн соёл иргэншлийн тулгуур үзэл баримтлал болох бөгөөд тулхтай хөгжлийн үзэл баримтлалд нийцэж байгаа юм Эндээс нүүдлийн соёл иргэншил ба тулхтай хөгжил гэсэн холбоо үүсэх юм. Хэрэв эдгээр цагриган хэлхээг бүрдүүлэгч үндсэн элементүүд өөрчлөгдөн үндсэн шинжээ алдвал нүүдлийн соёл иргэншил оршин тогтнож чадахгүй. Үйлдвэрлэлийн бие даасан технологи болох нүүдлэхгүй гэсэн ойлголт нь мал аж ахуйг эрхлэн хөтлөх арга ухааны бүхэл бүтэн тогтолцоо төдийгүй байгаль орчин, тухайлбал бэлчээр нутгийг хамгаалах, бэлчээрийн нөөцийг бий болгох, ургамлын төрөл зүйлийг хамгаалахад гол үүрэг гүйцэтгэж ирсэн юм.

Монгол орны эрс тэс уур амьсгалд зохицсон сүргийг бий болгох, тэдний удмын санг хадгалах, сайжруулах зэрэг селекцийн арга ухаан нь нүүдлийн мал аж ахуйн үр ашгийг сайжруулах гол арга бөгөөд нүүдлийн мал аж ахуй урт удаан хугацаанд тогтвортой оршин тогтнохын гол үндэс болж байлаа.

Нүүдлийн соёл иргэншил нь нүүдлийн мал аж ахуйгаас гадна өөр цогцолбор шинж чанаруудыг өөртөө агуулдаг. Нүүдлийн соёл иргэншил нь материаллаг баялгийг үйлдвэрлэх, хувиарлах, нийгмийн үйлдвэрлэлийг зохион байгуулах өвөрмөц арга барил, түүнд тохирсон мэдлэг ухаан, итгэл бишрэл, ёс суртахуун, гоо сайхны үзэл баримтлалыг өөртөө багтаасан тогтолцоо мөн.

Нүүдэлчдийн аж амьдрал хүрээлэн буй гадаад орчноос ихээхэн хамааралтай учраас байгаль орчныг хамгаалах, бохирдуулахгүй байх ёс заншил гүн шингэсэн байдаг. Нүүдлийн

соёлын нэгэн том хүрээ болох ардын тоглоом наадгай, дуу хуур, уран зохиолоор дамжуулан нүүдэлчдийг, тухайлбал бага насны хүүхдүүдийг нүүдлийн амьдралд бэлтгэх, хүн ба байгаль хоёрын хүйн холбоог ухамсарлуулан ойлгуулдаг, орчноо хайрлан хамгаалах сэтгэлгээг төлөвшүүлдэг байжээ. Нүүдэлчдийн гүн ухаан нь хүн ба байгаль орчныг салшгүй нэгдэл дотоод нарийн холбоонд нь авч үздэг бөгөөд сэтгэлгээний нийтлэг арга нийгэм байгаль хоёр ерөнхийдөө байгалийн нийтлэг хуулинд захирагддаг хорвоогийн зүй тогтлыг танин мэдсний илрэл юм.

Нүүдэлчид газар дэлхий дээрхи амьдралыг сансарын үзэгдэлтэй салшгүй холбоотой гэж үзэн од гаргийн хөдөлгөөн, байршлын өөрчлөлтийг судлан хүн мал болон экологид үзүүлж буй нөлөөллийг анхлан танин мэдэж байгаль цаг уурын өөрчлөлтийг газрын гадаргуу ургамал амьтны байдал, тэнгэр эрхэс, од гаригийн хөдөлгөөнөөр тамдан ажиглаж түүнд ахуй амьдралаа зохицуулан амьдарч иржээ.

Нүүдлийн соёл иргэншлийн явцад хүн байгаль, мал тэдгээрийн харилцан шүтэлцээний талаар асар их мэдээллийг хуримтлуулаад зогсоогүй тэдгээр үнэт зүйлсийг үеэс үед уламжлуулан өвлүүлэх арга болон ардын сурган хүмүүжүүлэх ёсыг бий болгосон байна. Байгаль орчинтой харьцах, эдийн засгаа эрхлэн явуулах арга ухаанд сургаж байжээ. Энэхүү ардын уламжлалт сурган хүмүүжүүлэх арга нь нүүдэлчдийн дунд тулхтай хөгжлийн үзэл баримтлалыг түгээх арга хэрэгсэл болж чадах юм.

Нүүдэлчдийн язгуурын аж төрөх ёс нь хүрээлэн буй орчин, экологийн хамгийн цэвэр нөхцөлд амьдарч, хамгийн эрүүл хоол хүнсийг хэрэглэж, элдэв халдварт өвчин тархахаас хамгаалагдсан амьдралын баталгаа сайтай чанарлаг амьдрал гэж үзэж болох юм.

Нүүдлийн соёл иргэншил нь байгаль орчин экологийн тэнцвэрт байдлыг хадгалж чадсан ч эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэж чадахгүй хэвээр байна. Малчдын тархай бутархай байдал нь нийгмийн үйлчилгээг хүргэх нэгжийн өртөгийг өндөрсгөх, үйлчилгээний чанар хүртээмж муудах сөрөг нөлөөтэй төдийгүй бүтээгдэхүүнийг боловсруулан зах зээлд гаргах, маркетингийн оновчтой стратегийг хэрэгжүүлэх, малчдын орлогыг нэмэгдүүлэх бололцоог хязгаарлаж байгаа юм. Мал аж ахуй нь хөдөлмөр их шаарддаг, хөдөлмөрийн бүтээмж багатай, улиралын шинж чанартай салбар юм. Иймээс бид Монгол улсын XXI зууны Тулхтай хөгжил хөтөлбөрийн хүрээнд олон мянган жилийн түүхтэй нүүдэлч малчдынхаа амжиргааг хэрхэн дэмжиж, даян дэлхийн тулхтай хөгжлийг дэмжигч олон улсын байгууллага, хөгжингүй орнууд, хөгжлийн сангуудтай хэрхэн холбох вэ? гэдгийг олон талаас нь судалж боловсруулах шаардлагатай байгаа юм.

Нэн даруй бүгдийг нь суурин хэлбэрийн мал аж ахуй болгох уу? эсвэл өвсний соргог усны тунгалагийг бараадан нүүдэллэн амьдарч мал аж ахуйгаа адгуулж ирсэн нүүдэлч төрхийг

нь зохих ёсоор хадгалж, холбоо харилцаа, нар салхины энерги, хатуу ба шингэн түлш зэрэг шинжлэх ухааны сүүлийн үеийн ололтод суурилсан амжиргааг нь дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж нүүдэлч малчдын ахуй орчноос улбаатай нүүдлийн соёл иргэншлээ хадгалах уу ? гэдэг асуудлын зааг дээр ирээд байна.

Нэг дэхь нь суурин соёл иргэншлийн хэв маягийг дагаж хөгжих зам, хоёр дахь нь хүн төрөлхтний өнөөгийн хөгжилд Монголын гэсэн гарцыг хадгалж, даян дэлхийн тулхтай хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулан хөгжих арга зам юм. Хүн төрөлхтөн хоёр дахь арга замыг нь нэлээн бүдүүлэг эртний хэлбэр гэж үзэх нь давамгайлж түүнд байгаа шинэ нөөц боломжийг олж харахгүй байгаа нь анхаарал татаж байна.

Иймээс бид эрдэмтэн мэргэжилтнүүдийнхээ оролцоотойгоор даян дэлхийн үзэл баримтлал, бодит үйлсийн хөгжилд Монгол малчдын нүүдлийн амьдрал дэлхийн соёл иргэншилд ямар байр суурь эзлэх учиртай, түүний ирээдүй нь ямар болох зэргийг тал талаас нь судлан боловсруулах шаардлагатай байгаа юм. Малчид, эрдэмтэдийн үнэлэлт, дүгнэлт даян дэлхийн тулхтай хөгжлийн хэтийн төлвийг тодорхойлоход нэн чухал ач холбогдолтой байгааг саяхан Нью Йорк-т болсон уулзалт тодорхой харуулж байлаа.

Малчдыг зах зээлийн харилцаанд ухаалгаар оролцуулах, мал аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийн оновчтой стратегийг хэрэгжүүлэх асуудлын зэрэгцээ газар дэлхийгээ, цэвэр тунгалаг гол мөрнөө, ургамал амьтнаа яаж хамгаалан хойч үедээ өвлүүлэх вэ ? гэдгийг давхар давхар бодолцож аж амьдралаа авч явах зорилт бидний Монголчуудад ноогдож байна. Үүнийг маркетингийн хэлээр бол ойрын болон алсын зорилт, стратегийг нягт хослуулан хэрэгжүүлж, Монгол ухаанаар бол "доороо суурьтай, дотроо бодолтой" хөдлөх гэж ойлгож болох юм.

Ашигласан материал

Ш.Нацагдорж «То вангийн сургааль» УБ 1968 он

Ж.Самбуу, Мал маллагааны арга барил .

Ц. Өөлд Хөдөөгийн хөгжлийн зарим асуудал 2001 он

Арнольд Тойнби Нүүдлийн мал аж ахуй .

#### **4. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ОЛОН УЛСЫН УДИРДЛАГА БА НҮҮДЛИЙН НИЙГЭМ**

Хамтран зохиогч: А.Баярмаа

#### **International Management of Sustainable Development and the Nomadic Society**

Today, more than 60 countries have people conducting nomadic or semi-nomadic style of life. The nomadic civilization is based on the relationship of people-livestock-

nature, and this inter-relationship is the basis concept of the nomadic civilization and corresponds to the concept of sustainable development. However, due to external and socio-economic factors, the nomadic civilization is experiencing restrictive impacts for further sustainability. A common dilemma faced by nomads is whether the nomadic society has a capability to cope with rapidly changing external environment. According to the system theory, the ability to cope with the external conditions depends on the ability of the system itself to respond adequately in terms of management and institutional reorganization. The nomadic society has been able to adapt to such transformation. As a result of impact of external factors, the nomadic life has experienced two major changes: consumption transformation and mentality transformation. The concept of sustainable development has its roots to the sedentary societies, therefore, the development of nomadic civilizations were ignored somehow. However, since the very idea of sustainable development presupposes ecologically friendly attitude and concerns, the nomadic culture qualifies fully to the pledges of the sustainable development. Management structures of sustainable development were elaborated at international, regional and national levels, which should be urgently studied and projected to the nomadic management structure. The main purpose will be to ensure an effective control, implementation and coordination.

Өнөөдөр дэлхийн 60 гаруй орны хүмүүс нүүдлийн болон хагас нүүдлийн амьдралаар амьдарч байна. Жишээлбэл, Афганистаны хүн амын 17 хувь, Ираны хүн амын 13 хувь, Саудын Арабийн хүн амын 50 орчим хувь нь нүүдлийн амьдралтай байна. Нүүдлийн соёл иргэншил нь хүн, мал, байгаль гэсэн амин холбоон дээр оршин тогтнож байдаг бөгөөд энэхүү харилцан хамаарал нь нүүдлийн соёл иргэншлийн тулгуур үзэл баримтлал болох бөгөөд тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцэж байгаа юм.

Нүүдлийн соёл иргэншил тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн хэдий ч гадаад орчны нөлөөлөлтэй холбоотойгоор тогтвортой урт хугацаанд оршин тогтнох боломж нийгэм эдийн засгийн хүчин зүйлийн нөлөөгөөр улам хязгаарлагдмал болж байна

Нүүдлийн нийгмийн тухай асуудал бол хүн төрөлхтний нийгмийн оршин хөгжих ерөнхий зүй тогтлын нэгээхэн хэсэг юм. Өнөөдөр хүн төрөлхтний нийгэм дэлхийн нэгдмэл зах зээл, нийтлэг хэрэглээний соёлоор дамжин улам харилцан хамааралтай болж байна. Нүүдлийн нийгэм цаашид оршин тогтнох эсэх нь хувьсан өөрчлөгдөж буй олон улсын гадаад орчноос ихээхэн хамааралтай бөгөөд энэхүү олон улсын гадаад орчинд нөлөөлж буй хүчин зүйлс, дэлхий нийтийн нийтлэг тулгамдсан асуудал, даяаршлын үйл явц зэрэг нь нүүдлийн соёл иргэншлийн оршин тогтнолыг тодорхойлох болоод байна. Нүүдлийн нийгэм нь хувьсан өөрчлөгдөж буй гадаад орчиндоо хэрхэн дасан зохицох вэ? гэдэг бол нүүдэлч түмний өмнө тулгамдсан нийтлэг асуудал юм.

Нүүдлийн нийгмийг нэгэн систем гэж үзвэл системийн бүтэц зохион байгуулалт нь тогтмол бус бөгөөд цаг хугацааны дагуу өөрчлөгдөж хөгжиж байдаг. Нүүдлийн соёл иргэншлийн үүсэн хөгжсөн түүх нь хүн төрөлхтний тодорхой хэсгийн дэвшилтэт хөгжлийн зайлшгүй, зүй ёсны шат болж нийгмийн материаллаг болон оюуны амьдралд үлэмж нөлөөлсөн байна.

Нүүдэлчин улс түмний нийгмийн хөгжил бүхэлдээ дээшлэх чигээр явж ирсэн боловч түүний хурдац үлэмж удаашралтай байв. Иймд нүүдэлчин малчдын ахуй амьдралд, аж ахуй эрхлэх арга барилд, тэдний нийгмийн байдалд гарч буй өөрчлөлт нь илэрхий бус байлаа. Гэвч системийн онолын хувьд авч үзвэл гадаад орчны нөлөөлөлд дасан зохицох, даван туулахын тулд систем нь өөрийн бүтэц зохион байгуулалтаа цаг хугацааны дагуу өөрчлөн хөгжих ба энэ нь системийн үйл ажиллагаанд зайлшгүй нөлөөлнө. Системийн үйл ажиллагаанд нөлөөлнө гэдэг нь тухайн системийн хөгжлийг илэрхийлж байгаа юм. Иймээс ч нүүдлийн амьдрал нь гадаад орчиндоо зохицон хувьсан өөрчлөгдөж иржээ. Энэхүү хөгжлийн түүх нь нүүдлийн амьдралын хөгжлийн хэтийн төлөвийг таамаглах боломж олгож байгаа юм.

Систем нь дотоод эсрэг талуудын нэгдэл зөрчлөөс үүсэн гарах зүй тогтлын дагуу тэнцвэрт байдлаа хадгалан оршиж байдаг. Системийн үйл ажиллагаанд өөрчлөлт гарахад үүний дагуу бүтцийг өөрчлөх хэрэгтэй болно. Нийгэм, эдийн засгийн хөгжил, гадаад орчны өөрчлөлттэй холбоотойгоор нүүдлийн амьдралд дараахи 2 өөрчлөлт гараад байгааг дурьдаж болно. Үүнд:

- Хэрэглээний өөрчлөлт
- Сэтгэлгээний өөрчлөлт

Энэхүү өөрчлөлтүүд нь нүүдлийн соёл иргэншлийн бүтэц буюу нүүдлийн амьдралын хэв маягийг өөрчлөн суурин соёл иргэншлийн элментүүдийг авч ашиглахыг зүй ёсоор шаардаг юм. Жишээ нь: холбоожуулах, эрчим хүчээр хангах, ахуйн хэрэглээг өргөжүүлэх гэх мэт.

Нөгөөтэйгүүр, байгалиа шүтэж дээдэлсэн олон мянган жил хөгжиж ирсэн нүүдэлчдийн амьдралд хадгалан үлдэх үнэт чанарууд ч багагүй байна. Нүүдлийн нийгмийн бүтэц, үйл ажиллагаа, тогтвортой оршин байх эрх ашигтай уялдаатайгаар удирдлагын хэрэгцээ гарч ирнэ. Нүүдлийн нийгмийг тодорхойлох ажиллагаа бие даасан шинжтэй болоогүй нөхцөлд нүүдлийн соёл иргэншлийн тогтвортой байдлыг хадгалах гадны орчны нөлөөллийг залж жолоодох зохицуулалт хэрэгтэй болдог.

Тогтвортой хөгжлийн болон нүүдлийн соёл иргэншлийн тулгуур үзэл баримтлалын нийцэл нь нүүдлийн соёл иргэншилд тогтвортой хөгжлийн олон улсын удирдлагын тогтолцоог ашиглах боломжийг нээн өгч байгаа юм.

Даяаршилын үйл явц гүнзгийрч олон улсын байгууллагууд, НҮБ-ын гишүүн орнуудаас энэ шууд дэмжлэг авах боломж хязгаарлагдмал хэдий ч судлан үзэх нь зүйтэй юм. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал нь суурин соёл иргэншлийн хөрсөн дээр үндэслэгдсэн учраас хүн

байгалийн тэнцвэртэй харьцааг дээдэлж ирсэн нүүдлийн соёл иргэншлийн асуудал нь анхаарлаас гадуур байгаа юм. Гэхдээ нүүдлийн соёл иргэншил дэхь эх дэлхий байгалиа дээдлэн хүндлэх харьцааг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлс болгон авч үзэж байгаа нь тогтвортой хөгжил ба нүүдлийн соёл иргэншлийн харилцан шүтэлцээг хангах шижим болж байгаа юм.

Одоо та бүхэнд олон улс, бүс нутаг, үндэсний төвшин дэхь тогтвортой хөгжлийн удирдлагын бүтэц тогтолцоо чиг үүргийн талаар танилцуулья. /Зураг 1/

### **Олон улсын төвшинд**

Бодлого боловсруулах хэрэгжүүлэхэд эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдийн нэгдэл тэнцвэржилтийн нөхцөлд тогтвортой хөгжлийн зорилтыг хангах олон улсын тогтолцоо бүрдэх юм.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн комиссын чиг үүрэг нь:

Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх тодорхой түншлэлүүдийг өргөжүүлэх , түншлэлүүдийн хоорондын зохицуулалтыг хангах

НҮБ-ын системийн доторхи тогтвортой хөгжилтэй холбоотой асуудлуудыг төлөвлөх , хэрэгжүүлэх, хяналт тавих, удирдан зохион байгуулах

Санхүүгийн нөөц, тогтвортой хөгжлийн технологи шилжүүлэх, түүнчлэн чадавхи бүрдүүлэхтэй холбоотой асуудлуудад хяналт тавих

Олон улсын төвшинд тогтвортой хөгжлийн олон талынхны оролцоог хангах

**Бүс нутгийн төвшинд:** НҮБ-ын эдийн засгийн зөвлөл ба дэд бүсүүдийн бүлгүүдийн оролцоотойгоор бүс нутгийн төвшинд тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх боломжтой. Бүс нутгийн тогтвортой хөгжлийн зөвлөл нь дараахи чиг үүргийг гүйцэтгэж байна.

Бүс нутгийн хэмжээнд тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх бодлого, төлөвлөлт хэрэгжилт, хяналтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах

Бүс нутаг дахь ТХ-ийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шинэ түншлэлүүдийг дэмжих бодит үйл ажиллагаанд чиглэсэн олон талын оролцогсдын оролцоог дээшлүүлэх

Үндэсний болон даян дэлхийн 21 дүгээр зууны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх үнэлэх

**Үндэсний төвшинд:** Улс орон бүр тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл эсвэл ижил чиг үүрэгтэй албыг байгуулан ажилладаг. Энэхүү зөвлөл нь олон талын оролцоог хангасан байх бөгөөд шийдвэр гаргах төвшинийхний оролцоог хангахад гол анхаарлаа хандуулдаг. Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл нь тухайн үндэстний хүрээнд тогтвортой хөгжлийн стратегийг тодорхойлох, чадавхи бүрдүүлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх, хяналт



тавих, салбаруудын хоорондын тогтвортой уялдааг хангах ,зохицуулах үүрэгтэй байдаг. Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн бүтэц, үйл ажиллагаа Ази тив болон орон нутгийн хэмжээнд танигдсан билээ.

Тогтвортой хөгжлийн олон улс, бүс нутаг , үндэсний төвшин дэхь удирдлагын бүтэц тогтолцоог ашиглан нүүдлийн соёл иргэншлийн удирдлагын бүтэц тогтолцоог боловсруулах судалгааны ажлыг нэн даруй эхлүүлэх шаардлагатай байна. Тогтвортой хөгжлийн олон улсын удирдлагын загвараар нүүдлийн соёл иргэншлийг удирдан зохицуулах, дэмжих үүрэг бүхий хороо эсвэл зөвлөлийг НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын дэргэд байгуулан ажиллуулах боломжийн талаар судлан үзэж тодорхой саналыг дэвшүүлэх нь зүйтэй байна.

НҮБ дахь хөгжиж буй орнуудын зөвлөлд далайд гарцгүй орнуудын бүлэг нэгдсэн зохион байгуулалтаар ажилладаг шиг нүүдэлч амьдралтай улсууд тийм бүтцийг бий болгож болно. Ийм байдлаар нүүдлийн амьдралын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, нүүдлийн амьдралын төвшинг тооцон үзэхийн тулд нүүдлийн нийгмийн удирдлага зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх, олон улс, бүс нутаг, үндэсний төвшинд бэхжүүлэх шаардлагатай болж байна. Нүүдлийн соёл иргэншлийг зохицуулах нэгдмэл удирдлагатай болох гол зорилго нь нүүдлийн нийгмийн оршин тогтнолыг баталгаажуулах, даяаршлын үр шимийг хүртэх боломжоор хангах, бодлогыг нэгтгэх, давхардлыг хязгаарлах, хэрэгжилт ба хариуцлагыг бэхжүүлэх явдал юм. Үр ашигтай удирдлагыг бий болгохын тулд дараахи асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй байна. Үүнд:

- Үр ашигтай бодлого боловсруулах, зохицуулах, хэрэгжүүлэх,хяналтыг хангах зохион байгуулалтын бүтэцтэй байх
- Бодлого боловсруулах төвшинд нүүдлийн соёл иргэншилтэй орнуудын засгийн газар, түүний салбар нэгж хэсгүүд, нүүдэлчид төдийгүй иргэний нийгмийн оролцоог дээшлүүлэх, үр ашиг ба ил тод байдлыг хангах
- Бодлого боловсруулах ба хэрэгжүүлэхэд харилцан шүтэлцээ тогтвортой байдлыг хангах
- Суурин соёл иргэншилтэй улсуудын оролцоо, тусламж дэмжлэгийг хангах үр ашигтай нэгдсэн тогтолцоо механизмтай байх гэх мэт

**5. ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТЭДИЙН VIII ИХ ХУРЛЫН «ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН АСУУДАЛД: ХҮНИЙ ХӨГЖИЛ БА ОРЧИН» СЭДВЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН ДӨРӨВДҮГЭЭР САЛБАР ХУРАЛДААНЫ ТОЙМ, ҮР ДҮН, САНАЛ, ДҮГНЭЛТҮҮД**

**Review, results, opinions and conclusions reached from 4th session  
"Sustainable Development Issues: Human Development and Environment"  
at 8th International  
Congress of Mongolists**

The 8<sup>th</sup> International Congress of Mongolists was being convened under the Patronage of N.Bagabandi, President of Mongolia, 5-11 August 2002 in Ulaanbaatar. One specific goal of this Congress was to listen the view points of international and Mongolian scientists in a special session of International Congress of Mongolists on Problems of Mongolian Sustainable Development: Human Development and Environmental Factors during the waves of sustainable development concepts in the world. In the session "Problems of Mongolia's sustainable development" discussed the results of researches and reports of 21 foreign and 30 Mongolian scientists. The research papers represent various aspects of Mongolia's sustainable development on the basis of historic documents and sources including the practical implementation of sustainable development concepts and the hundreds of years historic traditions of Mongolian people in adapting to the nature and environment. The author who was chairman of this special session summarized the conclusions and recommendations of the session.

Олон улсын Монголч эрдэмтэдийн VIII Их хурлыг зохион байгуулсан байгууллага хамт олон хувь хүн бүрт ялангуяа Монгол улсын Ерөнхийлөгч өөрийн ивээлд зохион байгуулж буй явдалд гүн талархалаа илэрхийлэхийг би хүсч байна

Олон орны эрдэмтэн мэргэд Монгол улсын түүх, соёл, хэл, нүүдлийн амьдралын хэв маяг, уламжлалт ёс заншил зэрэг өргөн хүрээтэй сэдвээр өөрсдийн бүтээл, судалгааны ажлаа танилцуулан харилцан санал бодлоо уралдуулахаар хуран цугладаг уламжлал тогтоод эдүүгээ 8 дахь удаагаа Улаанбаатар хотноо цуглаад байгаа билээ.

Дэлхий дахинаа тулхтай хөгжлийн үзэл баримтлалаар давалгаалж буй энэ түүхэн өдрүүдэд олон улсын Монголч эрдэмтдийн их хурлын нэгэн салбар хуралдааныг Тулхтай хөгжлийн чиглэлээр хуралдуулан олон улсын болон монголынхаа эрдэмтэн мэргэдийн санаа бодлыг сонсох болсон нь энэ удаагийн их хурлын нэгэн өвөрмөц онцлог болж байна.

Тулхтай хөгжлийн салбар хуралдаан нь Монгол улсын хөгжил дэвшлийн цаашдын хувь заяанд өөрийн хувь нэмрээ оруулан, энд хуран цугласан эрдэмтдийн судалгааны үр дүн, онолын үзэл баримтлал нь Монголын цаашдын хөгжлийн суурь болон амьдралд хэрэгжинэ гэдэгт гүнээ итгэж байгаагаа илэрхийлье.

Тулхтай хөгжлийн салбар хуралдаанд гадаадын 21, монголын 30 гаруй эрдэмтэд өөрсдийн илтгэл, судалгааны үр дүнгээ танилцуулан хэлэлцүүлээ. Эдгээр илтгэлүүдэд Тулхтай хөгжлийн асуудлыг олон талаас нь авч үзсний зэрэгцээ Монгол улсад тулхтай хөгжлийн үзэл санаа амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа, Монголын ард түмэн байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн олон зуун жилийн түүхэн уламжлалын талаар түүхэн баримт, эх сурвалжид үндэслэсэн судалгаа шинжилгээний бүтээлээ толилууллаа.

Тус хуралдаан нь зохион байгуулалтын хувьд оновчтой болж, эрдэмтэд мэргэд өөрсдийн санал бодлоо чөлөөтэй солилцох бололцоотой, бүтээлч, нээлттэй болсныг онцлон хэлмээр байна.

Тус хуралдаанаар хэлцэгдэж буй илтгэлүүд нь байгаль орчин, эдийн засаг, нийгмийн асуудлыг бүхэлд нь хамарч байгаагаараа олон улсын Монголч эрдэмдийн анхаарлыг зүй ёсоор татаж байна. Ингээд эрдэмдгийн дэвшүүлж хөндөн тавьж буй гол гол санаануудаас та бүхэнд толилуулья.

Академч Ж.Амарсанаа Чингис хааны эрх зүйн номлолын түүхэн хувь заяа сэдвээр илтгэл тавьж, их засаг хуульд төрийн зохион байгуулалтын талаар хэрхэн хуульчилан заасан, энэ нь өнөөгийн Монгол улсын төрт ёсонд хэрхэн тусгалаа олж байгаа талаар онцлон тодруулсан байна.

Доктор Лхашид Дэлхийн менежментэд Монголчуудын оруулсан хувь нэмэр илтгэлдээ Монгол хаадын төрөө удирдах арга ухааны талаар, энэхүү удирдлагын арга ухаанаас суралцан, төрөө хэрхэн жолоодох урлагын талаар өгүүлсэн нь эрдэмдгийн сонирхолыг ихэд татлаа.

АНУ-ын эрдэмтэн Эндикот Елизабет өгүүлэхдээ Монголын хөгжлийн үндэс нь өөрсдийн соёлын үнэт зүйлсээ харгалзан үзэх, хамгаалахад орших бөгөөд бэлчээр өмчлөх асуудалд анхааралтай хандахыг Өвөр монголын жишээн дээр тайлбарласан юм.

Японы эрдэмтэн Миуоко Шимазаки Япон, Монголын орон нутаг дахь нийгмийн хөгжлийн талаар харьцуулсан судалгааныхаа дүнг танилцуулан, байгаль орчноо шүтэж амьдрах нь хөгжлийн үндэс гэдгийг өөрийн олон жилийн судлагаа ажиглалтан дээр үндэслэн баталсан.

Академич Т.Намжим Монгол улсын нийгэм эдийн засгийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж ирээдүйн хөгжлийн хандлагыг тоймлон дүрслэхийн зэрэгцээ цаашид хөгжлийн асуудлыг зангидсан шинэ бүтцийг бий болгох саналыг дэвшүүлсэн байна.

Проф.Д.Дашцамцын тавьсан илтгэлд хөгжлийн талаархи Монголын соён гэгээрүүлэгч их эрдэмтэн Ж.Цэвээний үзэл баримтлалыг судлан үзэж, бид бүхэн өнгөрсөн үеээсээ өөрсдийн хөрснөөсөө суралцахын ач холбогдлыг харуулсан байна.

Доктор Лхүндэндорж Азийн нэгдсэн үйлдвэрлэлийн аргаас уламжилсан эрх зүйн тогтолцооны давуу талийг тодруулан гаргасан юм.

Францын эрдэмтэн Михайл Сантора – экологийн хамгийн цэвэр хүнсний бүтээгдэхүүнийг бэлчээрийн малаас бэлтгэх боломжтой гээд бэлчээрийн мал аж ахуйн давуу талыг хонины дал харуулж байж тайлбарласан нь анхаарууштай асуудлын нэг байлаа.

Эрдэмтэн Х.Гүндсамбуу- Монголыг нүүдлийн соёл иргэншлийн өлгий нутаг болгохыг НҮБ болон түүний төрөлжсөн байгууллага болох ЮНЕСКО-д уриалахыг санал болгосон.

Бусад олон эрдэмтэд Тулхтай хөгжлийн үндсэн асуудлууд болох ус, уур амьсгалын өөрчлөлт, газар газрын тухай хууль, бэлчээр, бэлчээрийн мал аж ахуй, хүрээлэн буй орчны чиглэлээр олон сонирхолтой илтгэл, чухал санааг дэвшүүлсэн тавьсан юм.

Хуралдааны үеэр эрдэмтэдийн тавьсан гол санаануудыг эмхэтгэн дараахи дүгнэлт саналыг Тогтвортой хөгжлийн салбар хуралдаанаас дэвшүүлэн тавьж байна. Үүнд:

Тулхтай хөгжлийн үзэл санаа, үйл хэргийг олон улсын Монголч эрдэмтдийн хуралд оролцогсад сонирхон, дэмжиж байгаагаа илэрхийлэхийн зэрэгцээ, хүн байгальтайгаа эвсэн амьдрах арга ухаан, харилцан шүтэлцээг дээдэлсэн, байгаль орчиндоо тулгуурласан хөгжлийн төлөө хамтран ажиллах

Монгол улсад урт хугацааны хөгжлийн хандлага, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, судалгаа шинжилгээ, сургалт явуулах, улс орны эдийн засаг, нийгэм хүрээлэн буй орчны хөгжлийн асуудлыг зангидан зохицуулах үүрэг бүхий Тулхтай хөгжлийн хүрээлэн байгуулахыг дэмжих

2020 он хүртэлх үндэсний хөгжлийн хөтөлбөрийг 21-р зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр дээр үндэслэн шинэчлэн боловсруулах

Бэлчээрийн даац, экологийн хүчин зүйлд нийцүүлэн малын тоо толгойг зөв зохистой тооцоолон бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх

Улс орны тусгаар тогтнол ба хөгжлийн үндэс, эрдэм ухааны сан нь болсон эрдэмтэн мэргэдээ үнэлэн хүндэтгэж түүх соёлынхоо дархлааг хадгалан төр, нийгэм, эдийн засгаа удирдах.

Байгаль орчныг бүх нийтээр хамгаалах үйлсэд хандив болгон дэвшүүлж буй санал, санаачлагууд тус Их хурлаар хэлэлцэгдэж буй бусад олон асуудлуудтай нягт салшгүй

холбоотой бөгөөд түүний нэгэн бүрдэл хэсэг болох юм. Энэ ч утгаараа манай салбар хуралдаанаас гарсан саналыг Монголч эрдэмтдийн их хурлаас гарах шийдвэрт тусгалаа олон батлагдана гэдэгт найдаж байна.

Монголын ард түмний оршин амьдарч ирсэн түүх,соёлын үнэт зүйлс, оршин амьдрах ирээдүйн хөгжил, хувь заяаны асуудлаар хэлэлцсэн энэхүү хурлын ажиллагаа амжилттай болж байна.

Ингээд хойч үедээ эх болсон байгаль дэлхийгээ өвлүүлэн үлдээж хойч ирээдүйгээ байгалийн сүйрлээс хамгаалья гэсэн уриалгаар үгээ төсгөхийг зөвшөөрнө үү.

## **6. ДАЯН ДЭЛХИЙН ТУЛХТАЙ ХӨГЖИЛ БА МОНГОЛ УЛС**

Хамтран зохиогч: Док. Л.Нямцэрэн

Док. Ц.Сүхбаатар

### **The World Sustainable Development and Mongolia**

In this paper, the process of the implementation of sustainable development principles in the world as well as in Mongolia, its evaluation points reflected in UNDP documents, the positive impacts of the elaboration of Mongolian Action Programme for sustainable development, critical issues and challenges for further development are considered.

Бидний хөгжлийн гол шаардлага бол зөвхөн өнөөдрийн тулгамдсан хэрэгцээг хагнахын тулд ирээдүйн хөгжлийн суурийг устгах ёсгүй, харин ирээдүйн хөгжлийн эх үүсвэрийг тавьж байх ёстой. Иймээс тогтвортой хөгжлийн тухай ярихад хүрч байгаа юм. The author justified the factors why we need sustainable development.

Улс орон бүр өөрийн онцлогтой, тулгамдсан асуудлууд нь ч өөр хоорондоо ялгаатай. Гэхдээ тогтвортой хөгжил нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван талын уялдаа бүхий нийтлэг нэг загвартай байна. Түүнчлэн тогтвортой хөгжилд хүрэхийн тулд улс орнууд нийтлэг 27 зарчмуудыг баримталж байна. Эдгээрийн заримыг нь онцгойлон дурдвал:

Тогтвортой хөгжлийн гол зорилго нь хүний төлөө тавих анхаарал халамж юм. Хүн ард байгаль орчинтойгоо зохицон эрүүл, үр бүтээлтэй амьдрах ёстой.

Улс орон бүр өөрийн мэдлийн нөөц баялагийг боловсруулан ашиглах бие даасан эрхтэй боловч дэлхийн ба бүс нутгийн хүрээлэн буй орчинд хохирол учруулахгүй байх явдлыг хагах хариуцлага хүлээнэ.

Хөгжин дэвших үйл явцын салшгүй нэг хэсэг нь хүрээлэн буй орчныг хамгаалах үйлс юм.

Тогтвортой хөгжлийн зайлшгүй нөхцөл бол ядуу зүдүү байдлыг үндсээр нь арилгах, амьжиргааны түвшний зөрүүг багасгах, хэрэгцээг илүү үр ашигтайгаар хангах явдал юм.

Хотжиж байгаа экологийн хувьд эмзэг орнуудын хэрэгцээнд онцгой ач холбогдол өгч эн тэргүүнд авч үзэж байна.

Нийт хүмүүсийг амьжиргааны өндөр түвшинд хүргэхийн тулд улс орнууд амьдрах чадваргүй үйлдвэрлэл, хэрэглээний үрэлгэн байдлын загварыг хязгаарлах, хүн амын зохистой байдлыг урамшуулах ёстой.

Шинэ, шинэлэг технологийг хөгжүүлэх, түгээх, дамжуулах, шинжлэх ухаан техникийн мэдлэгийг солилцох, боловсруулалтыг өргөжүүлэх үндэсний чадавхийг нэмэгдүүлэх талаар идэвхтэй хамтын ажиллагаа явуулах ёстой.

Бохирдолтой холбоотой зардлыг бохирдуулагч нөхөх ёстой гэсэн зарчмыг анхааралдаа авч хэрэгжүүлэх зэрэг болно.

XXI зууны тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэх асуудал нь улс орноо удирдах талаар үндсэн өөрчлөлт хийхийг шаардана. Өөрөөр хэлбэл, хөгжлийн алс хэтийн хараатай байж гэмээнэ өөрчлөлт хийж чадна. Ингэж шуурхай, үр дүнтэй ажиллаж байгаа улсуудын тоонд Коста Рика, Боливи, Хятад улс орж байна. Манай хил залгаа Хятад улс тогтвортой хөгжлийн хөтөлбөрөө бэлгэсэн анхдагч орнуудын нэг бөгөөд төвлөрсөн төлөвлөгөө загвартаа зохицуулалт, засвар хийж, тогтвортой хөгжлийн үндэсний олон хөтөлбөрүүдийг хотуудын болон орон нутгийн түвшинд боловсруулан мөрдөж байна.

Одоо дэлхийн ихэнх улс орнууд өөрийн тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө боловсруулан хэрэгжүүлж байна. 1992 оны дэлхийн чуулга уулзалтын үеэр НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн «Чадавхи 21» санг байгуулсан бөгөөд хөгжиж байгаа болон шилжилтийн 75 орны үндэсний болон орон нутгийн төлөвлөлтөд 21-р зууны тогтвортой хөгжлийн зарчмуудыг тусган хэрэгжүүлэхэд туслаж ирлээ.

Монгол улс хүн төрлөхтний хөгжлийн шинэ хандлага, үйл ажиллагаатай алхаа нийлүүлж, тогтвортой хөгжлийн үндэсний болон аймаг, хотуудын хөтөлбөрүүдээ боловсруулан хэрэгжүүлж байгаа төдийгүй сүүлийн 10 жилд тогтвортой хөгжлийн талаар гүйцэтгэсэн ажлын үндэсний тайлангаа Азийн орнуудаас хамгийн түрүүнд бэлтгэж дэлхий дахинд толилуулсан юм.

НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн баримт бичгүүдэд Монгол улсын тогтвортой хөгжлийн талаар хийж байгаа ажлыг үнэлж, тухайлбал:

Монгол улс хоёр жилийн хугацаанд стратегийн судалгаа, төлөвлөлт хийсэн туршлагатай.

Монгол улс тогтвортой хөгжлийн хөтөлбөртөө дэлхийн цаг уурын дулаарлын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцсон, нямбай судалгаа багтаасан.

Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг байгуулж, тэдгээр нь салбар хоорондын уялдааг бий болгон дэмжиж, нийгмийн бүхий л хэсгийг үндэсний болон орон нутгийн хөгжлийн төлөвлөлтөд уялдуулах үйл ажиллагааг эрхлүүлэх болжээ гэж дурьдсан байдаг.

Манай улс 1998 онд тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрөө /МХ-21/ боловсруулснаар өөрийн орны хөгжлийн алс хэтийн чиглэлийг харсан стратегийн баримт бичигтэй болж, нийгэм, эдийн засаг, байгаль орчны хөгжлийн асуудлыг цогцоор шийдвэрлэх, энэ талаар дэлхий нийтийн болон бүс нутгийн өмнө тулгарч байгаа хөгжлийн асуудалтай уялдуулан шийдвэрлэх боломж нөхцөл бүрдэж байна. Ялангуяа, тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх шатанд дараах аятай нөхцөл бий болж байна. Үүнд:

Үндэсний, салбарын болон орон нутгийн бодлого, мөрийн хөтөлбөрт тогтвортой хөгжлийн зарчмуудыг тусган хэрэгжүүлэх ажил хийгдэж эхлээд байна. Өөрөөр хэлбэл, удирдлагын бүх шатанд бодлого, зорилгоо тодорхойлохдоо тогтвортой хөгжлийн зарчмуудыг харгалзан үзэх болов.

Тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэхэд нийцсэн асуудлуудаар олон тоны хуулиуд батлагдан гарлаа. Ялангуяа, байгаль орчны асуудлаар багц хуулиуд батлагдан гарч байна.

Тогтвортой хөгжлийн асуудлаар гадаад хамтын ажиллагаа идэвхтэй явагдаж, НҮБ, Ази номхон далайн бүс нутаг, Зүүн хойд Азийн бүс нутгийн хүрээнд зохион байгуулж байгаа арга хэмжээнд идэвхтэй оролцож байна. Түүнчлэн БНХАУ, ОХУ-ын хил залгаа бүс нутгийн тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх чиглэлээр нийгэм, эдийн засаг, байгаль орчны асуудлаар олон тооны төслүүд хэрэгжиж байна.

Гэвч манай улсын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийн суурь нөхцлийг бүрдүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй тулгарч байна. Сүүлийн жилүүдэд байгаль цаг агаарын хүндрэлээс шалтгаалан мал аж ахуйн үйлдвэрлэл ихээхэн хохирол хүлээж, энэ нь олон өрх айлын амьдралд шууд нөлөөлөв. Манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэс, алт, ноолуурын дэлхийн зах зээлийн үнэ тогтвортой биш, голдуу буурч байснаас улсын төсвийн орлогод сөргөөр нөлөөлөв.

Өнөөдөр Монгол улсад өсөн нэмэгдэж буй ядуурал, хүрээлэн буй орчны доройтол, тогтвортой хөгжлийн боловсролын асуудал зэрэг нь үндэсний хэмжээний тулгамдсан асуудал болоод байна.

Өсөн нэмэгдэж байгаа ядууралтай тэмцэж, уг хандлагыг өөрчлөхийн тулд НҮБ, олон улсын тусламж дэмжлэг, хамтын ажиллагаанд түшиглэн засгийн газраас ядуурлын бууруулах үндэсний хөтөлбөрийг санаачлан 1996-2000 онд хэрэгжүүлэв. Одоо энэхүү хөтөлбөрийг үргэлжлүүлэн өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр болгон хэрэгжүүлж байна. Ийнхүү энэ асуудлаар олон хөтөлбөр, арга хэмжээ авч байгаа боловч ядуурал үндэсний тулгамдсан асуудал хэвээр байна. Үүнд эдийн засгийн өсөлт удаан, ажил эрхлэлт нэмэгдээгүй, ядуучуудын сэтгэлгээг өөрчлөх, тэдний боловсролд анхаарлаа түлхүү хандуулаагүйтэй холбоотой гэж үзэж болох юм.

Монгол улсад хүний шууд ба дам нөлөөлөл, байгалийн хүчин зүйлсийн улмаас хүрээлэн буй орчин улам доройтсоор байна. Энэ талаар тулгамдсан гол асуудлууд гэвэл, газрын доройтол, цөлжилт, хот суурин газрын хөрс болон агаар, усны бохирдол юм. 2001 оны байдлаар бэлчээрийн 78 хувь нь ямар нэгэн хэмжээгээр талхлагдсан байна. Цөлжилт, элсний нүүдэл жил бүр газар авч байна. Орчны бохирдолтой тэмцэх асуудал хурцаар тавигдахад хүрч байна. Тогтвортой хөгжлийн зорилтуудыг орчин үеийн хөгжлийн шаардлагад нийцсэн боловсролтой хүмүүс хэрэгжүүлэх учраас боловсролын тогтолцоог шинэчлэх, бүх нийтийн экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах шаардлага тавигдаж байна. Ялангуяа тогтвортой хөгжлийн зарчмуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд тодорхой бэрхшээл тулгарч байгааг энд зориуд тэмдэглэж байна.

1992 онд Рио Де Жанерод болсон дэлхийн дээд хэмжээний уулзалтаар баталсан Даян дэлхийн 21-р зууны хөгжлийн хөтөлбөрийн сүүлийн 10 жилийн хэрэгжилтийн байдалд НҮБ-ээс дараах үнэлгээ дүгнэлт өгсөн байна. Үүнд:

Дэлхийн хүрээлэн буй орчин улам доройтсон төдийгүй хэрэгжүүлж буй арга хэмжээ нь хангалтгүй хэвээр байна.

Хөгжиж буй орнуудын хувьд ядуурлыг бууруулах, даяаршлын хүрээнд олигтой амжилт олсонгүй, түүнчлэн дэлхийн хүн даяаршлын үр шимийг жигд хүртэж чадахгүй байна.

Хүмүүсийн эдийн засаг, нийгмийн хэрэгцээний тэнцвэрийг хангах, одоо ба ирээдүйн хэрэгцээг хангаж чадах экосистемийг хамгаалах асуудал, нөөцийг хамгаалах асуудал, улс төрийн тэнцвэргүй байдал, нэгдсэн зохицуулалтгүй арга барил, үйлдвэрлэл ба хэрэглээний хуучин хэв загвар оршсон хэвээр байна.

Гэвч сүүлийн 10 жилд хүний хөгжлийг дэмжих, хүрээлэн буй орчны доройтлыг багасгах зарим оролдлого үр дүнд хүрсэн, даян дэлхийн 21-р зууны хөгжлийн хөтөлбөр нь урт хугацааны хэтийн зорилго бүхий хүчирхэг гэрээ болон өнөөдөр ч хүчин төгөлдөр байна гэж үзсэн.



Манай улс НҮБ-ийн тогтвортой хөгжлийн комиссын гишүүний хувьд тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажил, чуулга уулзалтад идэвхтэй оролцлоо.

Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлөөс дээд хэмжээний уулзалтыг уган олон талт ажлуудыг зохион байгуулав. Энэ ажил нийгмийн бүх хүрээг хамарч байгаагийн дотор бидний ирээдүй-хүүхдүүд маань ч хамрагдаж байгаа билээ. 2000 онд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөртэй хамтран «XXI зууны тулхтай хөгжил» сэдвээр гар зургийн уралдааныг 7-16 насны хүүхдүүдийн дунд зарлан шалгарсан бүтээлүүдээр «Тогтвортой хөгжлийн тухай хүүхдийн бодол» цомгийг хэвлүүлэн гаргасан нь байгалиа шүтсэн Монгол хүүхдийн цэлмэг оюуныг илэрхийлсэн сонирхолтой бүтээл болсон юм. Мөн тогтвортой хөгжил сэдвээр үндэсний хэмжээнд зохион бичлэгийн уралдаан зохион байгуулав.

Дэлхийн тогтвортой хөгжлийн үнэлгээний багийн мэргэжилтнийг урьж, Монгол улсад тогтвортой хөгжлийн хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгаа талаар үнэлгээ хийлгээд байгаа бөгөөд аймгуудын хэмжээнд ч энэ ажил хийгдэж Дундговь, Увс, Архангай, Улаанбаатар, Сүхбаатар аймгууд өөрсдөө тогтвортой хөгжлийн хөтөлбөрийнхөө хэрэгжилтэд үнэлгээ хийлээ.

2002 оны 8 дугаар сард болсон олон улсын Монголч эрдэмтэдийн 8 дугаар их хурлаар анх удаа «Монголын тогтвортой хөгжлийн асуудал: Хүний хөгжил ба хүрээлэн буй орчин»-ы асуудлыг тусгай салбар хуралдаан болгон авч хэлэлцэв. Түүний зэрэгцээ Монгол улсын засгийн газраас «Монгол улс XXI зууны тогтвортой хөгжлийн төлөө» сэдэвт бага хурал зохион байгуулж, Засгийн газраас өнгөрсөн 10 жилд тогтвортой хөгжлийн талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн, цаашдын зорилттой холбогдсон илтгэлүүдийг хэлэлцэж шийдвэр гаргалаа.

Тогтвортой хөгжил хамтын түншлэлд тулгуурлан эрчимждэг гэсэн утгаар нь тогтвортой хөгжлийн бүсийн хөтөлбөр боловсруулах ажлыг зүүн бүсээс эхэлж байна. Мөн Төв аймгийн Эрдэнэ, Баянчандмань, Зуунмод, Лүн сумын тогтвортой хөгжлийн хөтөлбөр боловсруулах орон нутгийн санаачлага гарч ажлаа эхлээд байна.

Даян дэлхийн тулхтай хөгжлийн асуудлаар дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт болж, олон чухал асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн нь Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх гадаад таатай нөхцөл улам бүр бүрдэж байна гэсэн хэрэг болно. Үүнтэй холбогдуулан цаашид дараах асуудлуудад анхаарах шаардлагатай байна. Үүнд:

Тогтвортой хөгжлийн гол зорилтууд, тухайлбал, цөлжилт, ойжуулалт, экологийн цэвэр бүтээгдхүүний үйлдвэрлэл, сэргээгдэх эрчим хүчийг өргөн ашиглах талаар НҮБ, олон улсын

хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, цаашид тодорхой төсөл боловсруулан хэрэгжүүлэх.

Тогтвортой хөгжлийн сургалт, судалгааны шинэ тогтолцоо бүрдүүлэх талаар хөгжингүй орнуудтай хамтран ажиллах, санхүүжилтийн шинэ боломжийг илрүүлэн ашиглах.

Даян дэлхийн ба Монгол улсын тогтвортой хөгжлийн өнөө, ирээдүйг судлан шинжилж, түүнийг хүн арддаа хүргэж ойлгуулах эрдэм шинжилгээ, сургалтын төв, бас байгаль орчинд хоргүй үйлдвэрлэл, бизнесийг дэмжин хөгжүүлж, санхүүжүүлдэг практик үйлсийг удирдах төв гэсэн давхар үүргийг гүйцэтгэх Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний хүрээлэн байгуулж ажиллуулах.

4. Эдийн засгийн тогтвортой өсөлт, ажил эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн макро эдийн засгийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд гадаад, дотоод санхүүгийн эх үүсвэрийг дайчлан ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэхтэй холботой удаан хугацааны төслүүдийг хэрэгжүүлэх.

## **7. ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД ТУЛГАМДАЖ БУЙ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДЛУУД, ТЭДГЭЭРИЙГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ**

/2002 оны 6 дугаар сард Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн хуралд тавьсан илтгэл/

### **The Critical Issues of Sustainable Development at National Level and Ways to resolve them**

Although there are some progresses in protecting the environment as result of the conference on Humanity and Environment in Stockholm before 30 years, the state of the environment is still an international critical problem. The concept of the sustainable development was formulated in Rio de Janeiro at the world Summit 10 years ago. There is a need to resolve number of global problems in order to ensure the universal human right to live in an ecologically secure environment and to enable the sustainable development environment. Clean water and sanitation, energy, agriculture productivity, biological diversity and ecosystem management and health are critical and also are the large problems at global dimensions. The author considered number of factors in connection with these critical global problems and suggested appropriate policy recommendations.

Гучин жилийн өмнө дэлхий нийтээрээ Стоколм хотноо хуран цуглаж, «Хүн төрөлхтөн, хүрээлэн буй орчин» -ны асуудлаар зөвшилцөн үүний үр дүнд улс орон бүрд хүрээлэн буй орчноо хамгаалах ажлыг өрнүүлэн тодорхой амжилтанд хүрээд байгаа хэдий ч хүрээлэн буй орчны байдал олон улсын тулгамдсан асуудал хэвээр байна.

Арван жилийн өмнө Рио Де Жанейро хотноо дэлхий нийтээрээ хуран цуглаж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлсон билээ. Экологийн аюулгүй орчинд амьдрах хүний түгээмэл эрхийг хангах, тогтвортой хөгжлийн нөхцлийг бүрдүүлэх үүднээс тив дэлхийн чанартай олон асуудлыг шийдвэрлэх шаардлага бидний өмнө тулгараад байна. Даян дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтыг угтан Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэн , цаашид дэлхий нийтийн өмнө тулгарч буй гол асуудлуудыг тодорхойлон шийдвэрлэх арга замыг эрэлхийлж байна.

Цэвэр ус ба эрүүл ахуй, эрчим хүч, ХАА-н бүтээмж, биологийн төрөл зүйл ба экосистемийн менежмент, эрүүл мэндийн асуудал зэрэг нь дэлхийн хэмжээнд тулгамдаж буй томоохон асуудлууд болоод байна. Эдгээр асуудлыг одоогийн нөөцийн болон технологийн төвшинд шийдвэрлэх боломжтой бөгөөд хүн төрөлхтөний хөгжлийн ирээдүйд чухал хувь нэмэр оруулах юм.

**Цэвэр ус ба эрүүл ахуй:** Өнөөдөр дэлхийд 1 тэрбум хүн цэвэр усны нөөцийн хомсдолтой , үүнээс 2 дахин олон хүн эрүүл ахуйн наад захын хэрэгцээг хангахгүй орчинд амьдарч байна. Ундны усны бохирдлоос шалтгаалан жил бүр 3 сая хүн нас барж байна. Одоогийн байдлаар хүн төрөлхтөн цэвэр усны нөөцийнхөө 54 хувийг ашиглачихсан, 2025 он гэхэд 70 хувьд хүрэх хандлагатай байна. Усны хэрэглээний 70 хувийг ХАА-д, 8 хувийг ахуйн хэрэгцээнд, 22 хувийг үйлдвэрлэлд тус тус хэрэглэдэг.

Дээрхи тоо баримтууд нь усны хэрэглээний үр ашгийг дээшлүүлэх, усны хангамжийн менежментийг сайжруулах, усны нөөцийг тэгш хувиарлахыг хүн төрөлхтнөөс шаардаж байна.

**Эрчим хүч:** Эрчим хүч нь хөгжлийн суурь асуудал байдаг. Өнөөдөр 2 тэрбум хүн эрчим хүчний хомсдолтой байна. Эдгээр хүмүүс уламжлалт био массын эрчим хүчийг тухайлбал мод аргал, газар тариалангийн үлдэгдлийг түлшиндээ хэрэглэж байна. Хүн амын эрчим хүчний хэрэглээг нөхөн сэргээгдэх, байгаль орчинд халгүй эрчим хүчээр хангах , эрчим хүчний үр ашигтай технологи нэвтрүүлэх , эрчим хүчний тогтвортой бус хэрэглээний хэв маягийг өөрчлөх шаардлагатай байна. Дэлхийн дахинаа эрчим хүчний үр ашгийг дараагийн 20-30 жилийн дотор 4 дахин дээшлүүлэх зорилтыг тавьсан.

**ХАА-н бүтээмж:** Газар тариалангийн өсөлт нь өсөн нэмэгдэж буй хүнсний хэрэгцээг хангах боловч ой мод , бэлчээр нутаг, газрын доройтолд сөргөөр нөлөөлдөг гол хүчин зүйл болдог.

Дэлхийн хэмжээнд 2 сая га газар, дэлхийн газар тариалангийн талбайн гуравны хоёр нь хөрсний доройтолд орсон. Хөрсний доройтлоос шалтгаалан ХАА-н бүтээмж огцом буурч олон сая хүн өлсгөлөнгийн байдалд амьдарч байна. ХАА-н үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх замаар газар тариалангийн талбайн хэмжээг багасгах шаардлагатай байна.

**Биологийн төрөл зүйл ба экосистемийн менежемент:** Өнөөдөр 11,000 гаруй биологийн төрөл зүйлд мөхлийн аюул занал нүүрлээд байгаа ба амьтан ургамлын оршин амьдрах орчин сүйтснээс 800 гаруй төрөл зүйл аль хэдийн устаж үгүй болов.

Дэлхийн загас агнуурын нөөцийн 75 хувийг ашиглачихаад байна. 1990-ээд оны үеэс дэлхийн ой модыг асар ихээр сүйтгэж, жилд 14,6 сая га-г ялангуяа хөгжиж буй орнуудад сүүлийн 10 жилд дэлхийн модны 4 хувийг сүйтгэсэн дүн гарч байна. Хүн төрөлхтөн энэхүү сөрөг үйл ажиллагааг зогсоохын тулд биологийн төрөл зүйлийг хамгаалах, хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, эко системийн менежментийг боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй байна.

**Эрүүл мэнд:** Хүрээлэн буй орчин ба эрүүл мэндийн харилцан хамаарал нь улам хүчтэй болж байна. Хүрээлэн буй орчны доройтлын улмаас хүний эрүүл мэндэд олон сөрөг нөлөөлөл бий болж өвчлөлийн төвшин нэмэгдэж байна. Нэг тэрбум хүн бохирдсон агаараар амьсгалж, жил бүр бохирдлын улмаас 3 сая хүн нас барж байна. Эдгээрийн 2/3 нь ядуучууд ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд байгаа бөгөөд тэд ахуй орчны бохирдол, тухайлбал мод нүүрсний утаа, ундны ус, хөрсний бохирдлын улмаас нас барж байна. Химийн хортой бодисын хэрэглээ, ахуйн болон үйлдвэрийн хог хаягдлыг багасгах замаар хүрээлэн буй орчны эрүүл ахуйн асуудлыг шийдвэрлэх боломжтой юм.

Монгол улс 21-р зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтэндээ үнэлгээ хийж, Монгол улсын ТХ-ийн чиглэлээр олсон ололт амжилтыг үнэлэхийн зэрэгцээ алдаа дутагдал, сул талыг тодорхойлон үндэсний хэмжээнд тулгамдаж буй тогтвортой хөгжлийн асуудлуудыг тодруулан гаргаж, олон нийтийн болон мэрэгжилтнүүдийн саналыг тусгав. Үнэлгээ, судалгааны үр дүнгээс үзэхэд өсөн нэмэгдэж буй ядуурал, хүрээлэн буй орчны доройтол, тогтвортой хөгжлийн боловсролын асуудал нь үндэсний хэмжээнд тулгамдаж буй томоохон асуудлууд болоод байна.

**Өсөн нэмэгдэж буй ядуурал:** Огцом өсөн нэмэгдэж буй ядууралтай тэмцэж, уг хандлагыг өөрчлөхийн тулд НҮБ-ын холбогдох байгууллага, олон улсын тусламж дэмжлэг хамтын ажиллагаанд түшиглэн Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр (ЯБҮХ) -ийг Засгийн газраас санаачлан 1996-2000 онд хэрэгжүүллээ. Засгийн газраас ядууралтай тэмцэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн хөтөлбөр хэрэгжүүлэх явцад гарсан сургамжиндаа тулгуурлан хүний ерөнхий хөгжлийг дэмжихэд чиглэсэн өрхийн амжиргааны чадавхийг дээшлүүлэх

үндэсний хөтөлбөрийг боловсруулаад байна. Ядуурлыг бууруулах чиглэлээр олон хөтөлбөр, арга хэмжээ хэрэгжиж байгаа хэдий ч ядуурал үндэсний тулгамдсан асуудал хэвээр байна. Үүнийг хэд хэдэн хүчин зүйлтэй тухайлбал эдийн засгийн өсөлт удаан, ажил эрхлэлт нэмэгдээгүй, ядуучуудын сэтгэлгээ болон тэдний боловсролд анхаарал хандуулаагүй зэрэг хүчин зүйлстэй уялдуулан авч үзэж болох юм. Нөгөө талаар Монгол улсын өвөрмөц байдал буюу хүн амын зарим хэсгийн хэт таруу байршилт, хот хөдөөгийн хөгжлийн түвшиний өсөн нэмэгдэж буй ялгаа, ган зуд зэрэг байгалийн гамшигаас хэт хамааралтай нүүдлийн мал аж ахуй эрхэлдэг малчдын амьдрал ахуйн онцлог зэрэг цөөнгүй хүчин зүйлсийг ядуурлын хөтөлбөр арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэхэд дутуу анхаарсан явдал байна.

Эдийн засгийн тогтвортой өсөлт, бүтцийн шинэчлэлт, ажил эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэсэн макро эдийн засгийн бодлоготой уялдуулж ядуурлыг бууруулах талаар дараахи арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

Жижиг дунд үйлдвэрлэлийг урамшуулах, эрх зүйн зохицуулалт хийж, татварын зохистой тогтолцоог нэвтрүүлэх, жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих замаар ажлын байрыг нэмэгдүүлэх,

Иргэдийн боловсрол, эрүүл мэндийг сайжруулах, тэдний ур чадварыг нэмэгдүүлэх зэргээр хүний хүчин зүйлийг хөгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг өсгөх,

Ядуучуудын амьдрах орчин, нөхцөл бололцоог сайжруулах тухайлбал боловсрол эзэмшүүлэх, газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд нь туслах зээл олгох, тухтай аж төрөх нөхцлийг бүрдүүлэх

Өрхийн амжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудад хандан төслийн хөрөнгө оруулалт хийх хүсэлт тавих зэрэг болно.

**Хүрээлэн буй орчны доройтол:** Хүний шууд болон дам нөлөөлөл, байгалийн хүчин зүйлийн улмаас биднийг хүрээлэн буй орчин улам бүр доройтсоор байна. Хүрээлэн буй орчны тулгамдсан асуудалд газрын доройтол, бэлчээрийн даац хэтрэлт, цөлжилт, хот суурин газрын хөрсний болон агаарын бохирдол гол байрыг эзэлж байна. БОЯ наас 2000-2001 онд хийсэн үнэлгээний дүнгээс үзэхэд бэлчээрийн 78,4 хувь нь ямар нэг хэмжээгээр талхлагдсаны дээр сүүлийн 8-10 жилд бэлчээрийн эдэлбэр газрын доройтлын хэмжээ 8-10 хувиар нэмэгджээ. Монгол улс цөлжилттэй тэмцэх НҮБ-ын Конвенцийг батлах, түүнийг хэрэгжүүлэх үйлсэд идэвхигэй оролцож ирлээ. Монгол улс нь цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Хот суурин газрын хүн амын механик өсөлт, төвлөрөл түүнчлэн үйлдвэрлэл хэрэглээний хог хаягдалтай хуучин хэв загвар, арга барил оршин тогтносоор байгаа нь хот суурин газрын хүрээлэн буй орчныг бохирдуулах, улмаар хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нөхцлийг бүрдүүлж байна. Байгалийн нөөцийн хамгаалалт, ашиглалтын тогтолцоог

боловсронгуй болгож, менежментийг сайжруулах явдал удаан байгаа нь хүрээлэн буй орчны доройтлыг тууштай бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулсаар байна.

Энэ хүрээнд дараахи арга хэмжээг санал болгож байна. Үүнд:

- Цөлжилттэй тэмцэх конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд Монгол улстай хамтран ажиллах түншлэх талаар Европын холбоо болон бусад цөлжилттэй тэмцэх асуудлыг дэмжиж буй хандивлагчдад хүсэлт тавих
- Ойжуулах, говь хээрийн бүсэд усжуулах цэг бий болгоход санхүүгийн дэмжлэг авах
- Хөрсийг нөхөн сэргээж, хамгаалах, мод суулгах, цэцэрлэгжүүлэх зэргээр газрын чанарыг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан иргэд аж ахуйн нэгжийг татвараас чөлөөлөх буюу санхүүгийн бусад дэмжлэг үзүүлэх
- Сүргийн бүтцийг сайжруулж бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулах зорилгоор татварын болон санхүүгийн бусад хөшүүргүүдийг оновчтой ашиглах,
- Эдийн засгийн макро бүсүүдийн дунд хугацааны тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг яаралтай боловсруулан тэдгээрийн хүрээнд эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудалтай оновчтой уялдуулан хүрээлэн буй орчны доройтлыг тууштай бууруулах,
- Цэвэр технологийг дэмжих төв байгуулан үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн болон оюуны хөрөнгө оруулалт хийх зэрэг болно.

**Тогтвортой хөгжлийн боловсрол:** Монголын боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагын одоогийн үүрэг байр суурь нь тулхтай хөгжлийн боловсролын шаардлагад харахан нийцэж чадахгүй байна. Нийт ард иргэдийн энэ талаархи мэдлэг мэдээлэл хангалтгүй байгаа нь байгаль орчныг хамгаалах үйлст сөргөөр нөлөөлж байна. Бүх нийтэд экологийн боловсрол олгох үндэсний хөтөлбөрийг 1997 онд боловсруулан хэрэгжүүлж эхлээд байна. Боловсролын салбарыг хөгжүүлэх хөтөлбөрийг БСШУЯ-наас 1997-2001 онд хэрэгжүүллээ. Уг хөтөлбөрийн хэрэгжилт нь боловсролын менежментийн чадавхийг сайжруулах, боловсролын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, сургалтын байгууллагуудыг шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэхэд түлхэц болох бөгөөд эцсийн үр дүндээ боловсролын тогтолцоог тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн шинэчлэх суурь болох юм.

Тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэх талаар дараах арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

- Хүрээлэн буй орчны талаархи олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх

- Хүрээлэн буй орчны талаархи мэдээллийг ашиглах, түгээх үндэсний тогтолцоог бүрдүүлэх,

- Бүх нийтийн экологийн боловсролыг сайжруулах хөтөлбөрийн үйл ажиллагаанд Засгийн газарын болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог өргөжүүлэх,

- Хүрээлэн буй орны бохирд олыг багасгах болон бохирдсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудыг чадваржуулах, боловсон хүчин бэлтгэхэд нь туслах,

- Хүрээлэн буй орчны талаархи олон нийтийн мэдээллийг сайжруулах зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслийг өргөн ашиглах,

- Тогтвортой хөгжлийн сурах бичиг , гарын авлага материалаар хангах , ТХ-ийн боловсролын сүлжээг бий болгож, нийтийн хүртээл болгох,

- Байгаль орчныг хамгаалдаг уламжлалт ёс заншил болон байгаль орчны хууль тогтоомжийг ухуулан сурталчлах үйл ажиллагааг идэвхижүүлэх зэрэг болно.

Эдгээрээс гадна олон улсын байгууллагууд болон хандивлагчдаас дэмжлэг авах боломжтой зарим асуудлуудад та бүхний анхаарлыг хандуулья.

Үүнд :

- Экологийн цэвэр бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах, үүний тулд өндөр технологит тулгуурласан лаборатори байгуулан , тухайн бүтээгдэхүүнд дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн чанарын үнэлгээ хийж баталгаажуулан дэлхийн зах зээлд гаргахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор тодорхой төслүүдийг боловсруулан санхүүгийн дэмжлэг авах

- Нар салхи гэх мэт нөхөн сэргээгдэх эрчим хүчийг ашиглах, эрчим хүчний үр ашигтай технологийг нэвтрүүлэх, эрчим хүчний зохистой бус хэрэглээний хэв маягийг өөрчлөх замаар эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх, эрчим хүчний хэрэглээг хангахад чиглэсэн олон улсын болон хандивлагч орнуудын оролцоотой төслүүдийг хэрэгжүүлэх

- Экологийн тосгон байгуулах, эко аялал жуучлалыг хөгжүүлэх чиглэлээр хамтарсан төслүүдийг хэрэгжүүлэх

- Хөдөөд тухайлбал сум, багт тогтвортой хөгжлийн гол агуулга тулгуур зарчмуудыг хүргэх, ойлгуулах зорилгоор олон улсын байгууллага, хандивлагч орнуудын тусламж дэмжлэг авч тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх энэ зорилгоор эхний ээлжинд хөдөөгийн багийг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн хөгжүүлэх нөөц бололцоог илрүүлэх, оновчтой загвар боловсруулахад чиглэсэн хамтарсан судалгааны төсөл боловсруулж хэрэгжүүлэх,

Иймэрхүү шинэлэг асуудлуудыг олж харан, өргөн хүрээтэй судалгааны ажил хийх улмаар тулхтай хөгжлийн боловсрол, эрдэм шинжилгээ ,судалгааны ажлыг зохион байгуулах,

хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Тогтвортой хөгжлийн үндэсний хүрээлэн байгуулах шаардлага ч тулгарч байгааг энд дурьдах хэрэгтэй байна.

## **8. ОЛОН УЛС, БҮС НУТАГ, ҮНДЭСНИЙ ТҮВШИН ДЭХЬ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГА**

Хамтран зохиогч: А.Баяриаа

### **Sustainable Development Management at International, Regional And National Levels**

There is a need to strengthen the current system of sustainable development at international, regional and national level in order to strengthen the management mechanisms and institutions, to ensure the coordination between sectors and policies, to limit the duplications and to enhance the responsibility for the implementation in economic, social and environmental sphere. The author considered some points, which require the attention on an effective sustainable development governance system in general at all level as well as at international, regional and national levels.

Тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, НҮБ-ын «Байгаль орчин ба хөгжил» чуулганаас хойш хөгжлийн төвшинг тооцож үзэхийн тулд тогтвортой хөгжлийн удирдлагын өнөөгийн тогтолцоог олон улсын, бүсийн, үндэсний төвшинд бэхжүүлэх шаардлагатай байна. Тогтвортой хөгжлийн удирдлагыг бэхжүүлэх гол зорилго нь эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны салбар дахь удирдлагын арга механизм, зохион байгуулалтыг бэхжүүлэх түүнчлэн салбарууд тус бүрийн болон хоорондын харилцан шүтэлцээг баталгаажуулах, бодлогыг нэгтгэх, давхцлалыг хязгаарлах, хэрэгжилт ба хариуцлагыг бэхжүүлэх явдал юм.

Энэхүү нөхцөл байдалд үр ашигтай тогтвортой хөгжлийн засаглалын ерөнхий тогтолцоо нь бүхий л төвшинд дараахи зүйлүүдэд анхаарлаа хандуулах ёстой. Үүнд:

1. Эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчин зэрэг тогтвортой хөгжлийн 3 хэмжүүрийг нэгтгэсэн үр ашигтай тогтолцоо, механизмтай байх.

Бодлого боловсруулах ба хэрэгжүүлэхэд харилцан шүтэлцээ, тогтвортой нөхцлийг хангах.

Бодлого боловсруулах төвшинд засгийн газрын бүхий л нэгж хэсэг, иргэний нийгмийн оролцооны үр ашиг ба ил тод байдлыг хангах.

Үр ашигтай бодлого боловсруулах, зохицуулах, хэрэгжүүлэх, хяналтыг хангах зохион байгуулалтын бүтэцтэй байх.

Олон улс, бүс нутаг, үндэсний төвшин дэхь тогтвортой хөгжлийн засаглал нь дээр дурьдсанчилан нягт уялдаатай, харилцан хамраалтай байна.



**Олон улсын төвшинд:** Бодлого боловсруулах хэрэгжүүлэхэд эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны хүчин зүйлүүдийн нэгдэл тэнцвэржилтийн нөхцөлд тогтвортой хөгжлийн зорилтыг хангах олон улсын тогтолцоо бүрдэх юм.

НҮБ-ын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн чиг үүрэг нь:


- Тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх тодорхой түншлэлүүдийг өргө-жүүлэх , түншлэлүүдийн хоорондын зохицуулалтыг хангах.
- НҮБ-ын системийн доторхи тогтвортой хөгжилтэй холбоотой асуудлуудыг төлөвлөх , хэрэгжүүлэх, хяналт тавих, удирдан зохион байгуулах.
- НҮБ-ийн системийн хүрээнд авч үздэггүй салбарын хүрээний асуудлуудыг нэгтгэх, зохицуулах.
- Санхүүгийн нөөц, тогтвортой хөгжлийн технологи шилжүүлэх, түүнчлэн чадавхи бүрдүүлэхтэй холбоотой асуудлуудад хяналт тавих.
- Тогтвортой хөгжлийн олон улсын байгууллага агентуудын тайланг хүлээн авах хэлэлцэх.
- Олон улсын төвшинд тогтвортой хөгжлийн олон талынхны оролцоог хангах.


**Бүс нутгийн төвшинд:** НҮБ-ын эдийн засгийн зөвлөл ба дэд бүсүүдийн бүлгүүдийн оролцоотойгоор бүс нутгийн төвшинд тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх боломжтой. Бүс нутгийн тогтвортой хөгжлийн зөвлөл нь дараахи чиг үүргийг гүйцэтгэнэ.

- Бүс нутгийн хэмжээнд тогтвортой хөгжлийн чиглэлээр хэрэгжүүлэх бодоло төлөвлөлт хэрэгжилт, хяналтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах
- Улс орнуудын оролцоог хангах, дээшлүүлэх
- Бүс нутаг дахь ТХ-ийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх шинэ түнш-лэлүүдийг дэмжих бодит үйл жиллаганд чиглэсэн олон талын оролцогсдын оролцоог дээшлүүлэх
- Үндэсний болон даян дэлхийн 21 дүгээр зууны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг хэлэлцэх үнэлэх


**Үндэсний төвшинд:** Улс орон бүр тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл эсвэл ижил чиг үүрэгтэй албыг байгуулан ажилладаг. Энэхүү зөвлөл нь олон талын оролцоог хангасан байх бөгөөд шийдвэр гаргах төвшинийхний оролцоог хангахад гол анхаарлаа хандуулдаг. Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл нь тухайн үндэстний хүрээнд тогтвортой хөгжлийн стратеги тодорхойлох, чадавхи бүрдүүлэх, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэх, хяналт тавих, салбаруудын хоорондын тогтвортой уялдааг хангах ,зохицуулах үүрэгтэй.

### Тогтвортой хөгжлийн удирдлагын бүтэц






НҮБ-ын ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗӨВЛӨЛ



Бүс нутаг дахь эдийн засаг, нийгмийн хорооны дэргэдэх тогтвортой хөгжлийн хороо



Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл

### 9. ЗҮҮН ХОЙД АЗИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛД

/2002 оны 3 дугаар сард Улаанбаатар хотноо болсон «Зүүн хойд Азийн хамтын ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйлс» сэдэвт бага хуралд тавьсан илтгэл/

Хамтран зохиогч: Док. Л. Нямцэрэн

#### А. Зүүн хойд Азийн олон талт хамтын ажиллагааны гол шинж чанарууд

Зүүн хойд Ази нь геополитик, өндөр технологи, капитал, ноу-хау болон хөдөлмөр, байгалийн нөөцийн хувьд харилцан орлох асар их чадавхтай боловч тэдгээр нь үндсэндээ ашиглагдахгүй хэвээр байна. Эдгээр чадавхи тус бүс нутгийг дэлхийд хамгийн том бөгөөд хүчтэй эдийн засгийн бүсийн байр сууринд хүргэх боломжтой.

Геополитикийн хувьд тус бүс нутаг нь дэлхийн хамгийн том тив болон хамгийн том далайн төв, өнцөгт байрласан бөгөөд тэгснээр түүхий эд, материалын хамгийн том ордууд болон зах зээлд хүрэх хамгийн аятай нөхцөлтэй. Өөрөөр хэлбэл тэрээр дэлхийн эдийн засгийн гол бүсүүдийн "уулзвар"-г байрлаж байна. Дэлхийн бөмбөрцөгийн хойд хагасын төв өргөрөгт байрлах энэ бүсийн цаг уурын хамгийн тохиромжтой нөхцөл нь хүний үйл ажиллагааг ямагт тэтгэж байдаг.

Түүний байршил, цаг уурын нөхцөл нь Зүүн хойд Ази /ЗХА/-ид их хүчитнүүдийг төрүүлэх талбар болгодгоороо онцлог. Цаг уурын байдал нь түргэн хугацаанд солигдож байдгаараа хөгжлийн ямар нэг өөрчлөлтөд оруулах хүмүүсийн психологид нөлөөлдөг байна. Хүчний тэнцвэрийг хадгалах үйл явц нь өөрөө их хүчитнүүдийн хооронд өрсөлдөөнийг бий болгож, ингэснээрээ улам чадалтай хүчитнийг төрүүлдэг.

Зүүн хойд Ази нь түүний улс үндэстнүүдийн газар нутгийн шинж чанар, эдийн засгийн систем, эдийн засгийн түвшингийн ялгаа, нийгэм, улс төрийн хөгжлөөрөө олон төрөл байдалд байдгаараа мөн онцлог. Тийм учраас тэрээр хоорондоо харилцан орлож болох их хэмжээний төрөл зүйл, хамтын ажиллагааны их нөөц, эдийн засгаа чадахжуулах хөгжлийн өргөн боломжуудыг өргөн барьж байгаа юм.

Зүүн хойд Азийн орнууд, ялангуяа их хүчитнүүд хоорондоо өндөр хэмжээнд харилцан хамааралтай боловч хүн, бараа, мөнгө, мэдээлэлийн урсгал нь өнөөг хүртэл тэнцвэргүй, хязгаарлагдмал хэвээр байна.

Зүүн хойд Ази нь 20 дугаар зууны төгсгөлд эдийн засгийн хатуу цохилтод өртөж, тэр нь тус бүс нутагт байгаа орнууд нэгэн хувь заяатай гэдгийг ойлгуулж, цаашдын хөгжилдөө зайлшгүй яах ёстой вэ гэдэг талаар хатуу сургамж өгсөн билээ.

Зүүн хойд Азид тус бүс нутгийн зарим орнууд эргэн нэгдэхтэй холбогдсон асуудлуудтай нүүрлэж байна. Гэдээ энэ талаар амжилттай хэлэлцэн тохиролцож чадвал тэр нь өсөлтийн их хөдөлгөгч хүч болж, тэрээр эргэн нэгдсэн орнуудын төдийгүй бүх бүс нутагт ашигтай болох болно.

Дэлхий ертөнц 21 дүгээр зуунд шилжин орох үед Зүүн хойд Ази нь их нааштай өөрчлөлтүүдийн бүс нутаг болох найдлага төрүүлж байна. Одоогийн байдлаар "Зүүн хойд Ази" гэсэн нэр томъёог зөвхөн нутаг дэвсгэрийн талаас нь харгалзан үзэж тодорхойлсон байна. Тэгснээр түүнд Зүүнхойд Хятадын гурван муж /Лианонин, Жилин, Хеилонгжиан/,

БНАСАУ, БНСУ, Монгол, Оросын Алс Дорнод болон Японы тэнгэс талын баруун хэсгийн арван муж хамаарч байна.<sup>1</sup>

"Зүүн хойд Ази" гэсэн нэр томъёог өргөн утгаар нь нутаг дэвсгэрийн төдийгүй, үйлчлэлийн /функционал/ талаас нь авч үзэж тодорхойлох ёстой. Даяарчлал, экологийн харилцан хамаарал болон улс орнуудын хоёр болон олон талын харилцааны явцад "бүс нутаг" гэдэг нэр томъёо /Жишээ нь Зүүн хойд Азийн бүс нутаг/ нь зөвхөн нутаг дэвсгэрийн төдийгүй, улам ихээр түүний үйлчлэлийн хүрээний концепци болж байна. Жишээлбэл, эколог, улс төр, эдийн засаг, соёл, нийгмийн харилцан үйлчлэлийн байгалийн уялдаа холбооны хүрээг харгалзан үзэх хэрэгтэй. "Бүс нутаг"-ийн томъёолол нь байгалийн харилцан уялдаа холбооны дагуу өөрчлөгдөж байж болох юм.

Жишээлбэл, экологийн харилцан уялдаа холбооны хувьд Зүүн хойд Ази, Хойд Атлантын бүс нутаг хоорондоо нийлэх хандлага ажиглагдаж байна. Тухайлбал, НҮБ-ын Байгаль орчин Хөгжлийн талаархи Рио Де Жанерогийн Дээд хэмжээний уулзалтын дараачийн арга хэмжээний хүрээнд Зүүн хойд Ази, Хойд Атлантын Байгаль орчны Форум /ЗХАХАБОФ/ Канад, Хятад, БНАСАУ, Япон, Монгол, БНСУ, ОХУ, АНУ оролцон 1992 онд байгуулагдсан байна. Энэхүү форумыг санхүүжүүлэхэд Японы Азийн сан чухал үүрэг гүйцэтгэж байна.<sup>5</sup> Уг форум нь бүс нутгийн эко-системийн менежемент, байгаль орчны хил дамнасан асуудлуудын стратеги, арга зүй, динамикийн талаар анхаарч, бүс нутгийн экологийг хадгалах стратегийг боловсруулахад тухайн бүсийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг авч үзэх шаардлагатай гэсэн дүгнэлт хийсэн байна.Түүнээс гадна АНУ, ЗХА-ийн орнуудын хооронд АНУ-ын Баруун Эрэг-Оросын Алс Дорнодын ажлын хэсэг, АНУ-Оросын Хөгжлийн Хороо, Эдийн засаг, Технологийн Корпорацын Хамтарсан Комисс зэрэг хоёр талын үндсэнд ажиллах Засгийн газрын болон Төрийн бус байгууллагууд ажиллаж байна.

Иймд, "Зүүн хойд Ази"-д дор хаяад /явцуу утгаар/ Япон, БНСУ, БНАСАУ, Монгол, ОХУ дахь Алс Дорнод, Зүүн Сибир, Хятадын зүүн хойд талын гурван муж /Лионин, Жилин, Хеилонгжиан/, БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах орон, Хон Конг, Тайвань, болон АНУ, Канадын Атлантын далайн эргийн хэсгийг хамааруулж авч үзэх ёстой. "Зүүн хойд Ази"-ийг явцуу утгаар авч үзэхэд зарим орнуудын зөвхөн зарим хэсгийг ЗХА-д оруулсан бол түүнийг өргөн утгаар нь авч үзэхэд түүнд хамаарах бүх орнуудыг бүрэн хэмжээгээр нь хамааруулна гэсэн ойлголтод үндэслэнэ. Өөрөөр хэлбэл Зүүн хойд Ази нь өргөн утгаараа Япон, Хятад, БНСУ, БНАСАУ, Монгол, Орос, Хон Конг, Тайвань болон АНУ, Канадын баруун эргийг хамаарна. АНУ, Канад нь хэдийнээ Хойд Атлантын Чөлөөт Худалдааны Гэрээнд нэгдэн орсон учраас АНУ, Канадын баруун эргийн улсуудтай хийх хамтын ажиллагааг бүс

нутаг хоорондын утгаар ач үзнэ. Харилцан орлох боломжийг илрүүлэх зорилгоор Зүүн хойд Азийн бүс нутгийг түүний өргөн болон явцуу утгаар нь авч үзэж судлах шаардлагатай.

ЗХА дахь олон улсын харилцааны түүхэн нэг онцлог бол түүний "хүчний тэнцвэр" юм. Хэрэв аль нэг орон тухайн бүс нутагт нэн хүчтэй болж, хөрш орнууддаа аюултай болох үед ЗХА дахь хүчний тэнцвэр улам идэвхждэг байв. Энэхүү хүчний тэнцвэр нь бүр эрт үеэс Их Цагаан Хэрэмээр хиллэдэг Хойд талын нүүдэлчин Монгол болон Өмнөд талын суурин Хан үндэстний хооронд үүссэн байна. Жишээлбэл, МТӨ 2200 оны үед эртний Хятадын Ся Хаант улс, Монголын өвөг болох Хүннү улс бараг зэрэг оршин тогтнож байсан байна. МТӨ 1766 онд Хүннү улс тухайн үедээ хүчтэй болж байсан Хятадын Жоун улсын эсрэг тэмцэж байсан Ся улсын хойч болох, Зүүн Хятадын Шан улстай /МТӨ 19 дүгээр зууны үед хүчирхэг байсан/ цэргийн холбоо тогтоож байсан байна.

Өнгөрсөн түүхэн хугацаанд ЗХА дахь улс орнуудын харилцаа нь дайн байлдаан, эвлэрэл найрамдал, худалдаа наймааны хэлбэрээр байнга эргэлдэж, түүний үр дүнд аль нэг орны ноёрхол хүчтэй болох буюу дотоодын хямрал, задралын улмаас аль нэгний хүч суларч өөр нэг нь хүчтэй болох, эсвэл хүчтэй ноёрхогчийн эсрэг хэд хэдэн орон эвлэрэлдэн эвсэх замаар хүчний тэнцвэр хадгалагдах буюу аль нэг хүчтэнд шилжих байдлаар явж ирсэн байна. Жишээлбэл, 13-16 дугаар зууны үед Монголын Эзэнт Гүрний, 17-19 дүгээр зууны үед Манж Чин Эзэнт гүрний, 19 дүгээр зууны эхнээс Оросын Эзэнт Гүрний Зүүн Азид явуулсан идэвхтэй эзлэн түрэмгийлэх гадаад бодлогын, 20 дугаар зууны эхнээс Дэлхийн 2 дугаар дайны эцэс хүртэл Японы Милитаризмын, түүний дараа 70 гаруй жилийн хугацаанд Оросын Эзэнт Гүрний хуучин гадаад бодлогыг үргэлжлүүлсэн ЗХУ-ын ноёрхол, хамгийн сүүлчийнхээр, Дэлхийн 2 дугаар Дайнаас хойшхи худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, цэргийн салбар дахь АНУ-ын үйл ажиллагаа болон Японы эдийн засгийн хөгжил, 1980 оноос эхэлсэн Хятадын эдийн засаг, цэргийн шинэчлэл давамгайлж байна.

Зүүн хойд Азийн олон улсын харилцааны гол онцлог бол тэрээр дэлхийн дөрөн их хүчитнүүдийг агуулж байгаад оршино.

Түүхэн харилцааны үр дагавар, шинэ хүчтэн үүсэн бий болж байгаа болон үндэстнүүдийн үзэл суртал, ашиг сонирхлын зөрүү зэргээс шалтгаалан ЗХА-д өнөөг хүртэл батлан хамгаалах, аюулгүй байдлын олон асуудлууд үргэлжлэн оршсоор байна. Жишээлбэл, Тайваны Булан болон Солонгосын Хойгийн асуудлууд. Зарим хүмүүс Хятадын өсөн нэмэгдэж байгаа эдийн засгийн хүч чадал нь цэрэг, дайны чадавхыг эрс нэмэгдүүлнэ гэж үздэг. Хятадын удирдагчид АНУ-ыг үндэстний эргэн нэгдэх болон бүс нутгийн асуудалд Хятадын гүйцэтгэх үүрэгт саад болж байна гэж үзэж байгаагаас асуудлыг улам хүндрүүлж байна. Тайваныг Хятад улс өөртөө нэгтгэхээр цэргийн хүч хэрэглэхгүй байсан ч гэлээ

Тайваны Булангийн хурцадмал байдал хэдэн жил үргэлжлэх төлөвтэй. БНАСАУ-ын хувьд түүний удаан хугацаанд оршин тогтнох нь эргэлзээтэй боловч түүний нуруулт нь мөргөлдөөн үүсгэх эрсдэлд хүргэж болзошгүй бөгөөд тэр нь Өмнөд Солонгоын хувьд эдийн засаг, улс төрийн урьдчилан төсөөлөөгүй асуудалд хүргэж, бүс нутгийн тэнцвэрт өөрчлөлт оруулж магадгүй юм.<sup>3</sup>

Зүүн хойд Ази болон Ази Номхон Далайд АНУ одоогийн байдлаар эдийн засаг, батлан хамгаалах хүрээнд хамгийн хүчтэй нь болж байна. Уг бүс нутагт мөн АНУ-ын цэргийн байршил хэвээр байна. Зүүн Ази болон Номхон Далайн бүс нутаг дахь АНУ-ын стратегийн гол зорилго нь улс төрийн тогтвортой байдлыг хангах, бүс нутгийн зах зээлд оролцох, навигацын чөлөөт байдлыг хангах, аливаа дайсагнасан ноёрхол бий болохоос урьдчилан сэргийлэх явдал гэж үздэг. Азийн үндэстнүүдийн эдийн засгийн чадавхийг өөрийн эсрэг дайсанасан цэргийн хүч болгон хувиргахгүй байх явдлыг хангахыг АНУ чармайж байна. Тийм учраас АНУ-аас Өмнөд Солонгос, Японтой байгуулсан хоёр талын холбоо нь цаашид үргэлжлэх магадлалтай. Гэвч АНУ-ын цэргийн байршил болон Япон, Солонгостой тогтоосон холбоог Хятадын нутаг дэвсгэрийг эргэн нэгтгэхэд саад болж байна гэж Хятадын удирдагчид үзэх хандлагатай байна. Тийм учраас Хятадын удирдагчид АНУ-ын стратегийн зорилго, үйл ажиллагаанд үнэнээсээ сэжигтэй хандаж байгаа юм. Бээжингийнхан АНУ-д төвлөрсөн ноёрхол болох нэг туйлт үзэл баримтлал гэхээс олон туйлт үзэл баримтлалын хандлагад итгэж байгаа юм. Жишээлбэл, Хятад улс АНУ-Японы дахин тодорхойлсон холбоог Вашингтон-Токиогоос Ази номхон далайн бүс нутагт ноёрхох зөн гэж үзэж байна.

Мөн Хятадын цөмийн зэвсэг, балластик пуужингийн агуулах, Хойд Солонгосын сэжиг бүхий цөмийн зэвсэг, балластик пуужингийн хөгжлийн хөтөлбөр, Оросын цөмийн зэвсгийн зэрэглэлийн материалын менежементийн хангалтгүй байдал, Хятадын далайн эрдэм шинжилгээний болон усан цэргийн онгоцуудын өсөн нэмэгдэж байгаа үйл ажиллагаа, Хойд Солонгосын "Хүчтэй Армийн баримжаат үндэстэн" байгуулах төлөвлөгөө, Оросоос Хятадад болон бүс нутгийн бусад орнуудад экспортлож байгаа зэр зэвсэг, Тайваны цэрэг зэвсгийн хөгжил, Тайванийг эргэн нэгтгэх гэсэн Хятадын бодлого зэрэг аюулгүй байдлын олон асуудлууд байсаар байна.

Гэвч аюулгүй байдлын эдгээр асуудлуудыг одоогийн байдлаар туйлын ноцтой байна гэж хэлж болохгүй. Бодит байдал дээр бүх гол хүчитнүүдэд аюулгүй байдал, эдийн засгийн шалтгааны улмаас хамтын ажиллагаа нэн шаардлагатай байгаа нь тодорхой байна. Ялангуяа, дээр дурьсан дөрвөн гол хүчитнүүдийн хоорондын хамтын ажиллагаа нь дэлхийн болон Зүүн хойд Азийн тогтвортой байдалд онцгой ач холбогдолтой. Өөрийн нутаг дэвсгэрийн төв байршил, эдийн засгийн чадавхи, улс төр, цэрэг зэвсгийн хязгаарлагдмал

нөлөөний хувьд Япон улс энэ бүс нутаг дахь олон талын харилцан яриа хэлэлцээр, эдийн засгийн хамтын ажиллагаанд хурдасгагчийн үүрэг гүйцэтгэх боломжтой. Тэр нь бүс нутгийн улс төр, аюулгүй байдлын тогтвортой байдалд түлхэц болно. Эдийн засаг, батлан хамгаалах, аюулгүй байдлын хүрээнд бүс нутгийн олон талын хамтын ажиллагааны төлөө олон санаачлагууд ч мөн гарсаар байна. Зүүн хойд Азид хамтын ажиллагааны олон талын механизмыг бий болгоход гол хүчитнүүдийн ашиг сонирхлын давхцал нэн чухал. Зүүн хойд Ази дахь одоогийн үйл явц ч олон улсын харилцааны нэгдмэл ашиг сонирхлыг бий болгох эрэл хайгуулын чиглэлд хандаж байна.

АНУ-Япон, АНУ-БНСУ-ын хоорондын хоёр талын холбоо нь эдгээр гурван орныг аюулгүй байдлын талаар хамтран ажиллах боломж олгож байна. Зүүн хойд Ази дахь олон талын хамтын ажиллагаанд эрчим хүчний хүрээнд хамтран ажиллах явдал магадгүй хамгийн ирээдүйтэй байж болох юм. Мөн Түмэн голын сав газар, Шар тэнгэсийн булангийн хөгжил, Сибир, Охотскийн тэнгэсээс байгалийн хийн хоолой байгуулах, байгаль орчны бохирдлоос хамгаалах зэрэг нь мөн олон талын хамтын ажиллагааны чухал асуудлууд болно. Бүс нутгийн яриа хэлэлцээний ирээдүй нь үндэстнүүдийн ашиг сонирхол, Засгийн газруудын хүсэл эрмэлзэл, тэдгээрийн тэргүүлэх хүчин чармайлтаас хамаарах болно.

Ази Номхон Далайн Хамтын ажиллагаа /АПЕК/, Зүүн Өмнөд Азийн Холбоо /АСЕАН/ нь ерөнхийдөө аюулгүй байдлын гэхээсээ эдийн засгийн асуудлуудад хандаж, бодит үйл ажиллагаа гэхээсээ хэлэлцээний форум хийх байдлаар ажиллаж байна. АСЕАН нь АСЕАН бус орнуудтай яриа хэлэлцээ хийхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа юм. Түүний нэг жишээ болох "АСЕАН+3" /Хятад, Япон, Өмнөд Солонгосыг оролцуулан/ дээд хэмжээний уулзалтыг Ерөнхий сайд нарын түвшинд зохион байгуулж байгаа нь Зүүн хойд Азийн гол хүчитнүүдийг тогтмол уулзуулах боломж олгож байгаагаараа онцлог юм. "АСЕАН+3"-ын хүрээнд хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Зүүн Азийн хамтын ажиллагааг өөд татах "Түншлэл", "Нээлттэй бүс нутгийн хамтын ажиллагаа", "Улс төр-Аюулгүй байдлын хүрээний яриа хэлэлцээр, хамтын ажиллагаа" гэсэн гурван зарчмыг Японы Засгийн газар зарласан байна.

Зүүн хойд Азид олон талын хамтын ажиллагааны механизм бий болгохын тулд бид зөвхөн Зүүн хойд Ази гэлгүй тийм механизм хэдийнээ үйлчилж байгаа Зүүн хойд Ази, Зүүн, Зүүн өмнөд Азийг хамарсан Зүүн Ази мэт өргөн хүрээтэй нутаг дэвсгэрийг харах хэрэгтэй. Тэнд АСЕАН-ы Бүсийн Форум /АРФ/, Ази Номхон Далайн Аюулгүй байдлын хамтын ажиллагааны Зөвлөл /ESCAP/, Хоёр-Мөрт-Хэлэлцээ зэрэг бүс нутгийн аюулгүй байдлын асудлаархи механизм Ази Номхон Далайд хэдийнээ үйлчилж байна. Эдгээрийн сүүлчийн хоёр нь эрдэмтэд, төрийн бус байгууллагуудаас бүрэлддэг. АРФ нь Засгийн газруудыг төлөөлдөг бөгөөд гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нар түүнийг удирддаг, Азийн бүх бүсийн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцэж байх форумыг бүрэлдүүлэх зорилготой. Зүүн өмнөд

Азийн зарим орнууд тус форумын гишүүн орнуудаас гадна, гишүүн бус орнуудаар тойруулан хурлыг удирдуулж байх чиглэлээр АРФ-ын дүрмийг сайжруулж болох боломжийг харгалзан үзэж эхэлж байна. Энэ бол зөв санаа бөгөөд эхний шатанд түүнийг Зүүн хойд Азийн гол хүчигнүүдийн хооронд /гадаад хэргийн сайд нарын түвшинд/ яриа хэлэлцээ хийж байх форум болгон ашиглаж байгаад дараа шатанд түүний гишүүнчлэлийг өргөжүүлж болох юм.

Эдийн засгийн хувьд Зүүн хойд Азийн байдал Азийн санхүүгийн хямралын дараа 1998 оноос хойш ерөнхийдөө сайжрах хандлагатай байгаа бөгөөд дунд болон урт хугацаанд сайн болох төлөвтэй байна. Зүүн хойд Азийн эдийн засгийн хөгжлийн нэг чухал онцлог бол Хятад улсын эдийн засаг Азийн санхүүгийн хямралд өртөөгүй бөгөөд Хятад улс 2010 оны түвшинд дэлхийн хамгийн том эдийн засагтай орон болох хандлагатай байгаад оршино. Хятад улс ДХБ-ын гишүүн болсноор тэр нь зөвхөн Хятадын өөрийнх нь ирээдүйн хөгжилд төдийгүй бүх нутгийн, ялангуяа зүүн хойд Азийн эдийн засгийн хөгжилд нөлөөлнө.

#### **Б. Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны механизм тогтвортой хөгжлийн чиглэлд**

1992 оны НҮБ-ийн «Орчин ба Хөгжил» дэлхийн дээд хэмжээний чуулган /UNCED/ болон Дэлхийн 21 дүгээр зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр нь тогтвортой хөгжлийн талаархи олон талын хамтын ажиллагааг даян дэлхий, бүс нутаг, үндэстэн болон орон нутгийн түвшинд дэмжих хамтарсан чармайлтуудыг бий болголоо. Зүүн хойд Азийн орнууд шинэ зууны ирээдүйд хандсан гол үйл ядлуудтай идэвхтэйгээр хөл нийлүүлэн алхаж явна.

Зүүн хойд Ази дахь тогтвортой хөгжлийн үнэлгээтэй холбогдуулан Японы Даян дэлхийн байгаль орчны стратегийн институтээс 2001 онд бэлтгэсэн тайланд түүний хүрсэн гол амжилт, авсан сургамж, тохиолдож байгаа гол бэрхшээл, зохион байгуулалт, санхүүгийн шинэ шаардлага, боломжууд болон хэрэгжүүлэх механизмын талаар тодорхой тусгасан байна.<sup>6</sup>

Хятад, Япон, Өмнөд Солонгос, Монгол улс үндэсний болон орон нутгийнхаа 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг боловсруулсан байна. Японы Байгаль орчны үндсэн төлөвлөгөө, Өмнөд Солонгосын 21 дүгээр зууны Ногоон үзэл баримтлал, БНАСАУ-ын Байгалийн нөөцийг хадгалах, тогтвортой ашиглах үндэсний стратеги зэрэг байгаль орчинтой холбогдсон төлөвлөгөө, стратегийг боловсруулан хэрэгжүүлж байна.

Бүс нутгийн бүх орнууд 1992 оны НҮБ-ийн «Орчин, Хөгжил» дээд хэмжээний уулзалтын өмнө болон түүний дараа батлагдсан байгаль орчны талаархи олон талын гэрээ, хэлэлцээрүүдэд нэгдэн орсон буюу баталсан байна. Үүнд:



- Озоны цооролтоос хамгаалах Венийн Конвенц /1985/
- Озоны цооролтод нөлөөлөх бодисын талаархи Монреалын Протокол /1987/
- Хорт хаягдлын хил дамжсан хөдөлгөөнд хяналт тавих, түүнийг арилгах Базелийн Конвенц /1989/
- Биологийн төрөл зүйлийн талаархи НҮБ-ийн Конвенц /UNCBD/, /1992/
- Ховордсон төрөл зүйлийн олон улсын худалдааны талаархи Конвенц /CITES/, /1973/
- Цаг уурын өөрчлөлтийн талаархи НҮБ-ийн Конвенц /UNFCCC/, /1992/
- Цөлжилттэй тэмцэх НҮБ-ийн Конвенц /UNCCD/, /1994/
- Хөлөг онгоцны бохирдлоос урьдчилан сэргийлэх олон улсын Конвенц /MARPOL/, /1973/, түүний 1978 оны шинэчилсэн протокол
- Эмэгтэйчүүдийн эсрэг ялгаварлан үзэх бүх төрлийн хэлбэрийг арилгах Конвенц /CEDAW/, /1989/
- Дэлхийн соёл, байгалийн өвийг хамгаалах Конвенц /1972/
- Далайн Конвенцийн тухай хууль
- Ази Номхон Далайн Загасчлалын Комисс байгуулах тухай Гэрээ зэрэг болно.

1992 оноос хойш Зүүн хойд Ази, Зүүн Ази болон Ази Номхон Далайн бүсэд байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлаархи бүс нутгийн Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны олон механизмууд бий болсон байна. Үүнд:

- Байгаль орчны хамтын ажиллагааны Зүүн хойд Азийн бүсийн хөтөлбөр
- Байгаль орчны хамтын ажиллагааны Зүүн хойд Азийн Конференц
- Номхон далайн баруун хойд бүсийн болон түүний эрэг хавийн байгаль орчны хамгаалал, менежемент, хөгжлийн төлөвлөгөө
- Түмэн голын сав газрыг хөгжүүлэх хөтөлбөр
- Төрийн бус байгууллагуудын сүлжээ болох Хойд Ази-Номхон далайн байгаль орчны түншлэл
- Ази Номхон далайн Байгаль орчны конгресс
- Дэлхийн өөрчлөлтийн эрдэм шинжилгээний Ази-Номхон далайн сүлжээ
- Зүүн Азийн Хүчлийн хуримтлалын Мониторингийн сүлжээ
- 2000 онд Ази Номхон далайн Сайд нарын түвшинд баталсан Байгаль орчинд халгүй тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны бүс нутгийн хөтөлбөр зэрэг багтаж байгаа юм.

21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд цаашид хүчин чармайлт тавих олон асуудлууд байна. Зүүн хойд Азид ялангуяа Хятад, Монгол улс газрын элэгдэл, цөлжилтөд ноцтой өртөж байна. Хоёр улс аль аль нь цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрөө боловсруулсан байна. Одоогийн байдлаар Зүүн хойд Азид биологийн төрөл зүйлийг хамгаалах талаархи хамтын ажиллагааны тусгай механизм байхгүй байна.

Харин, Зүүн Азийн хүчлийн хуримтлалын мониторингийн сүлжээ, Зүүн Азийн агаар мандлын төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааны сүлжээ зэрэг хил дамжсан бохирдлын асуудалтай холбогдсон үүсэл санаачлагууд нилээд байна.

Одоогийн байдлаар Зүүн хойд Азид бүс нутгийн түвшинд усны асуудалтай холбогдсон тусгай механизм байхгүй байна. Харин, Ази номхон далайн байгаль орчны конгресс болон Дэлхийн өөрчлөлтийн эрдэм шинжилгээний Ази-Номхон далайн сүлжээ, Зүүн Азийн хүчлийн хуримтлалын мониторингийн сүлжээ, Номхон далайн баруун хойд бүсийн далайн болон түүний эрэг хавийн байгаль орчны хамгаалал, менежемент, хөгжлийн төлөвлөгөө зэрэг Зүүн хойд Ази болон түүний эргэн тойрны байгаль орчинд хяналт тавих, мониторинг хийх олон механизмууд бий болж байгаа нь дэвшилттэй хэрэг юм.

Түүнээс гадна Технологи шилжүүлэх Ази номхон далайн төв, цэвэр үйлдвэрлэлийн талаархи Ази номхон далайн дугуй ширээний ярилцлага, Байгаль орчны хамтын ажиллагааны Зүүн хойд Азийн бүсийн хөтөлбөрийн хүрээнд байгуулагдсан нүүрсээр галладаг цахилгаан станцуудын бохирдлыг бууруулах Зүүн хойд Азийн төв болон НҮБ-ийн Олон улсын байгаль орчны технологийн төв зэрэг механизмууд технологи шилжүүлэлт, цэвэр үйлдвэрлэлийн хүрээнд хэдийнээ үйлчилж байна.

## **В. Зүүн хойд Ази дахь хамтын ажиллагааг тогтвортой хөгжлийн чиглэлээр сайжруулах үндсэн бүтэц / зөвлөмж/**

**Зорилго:** Энэхүү үндсэн бүтцийн зорилго нь ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны ерөнхий зорилтуудыг томъёолж, тэдгээрийг байгаль орчиндоо зохицсон тогтвортой хөгжлийн үндсэн зарчмуудад нийцүүлэн хэрэгжүүлэх зарчим, арга механизмуудыг тодорхойлоход оршино.

### **Үндсэн зарчмууд**

**Тогтвортой хөгжлийн олон талт зорилтуудыг харгалзан үзэх:** Зорилтууд нь нэг хүн амд үндэсний орлогыг нэмэгдүүлэх, г.м. зөвхөн эдийн засгийн төдийгүй амьдралын чанарыг сайжруулах, хүний үндсэн хэрэгцээг хангах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх, боловсрол олж авах, олон нийтийн амьдралд улам илүү оролцох, адил тэгш байдал, тэнцвэртэй, тогтвортой экосистем, цэвэр, найдвартай орчныг хангах, байгалийн нөөцийг хаягдалгүй үр ашигтай ашиглах, байгалийн төрөл зүйлийг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтөд нөлөөлж

байгаа хүчин зүйлээс сэргийлэх зэрэг нийгмийн болон экологийн, улс төрийн үйл явцад тодорхой зорилготой оролцох чадавхи, төр засгийн газрын шийдвэр гаргахад иргэдийн оролцоо, соёлын өв, үнэт зүйлсийг хадгалах, соёл урлагийг баяжуулан хөгжүүлэх, шашин, ёс суртахуун, зан заншлын өвийг хөгжүүлэх зэрэг улс төр, соёл, оюуны хүрээг хамаарна. Бүс нутгийн экосистемийн бүтэн байдал, эдийн засгийн бааз суурьт нөлөөлөх хүний хөгжлийг онцгойлон авч үзсэн тусгай зорилтууд болон үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий Зүүн хойд Азийн бүс нутгийн иж бүрэн стратегийг боловсруулах явдал зайлшгүй шаардлагатай.

**Өөрсдийнхөө ялгааг хүлээн зөвшөөрч, баялаг олон төрөл зүйлийн дунд хамтран амьдарцгаах. /буюу системийн зарчмуудыг харгалзан үзэх/:** Дэлхий Ертөнц, амьдралаа түүний бүх төрөл зүйлээр нь хүндэтгэх. Дэлхийн экологийн системийн бүтэн байдал, ялангуяа биологийн төрөл зүйл, амьдралыг тогтвортой тэтгэх байгалийн процессийг хамгаалах, сэргээх нь нэн чухал байна. Түүний зэрэгцээ хувь хүмүүсийн соёлыг баяжуулах, олон талт соёлын нэгдэл нягтралыг дээшлүүлэх, орон нутгийн онцлогийг нээн илрүүлэх, тодорхой хүрээний дотор бие даан стратегийн шийдвэр гаргах, юуны өмнө өөрийнхөө нөөцөд тулгуурлан асуудлыг шийдвэрлэх, авъяас чадавхаа шинэчлэлийн процесстой интеграцчлах зэрэг чадавхийг хөгжүүлэх асуудал улам бүр чухалчлагдаж байгаа юм.

**Одоогийн байгаа хамтын ажиллагааны хэлбэрүүдийг "үе шаттайгаар" тогтвортой хөгжлийн чиглэлд бэхжүүлэх:** Улс төр, аюулгүй байдлын хүрээнд: АПЕК, АСЕАН болон АСЕАН+3 /Хятад, Япон, Өмнөд Солонгосыг шинээр оролцуулсан/, АСЕАН -ы бүсийн форумын хүрээн дахь одоогийн яриа хэлэлцээг эхний ээлжинд Зүүн хойд Азийн гол хүчнүүдийн хооронд /гадаад хэргийн сайд нарын түвшинд/ харилцан ойлголцлын форум болгон ашиглаж, дараачийн шатанд түүний гишүүнчлэлийг өргөжүүлэх хэрэгтэй байна.

Эдийн засгийн хүрээнд: АСЕАН-ы гишүүн орнууд АСЕАН-ы Чөлөөт худалдааны Бүс /АФТА/ болон АСЕАН-ы Аж үйлдвэрийн хамтын ажиллагааны схем /АICO/ зэрэг механизмуудыг Ази дахь худалдаа, хөрөнгө оруулалтын чиглэлээр өргөжүүлэх нь чухал. Түүний зэрэгцээ макро эдийн засгийн бодлогын зохицуулалт, бүс нутгийн санхүүгийн байгууллага, нэгдсэн мөнгөний сагс бий болгох болон худалдааг өргөжүүлэх чиглэлээрх яриа хэлэлцээг үргэлжлүүлэх асуудал зайлшгүй шаардлагатай. Энэ арга хэмжээний хүрээнд Өмнөд Солонгос улсын санаачилсан чөлөөт худалдааны үзэл баримтлалын дагуу хамтарсан эрдэм шинжилгээний төслийг дэмжин хөгжүүлж, тэрхүү санааг цаашид бусад орнуудад өргөжүүлэн хэрэгжүүлэх, гэхдээ энэ ажлыг харилцан ойлголцох гэрээгээр эхлэх нь зүйтэй.<sup>9</sup> Бүс нутгийн доторхи интеграцлал /бүсийн доторхи нэгдмэл системийн хөгжил/ нь тогтвортой эдийн засгийн хөгжилд чухал хүчин зүйл болно.

Нийгэм, байгаль орчны салбарт: Ялангуяа хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, шинэ технологийг хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, байгаль орчны өөрчлөлтийн талаар хамтарсан эрдэм шинжилгээний ажил явуулах, хөгжиж байгаа орнуудад тогтвортой хөгжлийн үндэсний стратегиа боловсруулах, хэрэгжүүлэх чадавхийг бүрдүүлэхэд нь туслалцаа үзүүлэх, дэлхийн байгаль орчин, тогтвортой хөгжлийн асуудлуудыг олон талын гэрээ, хэлэлцээрүүдэд интеграцчлах явдлыг хангах нь чухал. Бүс нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа олон санаачлагуудын харилцан уялдаагүй байдлаас сэргийлэх зорилгоор тухайн бүсийн механизмуудын хамтарсан форум, төрөл бүрийн хөтөлбөрүүдийг хооронд нь үр ашигтай интеграцчлах, бүс нутгийн орнуудын үйл ажиллагааг зохицуулахад чухал зуучлагчийн үүрэг гүйцэтгэх олон улсын байгууллагуудын зүгээс дэмжлэг үзүүлэх явдлыг хангах зохицуулалтын механизмыг хөгжүүлэх шаардлагатай. Тэдгээр механизмуудад бүс нутгийн хамгийн чухал асуудлууд болон хөтөлбөрүүдийг хамааруулан хэрэгжүүлж болох юм.

Экологийн системийн олон төрөл зүйл, цогц байдал, байгалийн гамшигийн механизмууд, тэдгээрийн олон улсын хэмжээний шинж чанар нь тухайн технологийн хяналт, шинжилгээ, хөгжлийн асуудлуудыг дэмжих олон улсын хамтын ажиллагааг шаардаж байна. Түүний зэрэгцээ мэдээлэлийн технологийг ашиглах замаар шинжлэх ухааны мэдээлэлийн баазыг хуваалцах, тэдгээрийн дэлхий даяар ашиглах боломж олгох шаардлага тавигдаж байна. Зүүн хойд Ази болон түүний гаднах байгаль орчны хяналт, мониторингийн одоогийн байгаа механизмуудыг бэхжүүлж, үйл ажиллагааных нь хүрээг өргөжүүлэх шаардлагатай байна. Одоо байгаа эдгээр механизмуудын зэрэгцээ тус бүс нутагт мониторинг, үнэлгээний үйл ажиллагаа болон бодлого боловсруулах бодит үйл явцыг хооронд нь холбох талаар шинэлэг бүтээлч арга механизмыг бий болгох хэрэгтэй. Цөлжилт, газрын элэгдэлтэй тэмцэх бүс нутгийн хамтын ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор цаг уурын өөрчлөлтийн одоогийн механизмын хүрээнд цөлжилтөд нөлөөлөгдсөн болон шууд нөлөөлөгдөөгүй боловч асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмрээ оруулах чадавхтай бусад орнуудтай хамтарсан чармайлт гаргах боломжийг ашиглаж болох юм. Үүнтэй холбогдуулан Киотогийн механизм болон бусад механизмуудын боломжийг бүс нутгийн түвшинд өргөжүүлэн ашиглаж болно. Түүний зэрэгцээ бүс нутгийн хамтын ажиллагаанд цөлжилттэй тэмцэх НҮБ-ийн конвенцийн хэрэгжилтэд анхаарч, Зүүн хойд Ази дахь сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээг сайжруулан бэхжүүлэх хэрэгтэй. Ялангуяа, "Цөлжилтийн мониторинг, үнэлгээ"-ний талаар Хятадад зохион байгуулсан сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээ-1 болон Монголд зохион байгуулах "Гангийн нөлөөллийн менежемент, цөлжилтийн хяналтын чадавхийг сайжруулах" Сэдэвчилсэн хөтөлбөрийн сүлжээ-5-ыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх шаардлагатай.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах үйл ажиллагаанд оролцогч үндэстнүүдийг хамарсан сүлжээ байгуулах, мэдээлэл, туршлагаа солилцох форум болж чадах семинар

зөвлөлгөөнүүдийг мөн зохион байгуулах шаардлагатай. Ийм төрлийн механизмуудыг ашиглах явдал нь хил дамжсан хамгаалалттай газруудын хүрээг тодорхойлох, экологийн хувьд чухал бүсүүд болон бүсийн хэмжээний төрөл зүйл, тэдгээрийн орчны нөхцлийг тогтоох боломжийг улс орнуудад олгоно. Урт хугацаанд бүс нутагт үйлчлэх гэрээ, хэлэлцээрүүд нь Байгаль, байгалийн нөөцийг хамгаалах АСЕАН-ы гэрээ, Генетикийн болон биологийн нөөцийг ашиглах АСЕАН-ы протоколын бүтэцтэй төстэй байж болох юм.

Ялангуяа ЗХА дахь усны асуудалтай холбогдуулан туршлагаа харилцан хуваалцах, усны тогтвортой менежементийн ерөнхий зарчмууд болон тавигдах шаардлагуудыг тогтоох боломж олгох механизмуудыг бий болгох хэрэгтэй. Үүнд, гол мөрний дайран өнгөрөх өөр өөр улсуудын усны удирдлагыг зохицуулж байх зорилгоор түүний сав газрыг бүрэн хамааруулсан усны менежементийн стратегийн төлөвлөгөө боловсруулж, гол мөрний эхнээс адгийг нь хүртлэх маргаантай асуудлыг шийдвэрлэх боломж олгох хэлэлцээний механизм бий болгох шаардлагатай. Эдгээр механизмууд нь улс орнууд, олон улсын байгууллага, төрийн бус болон бусад сонирхогч бүлгүүдийг хамарсан байх ёстой.<sup>6</sup>

Зүүн Азийн хүчлийн хуримтлалын мониторингийн сүлжээ болон Зүүн Азийн агаар мандлын үйл ажиллагааны сүлжээ зэрэг одоогийн механизмуудын үйл ажиллагааг сайжруулж, тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааг хангах арга замыг хөгжүүлэх нь тогтвортой хөгжлийн бүс нутгийн үр ашигтай хамтын ажиллагаанд түлхэц болно. Зүүн хойд Азид хөгжлийн түвшингээр өөр өөр улс орнууд хамаарч байгаа учраас илүү хөгжилтэй орноос доогуур хөгжилтэйд нь технологи шилжүүлэх боломжтой бөгөөд энэ нь аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн процессийг, ялангуяа жижиг дунд үйлдвэрийг хаягдлаа багасгах, цэвэр үйлдвэрлэл явуулах чиглэлээр сайжруулах боломж олгоно.<sup>6</sup>

Дээр дурьсан боломжууд, шаардлагатай арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дараах дөрвөн үе шатаар дэмжиж болох юм.

**Нэгдүгээр үе шат:** Татах хүч бий болгох. Зүүн хойд Азийн бүх гол шинж чанаруудыг харгалзан үзвэл бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах зайлшгүй шаардлага тавигдаж байна. Бүс нутгийн тогтвортой хөгжлийн хамтын ажиллагаанаас орон бүр улс төр, эдийн засаг, нийгэм, экологийн үр ашгийг хүртэх болно. Өөрөөр хэлбэл, орон бүрийг тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны чиглэл рүү татах хүч байна гэсэн үг юм. Тэр нь бүс нутгийн тогтвортой хөгжлийг дээшлүүлэх улс төрийн хүсэл эрмэлзлийг бий болгох урьдчилсан нөхцөл болно. Гэвч одоогийн байдлаар ЗХА-д эдийн засаг буюу тогтвортой хөгжлийн гэхээсээ улс төр, аюулгүй байдлын шинжтэй зарим асуудлууд оршсоор байна.

**Хоёрдугаар үе шат:** Зүүн хойд Азид бүс нутгийн тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааны ач холбогдлыг ойлгож, түүнийг бүрэлдүүлэхийн төлөөх улс төрийн хүсэл эрмэлзлийг бий болгох. Зүүн хойд Азийн бараг бүх орнууд тогтвортой хөгжлийн төлөөх улс төрийн амлалтаа гаргаж, тогтвортой хөгжлийнхөө Үндэсний зөвлөлүүдийг байгуулсан. Энэ нь улс төрийн хүсэл эрмэлзэл бий болох чухал урьдчилсан нөхцөл болно. Түүний зэрэгцээ ЗХА дахь бүс нутгийн хамтын ажиллагааны санаачлага, механизмууд мөн чухал. Дээр дурьснаар энэ үе шат руу хөдөлгөж байгаа олон санаачлага, механизмууд одоо байна. Азийн гол хүчигнүүдийн удирдагчид энэ талаар юм хийх зайлшгүй шаардлагатай болсон гэдийг мэдэрч байгаа байдалтай. Жишээ нь Хятадын Ерөнхийлөгч Зин Зиамин "Бид, Азийн орнууд үндэсний өөр өөр нөхцөлд байгаа боловч байгаа боломжийг ашиглах, зайлшгүй шаардлагыг даван туулах, эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийн төлөө ажиллах нэгдмэл үүрэгтэй тулгарч байна." гэжээ. Мөн Хятадын Ерөнхий сайд Жү Рон Жи "Хятад улс Зүүн Азигүйгээр, Зүүн Ази ч Хятадгүйгээр хөгжиж чадахгүй" гэж тус тус онцлон тэмдэглэсэн билээ. Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч, Чөлөөт худалдаа, Чөлөөтэй харилцан зорчих бүс байгуулах талаар Япон, Хятадад хандаж, "Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагааны систем" байгуулах санал тавьсан.

Гэвч харамсалтай нь ЗХА дахь өнөөгийн аюулгүй байдал нь асуудлыг шийдвэрлэж чадахгүй харин ч улам хүндрүүлж байна. Хоёр болон олон талын батлан хамгаалах холбоод /АНУ-Японы Аюулгүй байдлын хэлэлцээр г.м./ нь Тайваний асуудлыг шийдвэрлэх хууль эрх зүй, улс төрийн үр ашигтай хэрэгсэл болж чадахгүй байна. АСЕАН-ы Бүсийн Форум болон АПЕК ч энэ чиглэлд улам үр дүн бага байна. Эдийн засаг, цэрэг-улс төрийн нэгдсэн байгууллага байхгүй байгаагаас алан хядлагын шинж чанартай шинэ удирдагчид болон "тоглогчдыг" бий болгож болох уур амьсгалд хүргэж болзошгүй байна.<sup>12</sup>

**Гуравдугаар үе шат:** Хөдөлгөгч хүч байх. Бүс нутагт тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор дор хаяад чадавхи бүхий нэг орон буюу олон улсын байгууллага тэрхүү үзэл баримтлалын хэрэгжилтийг хурдасгах санаачлагыг гартаа авах шаардлагатай. Үүнд Зүүн хойд Азид Япон улс хамтын ажиллагаа, интеграцчлалын бүтцийг санаачлах чадавхтай юм. Японы эдийн засгийн чадавхи нь Зүүн хойд Азийн эдийн засгийн тогтворжилт, бүс нутгийн эдийн засгийн бүтцийг бүрэлдүүлэхэд хувь нэмрээ оруулж, тэгснээр улс төр, аюулгүй байдлын тогтворжилтод ч нөлөөлөх болно. Японы хувьд зах зээлээ улам чөлөөтэй болгох, эдийн засгаа өөрчлөн дэлхийн өрсөлдөөнд нээлттэй болгох, удаан хугацааны эдийн засгийн уналтаас хурдан гарах, ялангуяа бүс нутгийн хөгжиж байгаа орнуудаас илүү итгэл хүлээх зэрэг шаардлагууд тавигдаж байгаа юм. Гэвч, Японы сонирхол хэрэв байхгүй бол АНУ, Хятадын аль алин ч Японы ашиг сонирхлын төлөө санаа зовохгүй биз. Япон улсын байр суурь нэмэгдэх явдал нь өрсөлдөөнийг гэхээсээ илүү бүс нутаг дахь олон талын яриа хэлэлцээр, эдийн засгийн хамтын ажиллагааг улам илүү өдөөх

магадлалтай. Энэ нь Япон улс өнөөгийн байдлаар эдийн засгийн өндөр чадавхтай боловч улс төр, цэргийн хувьд дутагдалтай байгаатай холбоотой. Өөрөөр хэлбэл Япон улс бүс нутагтаа өөрийн ноёрхолыг тогтоохыг хүслээ ч гэсэн түүнийгээ хэрэгжүүлэх боломжгүй юм. Гэхдээ Япон нь Азийн орнуудад нэн хэрэгцээтэй байгаа эдийн засгийн өндөр чадавх, технологитой. Тийм учраас Япон улс Зүүн хойд Азид эдийн засгийн хамтын ажиллагааг хурдасгах санаачлагыг гартаа авах орон гэж дүгнэж болно. Түүний зэрэгцээ 1992 оны Рио Де Жанерогийн «Орчин ба Хөгжил» Дээд хэмжээний чуулга уулзалтаас хойш дэлхий нийтээр болон ЗХА-д даян дэлхий, үндэстэн, бүс нутаг, орон нутгийн түвшинд тогтвортой хөгжлийн өргөн хүрээ бүхий хөдөлгөөн, санаачлагууд өрнөсөөр байна. Энэ нь 2002 онд Өмнөд Африкийн Йоханнесбург хотноо болох тогтвортой хөгжлийн Дэлхийн Дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлын санаачлагуудаар улам идэвхжиж байна.

**Дөрөвдүгээр үе шат:** Тогтвортой хөгжлийн хамтын ажиллагааг бүс нутгийн түвшинд зохицуулах зайлшгүй шаардлагын талаар тохиролцоонд хүрэх. Улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн хүрээнд АПЕК, АСЕАН болон АСЕАН+3 /Хятад, Япон, Өмнөд Солонгосыг оролцуулсан/, АСЕАН -ы бүсийн форум зэрэг хүрээн дахь одоогийн яриа хэлэлцээг эхний ээлжинд Зүүн хойд Азийн гол хүчнүүдийн хооронд /гадаад хэргийн сайд нарын түвшинд/ харилцан ойлголцлын форум болгон ашиглаж, дараачийн шатанд түүний гишүүнчлэлийг өргөжүүлэх замаар дээрхи зорилгод хүрч болно. Үүнд, АНУ Ази Номхон далайн бүсэд тогтворжуулах, тэнцвэржүүлэх үүрэг гүйцэтгэнэ. Хятад улс эдийн засгийн хувьд, ялангуяа хэрэв АНУ, Япон зэрэг гол хүчигнүүдийн эдийн засаг буурах нөхцөлд улам илүү үүрэг гүйцэтгэх болно. Бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагааны энэ үе шатанд Японы "хөдөлгөгч хүч" болох санаачлага, хариуцлага чухал ач холбогдолтой. БНАСАУ, Хятадын улс төрийн ирээдүй нь бүс нутгийн энх тайван, тогтвортой байдалд шийдвэрлэх нөлөө үзүүлнэ. Зүүн хойд Ази дахь аюулгүй байдал, эдийн засгийн хамтын ажиллагаа нь орнуудаас идэвхтэй тэргүүлэх үүрэг ролийг шаардах бөгөөд ялангуяа Япон, Хойд Солонгосын энэ үүрэг "дундаж хүч"-ний хувьд "их хүч"-нээс илүү чухал.<sup>11</sup> Орос улс ирээдүйд эрчим хүчний салбарын олон талын хамтын ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд өөрийн идэвхтэй дипломат үйл ажиллагаагаар Солонгосын хойгийн аюулгүй байдалд нааштай нөлөө үзүүлж болох талтай. Дээр дурьдсан улс төр, аюулгүй байдал, эдийн засгийн хүрээнд одоогийн байгаа механизмуудыг тогтвортой хөгжил, байгаль орчны хамтын ажиллагаанд чиглүүлэн улам идэвхжүүлэх, шинэ механизмуудын бий болгох, ялангуяа ЗХА-ийн бүс нутгийн түвшиний бүх үйл ажиллагааг зохицуулах явдал чухал.

## Ашигласан материал:

- <sup>1</sup> – S. Shishido, S. Itoh, M.Hamada, K.Kawamura, T.Nakajima. "A Multiregional Economic Model for Northeast Asia". Estimation and Policy Analysis. The Journal of Economic Study of Northeast Asia (JESNA) Vol.1 No.1 March 1999.
- <sup>2</sup> - J.Bor. "Mongolian Diplomatic History" UB, 1997, P.36-37
- <sup>3</sup> - Hans Binnendijk\*, Workshop Summary "U.S. Strategic Objectives in East Asia"
- <sup>4</sup> - Wu Xiubo, US Security Policy in Asia: "Implications for China-US Relations". Center for Northeast Asia Policy Studies, September-2000.
- <sup>5</sup> - Press Statement by Prime Minister Yoshiro Mori, Singapore, 25 November 2000
- <sup>6</sup> - Sustainable Development in NEA: Assessment and Challenges of Agenda 21, Final Draft Report prepared by Institute for Global Environmental Strategies (IGES), Japan
- <sup>7</sup> - <http://www.eures.de/insured/summary.htm>.
- <sup>8</sup> - The Earth Charter, March 2000, The Earth Charter Initiative
- <sup>9</sup> - Report of the Mission for the Revitalization of the Asian Economy:
- <sup>10</sup> - Takahido Kondo, "Toward a Common Currency for the Asia-Pacific Region", JETRO-Japan External Trade Organization.
- <sup>11</sup> - <http://asahi.com/english/asianet/010130-2.html> Japan's Self-Portrait-New Role as a "middle power"
- <sup>12</sup> - Prof..S.Lusianin, "President Putin's new policy to integrate Russian Far East and Siberia with the NEA".

## **10. МОНГОЛ УЛСЫН ХХІ ЗУУНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮНДЭСНИЙ СТРАТЕГИЙН ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ, БОДЛОГЫН ЧИГЛЭЛҮҮД**

/2002 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо болсон «Байгаль орчин-Тогтвортой хөгжил» онол практикийн бага хуралд тавьсан илтгэл/

Хамтран зохиогч Док. Л.Нямцэрэн

### **Critical Issues and Policy Directions of the National Strategy for Sustainable Development of Mongolia in XXI Century**

Mongolia adopted its National strategy for sustainable development in the 21<sup>st</sup> century with its implementation programme by the government resolution on 27 May 1998. There are some new guidelines for national strategies for sustainable development at the international level. For example, the key principles for sustainable development, which included the experiences of the development and implementation of national strategies for sustainable development in various countries in the world and adopted at the International Forum in Accra, Ghana, 7-9



December 2002 on national strategies for sustainable development. There is also New Strategy for the Environment for the First Decade of the 21<sup>st</sup> Century agreed by OECD Environment Ministers when they met in Paris on 16 May 2001 in framework for preparation of World Summit for Sustainable Development in Johannesburg 2002. On the basis of these key principles and critical national issues of Mongolia, author concluded some policy directions for consolidation and further implementation of national strategy for sustainable development in Mongolia.

1992 онд болсон Даян дэлхийн дээд хэмжээний уулзалтаар засгийн газрууд тогтвортой хөгжлийн үндэсний стратегиа боловсруулж хэрэгжүүлэхийг анх санал болгосон юм. Түүний дараа 1997 онд НҮБ-ийн Ерөнхий ассемблейн тусгай чуулганаар 2002 он гэхэд орон бүр үндэсний стратегигай болсон байх зорилт дэвшүүлсний дагуу ихэнх орнууд тогтвортой хөгжлийн үндэсний стратегиа боловсруулан хэрэгжүүлж байна. Түүнээс хойш бараг арваад жил өнгөрсөн боловч саяхан болтол стратегиа боловсруулан хэрэгжүүлж байгаа орнуудын туршлагыг дүгнэж гаргасан нэгдсэн удирдамж, зөвлөмж тэр бүр гараагүй байлаа.

Харин 2002 онд Өмнөд Африкийн Иоханнесбург хотноо болох тогтвортой хөгжлийн Дэлхийн дээд хэмжээний уулзалтын бэлтгэл ажлын хүрээнд 2001 оны 11 дүгээр сарын 7-9-нд Гана улсын Аккра хотноо болсон тогтвортой хөгжлийн үндэсний стратегийн талаархи олон улсын форумгаар тогтвортой хөгжлийн стратегийг улс орнуудын хэмжээнд хэрэгжүүлж байгаа туршлагыг хэлэлцэж, түүний үндсэн зарчмуудын талаар нэгдсэн удирдамж гаргасан байна.

Тогтвортой хөгжлийн үндэсний стратегиа боловсруулан хэрэгжүүлж байгаа орнуудын туршлагыг нэгтгэн дүгнэж үзэхэд олон талын оролцоотойгоор, урт хугацааны үзэл баримтлал боловсруулан, байгаа хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг хооронд нь нэгтгэн уялдуулж, тэргүүлэх дараалалаа зөв тогтоох байдлаар боловсруулсан стратеги ихэвчлэн амжилтад хүрсэн байна. Харин тодорхой бүтээгдэхүүн, нэг төрлийн зүйлд хэт ач холбогдол өгсөн, санаачлагууд нь хоорондоо уялдаагүй, дээрээс захиргаадаж боловсруулсан стратегийн хэрэгжилт тааруу байдалтай байна. Олон стратегиуд тогтвортой хөгжилд шаардагдах эдийн засаг, нийгэм, бүтцийн гүн өөрчлөлт гаргаж чадаагүй байна. Ихэнх орнууд стратеги төлөвлөлтийн олон арга хэрэгсэлтэй боловч, зарим нь тэдгээрийг зохицуулах үр нөлөө бүхий тогтолцоо байхгүй байна. Зохицуулалтын ийм тогтолцоог бий болгох явдал нь тогтвортой хөгжлийн бүрдэл хэсгүүдийг төлөвлөлтийн үйл явцтай интеграцлахад чухал ач холбогдолтой. Зохицуулалтыг сайжруулах, төлөвлөлтийн төрөл бүрийн арга хэрэгслийг ижилсгэх нь чадавхи, нөөцийг үр ашигтай зарцуулахад чухал.

Тогтвортой хөгжлийн стратеги гэдэг нь эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны зорилтуудыг хооронд нь зохистой интеграцчилж, боломжгүй зүйлүүдийг тэнцвэржүүлэх

шинжилгээ, хэлэлцүүлэг, чадавхи бүдүүлэлт, төлөвлөлт, хөрөнгө оруулалтад олон талыг оролцуулсан, үргэлжлэн сайжрах үйл явцын зохицуулагдсан багц юм.

Стратеги гэдгийг нөгөө талаар тодорхой зорилтууд дэвшүүлэн түүнд хүрэх арга хэрэгсэлийг тодорхойлох үйл ажиллагаа гэж ойлгож болно. Тогтвортой хөгжлийн стратеги арга нь сэтгэн бодох, ажиллах дараах шинэ хэлбэрүүдийг агуулна. Үүнд:

Хөдөлшгүй төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх явдлаас төрөл бүрийн асуудлуудыг хооронд нь уялдуулах явдлыг дэмжих замаар засаглалыг байнга сайжруулах, дасах, системт үйл ажиллагаанд шилжих

Асуудлыг зөвхөн хөгжлийн талаас нь авч үзэхээс нийт нийгмийн өмнө хүлээх хариуцлагыг авч үзэх явдалд шилжих

Төвлөрсөн, хяналттай шийдвэр гаргах үйл явцаас үр дүн, боломжийг хуваалцах, ил тод хэлэлцэн тохиролцох, хамтран ажиллах, нэгдсэн үйл ажиллагаа явуулахад шилжих

Үр дүнг /төсөл, хууль г.м./ анхаарахаас үр дагавар/нөлөө г.м./-ыг голлон анхаарахад шилжих

Салбарын төлөвлөлтөөс интеграцчилсан төлөвлөлтөд шилжих

Гадаад тусламжаас хамааралтай байдлаас дотоод санхүүжилтдээ түшиглэсэн хөгжилд шилжих

Хяналт шинжилгээ, суралцалт, сайжруулалтад түшиглэсэн үйл явцад шилжих

Эдгээр арга зам нь тухайн орон олон улсын хамтын ажиллагаанд үр нөлөөтэй оролцож, даяаршлаас нийгэм, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг үр дагаварыг харгалзан үзэх боломж олгоно. Мөн засгийн газар, хувийн хэвшил, төрийн бус байгууллагууд хамтран ажиллах, тогтвортой хөгжлийг дэмжих шинэ арга замаа тохиролцох боломж олгоно.

Стратеги боловсруулах явцын үндсэн зарчмын гол амин сүнс нь орон нутгийн эзэмшил, бүх түвшингийн үр нөлөө бүхий оролцоо, дээд түвшиний амлалт болно. Тогтвортой хөгжлийн үр нөлөө бүхий стратеги нь ирээдүйн үзэл баримтлалын талаар засгийн газар, иргэний нийгэм, хувийн хэвшлийнхний хүсэл эрмэлзэл, чадавхийг нэгтгэж өгдгөөрөө онцлог юм. Стратеги нь зөвхөн цөөн тэргүүлэх зорилтуудад анхаарлаа хандуулах ёстой.

Байгаа нөхцөл байдлаас хамааран тогтвортой хөгжлийн стратегийг дараахи бүрдэл хэсгүүдээс бүтэх систем гэж үзэж болно. Үүнд:

- Олон талын оролцогчдын бүлэг, үндэсний болон төвлөрсөн бус түвшинд хэлэлцэн тохиролцох арга хэрэгсэл, тэдгээрийн уялдаа холбоо
- Харилцан хуваалцах үзэл баримтлал, стратегийн өргөн зорилтууд
- Эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэх механизмуудын багц /мэдээллийн систем, харилцан холбогдох чадавхи, шинжилгээний үйл явц, олон улсын оролцоо, бодлогуудыг

хооронд нь уялдуулан зохицуулах, санхүүжүүлэх, хяналт шинжилгээ хийх, хариуцлага тооцох арга хэрэгсэл/

- Хууль эрх зүй, сайн дурын үйл ажиллагаа, зах зээлд үндэслэгдсэн хэрэгсэл зэргийг салбарын хүрээнд болон олон талын оролцогчид хэрэглэх зарчим, стандартууд
- Суралцаж, эзэмших туршилтын үйл ажиллагаа
- Эдгээр механизмуудыг зохицуулах эзэн
- Ерөнхий сайдын алба мэт төвийн дээд түвшнээс эхлэн иргэд, бизнесийн байгууллагууд хүртлэх зорилтуудыг хэрэгжүүлэх бүрэн эрх

### **Тогтвортой хөгжлийн шинэ стратегийн үндсэн зарчмууд**

Үндэстнүүдийн төрөл бүрийн нөхцөл байдал, тэргүүлэх дарааллуудаас шалтгаалан улс орнуудын стратеги төлөвлөлтийн арга хэлбэл янз бүр байна. Гэвч тогтвортой хөгжлийн талаар хөгжиж буй орнуудтай хийсэн зөвлөлгөөн, энэ талаархи олон улсын болон бүс нутгийн уулзалт, семинарын үр дүнгээс үзэхэд бодит туршлагын нийтлэг шинж чанарууд байгааг харуулж байна. Энэхүү нийтлэг шинж чанаруудад үндэслэн тогтвортой хөгжлийн үндсэн зарчмуудыг тодорхойлж болох юм. Энэхүү үндсэн зарчмуудыг хөгжилтэй болон хөгжиж буй орнуудад нэгдмэл байдлаар хэрэглэж болно. Эдгээрийн зарим нь тогтвортой хөгжилд хүрэх урьдчилсан нөхцөл болно. Ардчилсан системтэй, хуулиа хүндэлдэг, үг хэлэх эрх чөлөө бүхий тайван орнууд эдгээр зарчмуудыг ажил хэрэг болгох боломж илүү байх нь мэдээж.

Тогтвортой хөгжлийн стратеги нь системийн аргад үндэслэгдсэн, дахин давтагдах үйл явц бөгөөд дараахи зарчмуудыг мөрдлөг болгоно. Эдгээр зарчмууд нь бүгд чухал бөгөөд тэдгээрт ямарт нэгэн тэргүүлэх дараалал байхгүй. Стратеги төлөвлөлтийн бүх үйл явцад эдгээр зарчмуудыг байнга анхааран үзэж байх шаардлагатай.

**Хүн-төвтэй байх.** Стратегийг боловсруулан хэрэгжүүлэхэд хүний хөгжилд гол анхаарлаа хандуулан тэр нь ялангуяа, ядуучууд, нийгмийн эмзэг бүлгүүдэд урт хугацаанд үр өгөөжөө өгөх талаар анхаарах .

**Урт хугацааны үзэл баримтлалын талаар нэгдсэн тохиролцоонд хүрэх.** Олон талын оролцогчид хүлээн зөвшөөрөх, тодорхой урт хугацаа бүхий үзэл баримтлалын зэрэгцээ ойрын болон дунд хугацаанд өөрчлөлт гаргах зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замын талаар нэгсэн тохиролцоонд хүрсэн, улс төрийн бүх намууд тэрхүү үзэл баримтлалыг зөвшөөрсөн байх.

**Иж бүрэн, интеграцлагдсан байх.** Эдийн засаг, нийгэм, хүрээлэн буй орчны зорилтуудыг хооронд нь аль болохоор интеграцлахыг чармайх, харин интеграцчилж болохгүй бол тэнцвэржүүлэх. Энэ үйл явцад хойч үеийн хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэх.

**Төсвийн тэргүүлэх дараалалыг тодорхойлсон байх.** Төлөвлөгөө нь зорилтуудыг хэрэгжүүлэх санхүүгийн нөөцтэй байх явдлыг хангах үүднээс стратегийн зорилтуудын тэргүүлэх дарааллуудыг тодорхойлж, тэдгээрийг төсвийн үйл явцтай бүрэн интеграцлах, эс тэвээс стратеги нь мөрөөдлийн жагсаалт болно.

**Иж бүрэн, үнэн зөв шинжилгээнд үндэслэгдсэн байх.** Тэргүүлэх дараалал нь одоогийн нөхцөл байдал, цаашдын хандлага, эрсдэл, орон нутгийн, үндэсний болон дэлхийн хэмжээнд тавигдаж буй шаардлагуудын уялдаа холбооны иж бүрэн шинжилгээнд үндэслэгдсэн байх шаардлагатай. Шинжилгээнд, байгаа мэдээллийг бүрэн ашиглахын зэрэгцээ даяаршлын болон цаг уурын өөрчлөлтийн нөлөө зэрэг гадны нөлөөлөл, орон нутгийн болон олон талын оролцогчдын саналыг харгалзан үзэх хэрэгтэй. Энэхүү шинжилгээ нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлтийн найдвартай, үнэн зөв мэдээлэл болон тэдгээр мэдээлэл нь стратеги зорилт, үзүүлэлтүүдтэй хэрхэн уялдсан байдлаас хамаарна.

**Мониторинг, суралцалт, сайжруулалтыг нэгтгэх.** Мониторинг, үнэлгээ нь тодорхой үзүүлэлтүүдэд үндэслэгдсэн байхын зэрэгцээ үйл явцыг урагшлуулан жолоодох, алдаа дутагдлыг илрүүлэх, зайлшгүй хийх өөрчлөлтийн дохио болох учиртай.

**Тухайн орон өөрөө санаачлан үндэснийхээ эзэмшил болгох.** Өнгөрсөн хугацаанд олон орнууд стратегиа ихэвчлэн гадны буюу хөгжлийн байгууллагын шаардлага, шахалтаар боловсруулж байв. Тухайн орон стратегиа өөрөө санаачлан боловсруулж, өөрийн нөөц бололцоондоо түшиглэн хэрэгжүүлэх нь чухал.

**Засгийн газрын өндөр түвшиний амлалт, нөлөө бүхий байгууллагын жолоодлого байх.** Ялангуяа бодлого, бүтцийн өөрчлөлт, санхүүгийн нөөц, хариуцлага тооцохтой холбоогдуулан засгийн газрын өндөр түвшиний амлалт гарч, стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нөлөө бүхий байгууллага хариуцах шаардлагатай.

**Байгаа үйл явц, стратегиудад үндэслэгдэх.** Тогтвортой хөгжлийн стратегийг төлөвлөлтийн шинэ үйл явц гэж үзэж болохгүй. Тэр нь тухайн оронд хэрэгжиж буй төрөл бүрийн хөтөлбөр, төлөвлөлтийн үйл явцуудад үндэслэгдэх бөгөөд тэгснээр тэдгээр бодлого, төлөвлөлтийн бүтцүүдийг хооронд нь нэгтгэж, уялдуулах, нөхөн бүрдүүлэх боломж олгоно. Үүнд төлөвлөлтийн механизм, үйл явцуудыг зохицуулах, хоорондын зөрчлүүдийг илрүүлэн арилгах зөв удирдлага шаардлагатай. Зөрчлүүдийг илрүүлэн арилгахад бие даасан

хөндлөнгийн тал оролцвол зохино. Стратегийн үйл явцад оролцогчдын үүрэг, хариуцлага, уялдаа холбоог тодорхой тогтоож өгөх шаардлагатай.

**Үр нөлөө бүхий оролцоог хангах.** Өргөн оролцоо бүхий хэлэлцүүлэг нь шинэ санаа, мэдээллийн эх үүсвэрийг олох, асуудал, зорилтуудыг зөв тодорхойлох, нэгдсэн тохиролцоонд хүрэх боломж олгоно. Үүнд төв засгийн газраас гадна эрдэмтэд, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгэм, эмзэг бүлгийнхний төлөөлөлүүд оролцуулах шаардлагатай.

**Үндэсний болон орон нутгийн түвшний уялдаа холбоог хангах.** Стратеги нь үндэсний болон төвлөрсөн бус түвшний доторхи болон тэдгээрийн хоорондын дахин давтагдах хоёр-замт үйл явц байх учиртай. Стратегийн гол зарчмууд, чиглэл /эдийн засаг, санхүү, худалдааны бодлого, хууль эрх зүйн орчны өөрчлөлт, олон улсын болон гадаад харилцаа г.м./-ийг төв түвшинд тогтооно. Харин нарийвчилсан төлөвлөгөө, түүний хэрэгжилт, хяналт, холбогдох нөөц, эрх мэдлийг орон нутагт нь шилжүүлэх замаар төвлөрсөн бус түвшинд гүйцэтгэнэ.

**Хүмүүсийн чадавхийг хөгжүүлэх.** Стратегийг боловсруулан үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүний нөөц, чадавхийг хөгжүүлэх явдал онцгой ач холбогдолтой. Юуны өмнө төр болон иргэний нийгмээс оролцогчдын улс төр, зохион байгуулалт, шинжлэх ухаан, санхүүгийн чадавхыг үнэлэн үзэж, шаардлагатай бол чадавхийг нь сайжруулах арга хэмжээ авах хэрэгтэй.

**Эко тогтолцооны бүтэн байдлыг хангах.** Байгалийн нөөцийн үр нөлөө бүхий менежементийн үндсэнд эко тогтолцооны бүтэн байдлыг хадгалах явдлыг гол зорилт болгоно. Эко тогтолцоо бол хязгаарлагдмал, эмзэг, аливаа бохирдол, хог хаягдлыг шингээх чадавхи нь мөн хязгаарлагдмал учраас байгалийн нөөцийг үр ашигтай ашиглах замаар түүнийг хадгалах учиртай. Үйлдвэрлэл, хэрэглээний зохисгүй хэв маяг нь дэлхийн эко тогтолцоо, биологийн олон төрөл зүйл, цаг уурын байдал, дэлхийн хүрээлэн буй орчны эрүүл байдалд занал учруулж байна. Эко тогтолцоог хамгаалан, түүнээс үзүүлж буй чухал үйлчилгээг хадгалах талаар бодлогын үр нөлөө бүхий арга хэмжээ авахгүй бол хүрээлэн буй орчинд үзүүлж буй хүний үйл ажиллагааны дарамтыг багасгах боломжгүй нь тодорхой болж байна. Улс орнууд байгалийн нөөцийн зохисгүй ашиглалтад дэм үзүүлэх татаасыг арилгах, байгалийн нөөцийн ашиглалтын бүх зардлыг зах зээл, бодлогын бусад хэрэгслийн тусламжтайгаар «Ашигласны төлбөрийн зарчим», «Бохирдуулсны төлбөрийн зарчим»-д нийцүүлэн тооцож байх явдлыг хангах бодлогын арга хэмжээ авах шаардлагатай байна. Бодлогын ийм арга хэмжээг бизнесийнхэн, төрийн бус байгууллагууд, нутгийн уугуул иргэд, орон нутгийн нийгмийн бүлгүүдтэй нягт хамтран ажиллах замаар боловсруулах шаардлагатай.

Улс орнууд татаасыг арилгах, «ногоон» татварын шинэчлэл хийх, арилжаалагдах хийн зөвшөөрөл олгох зэрэг зах зээлд үндэслэгдсэн хэрэгсэлд тэргүүлэх ач холбогдол өгч, технологи, нийгмийн шинэчлэл хийх замаар хийн ялгаруулалтыг багасгах сонирхол бий болгох шаардлагатай.

**Эдийн засгийн өсөлтийг хүрээлэн буй орчны дарамттай холбох.** Эдийн засгийн тогтвортой өсөлт хүрээлэн буй орчны чанарыг сайжруулахад нөлөөлж байвал зохистой хөгжил гэх боллоо. Үүний тулд тулд эдийн засгийн өсөлтийг хүрээлэн буй орчны дарамттай холбож өгөх шаардлагатай. Энэ нь хүрээлэн буй орчны тогтвортой байдлын шалгуур болохын зэрэгцээ хүрээлэн буй орчны өөрийгөө нөхөн үйлдвэрлэх, бусад зүйлсийг өөртөө шингээх чадавхийг илэрхийлж, эко тогтолцооны эргэлт буцалтгүй өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, нөхөн үл сэргээгдэх нөөцийг орлуулах боломжийг хангах болно. Жишээлбэл, газар тариалангийн хувьд гэхэд л хүрээлэн буй орчин, нийгмийн бүх зардлууд бүтээгдэхүүний үнэд тусгагдаж, фермерийн тогтвортой тогтолцоо, хүрээлэн буй орчинд хоргүй фермерийн менежементийг дэмжих шаардлагатай.

**Хүрээлэн буй орчны үзүүлэлтэд үндэслэгдсэн байх.** Тогтвортой хөгжлийн талаархи бодлого нь иргэд, шийдвэр гаргагчдын аль алиных нь ашиг сонирхлыг илэрхийлж, хүрээлэн буй орчны төлөв байдал, түүний үзүүлэлтүүдэд үндэслэгдсэн байх ёстой. Үндэсний буюу олон улсын хэмжээнд дунд болон урт хугацааны, хэмжиж болох зорилтуудыг тохиролцсон нөхцөлд үзүүлэлтүүдийг хамгийн үр ашигтай хэрэглэж болно.

**Амьдралын чанарыг сайжруулах.** Нийгэм, эдийн засгийн талаас авч үзэх юм бол хүрээлэн буй орчны доройтол нь хүний эрүүл мэндэд хамгийн их нөлөөлдөг. Эрүүл мэнд, аюулгүй байдал, хотжилт, орон зайн хөгжил, хүрээлэн буй орчны шудрага зарчим, ажил эрхлэлт, оролцоо, хүрээлэн буй орчны боловсрол зэрэг нийгэм, хүрээлэн буй орчны хүрээний харилцан давхцсан асуудлуудыг шийдвэрлэхэд онцгой анхаарах хэрэгтэй байна.

**Сайн Засаглал, хамтын ажиллагааг сайжруулах.** Даяаршлаас хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг даван туулахад үндэсний болон олон улсын хэмжээнд тогтвортой хөгжлийн засаглалыг сайжруулах хамтарсан үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатай болно.

#### **Тогтвортой хөгжлийн стратегийн дэлхийн хэмжээний тулгамдсан асуудлууд**

Өнгөрсөн гучин жилд дэлхийн хэмжээнд урьд өмнө гарч байгаагүй дэвшил гарав. Тухайлбал, хөгжиж байгаа орнуудад хүний дундаж наслалт 20 гаруй жилээр нэмэгдэж, нялхасын нас баралт 2 дахин буурч, анхан шатны сургуульд хамрагдалт 2 дахин нэмэгдсэн байна. Хүнсний бүтээгдхүүний үйлдвэрлэл, хэрэглээ хүн амын өсөлтөөс даруй 20 хувиар түрүүлж байна. Хэдийгээр ийнхүү дэвшил гарсан боловч дэлхийн хөгжлийн шинэ хандлагууд тогтвортой хөгжилд тулгамдсан асуудлуудыг шинээр гарган ирж байна. Тухайлбал, харилцан нөхцөлдөх буюу зөрчилдөх төвлөрөлийн сааралт, даяаршил гэсэн хоёр гол хандлагыг тулхтай хөгжлийн хүрээнд авч үзэх шаардлагатай болж байна. Төвлөрөлийг багасгасан нөхцөлд нийгэм, хүрээлэн буй орчны олон асуудлуудыг үр дүнтэй шийдвэрлэж болохыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ даяаршлын асуудлыг шийдвэрлэхэд дэлхийн хэмжээний журам, засаглалын тогтолцоо шаардлагатай болж байна. Ялангуяа ямар асуудлуудыг ямар түвшинд шийдвэрлэхийг тогтоох, төрөл бүрийн түвшин дахь бодлогуудын хоорондын уялдаа холбоог хангах, үндэсний болон олон улсын түвшинд асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн хүмүүсийг оролцуулах зөв арга замыг олох явдал тогтвортой хөгжлийн стратегийн асуудал болж байна.

Худалдааны чөлөөлөлт, өсөн нэмэгдэж буй гадаадын хөрөнгө оруулалт, хямд холбоо, мэдээллийн хэрэгслийн өсөлт, технологийн шинэчлэл, эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрүүд болон олон талын байгууллага, гэрээ хэлэлцээрийн тархалт зэрэг хүчин зүйлүүдийн нөлөөн дор даяаршил эрчимтэй явагдаж байна. Тэгснээр эдийн засгийн өсөлт,

орлогын шинэ боломжийг бий болгон мэдлэг, технологийн тархалтыг хурдасгаж, олон улсын шинэ түншлэлүүд бий болох боломж бүрдүүлж байна. Гэвч даяаршил нь зарим орнуудад гаднаас үзүүлэх хүнд цохилт болж, амьдралын доройтол, эмзэг байдлын шалтгаан болж байнга. Энэ байдлыг тогтвортой хөгжлийн стратегид харгалзан үзэх шаардлагатай.

Өнгөрсөн хугацаанд дэлхийн хүрээлэн буй орчны дарамт хэт ихэссээр байна. Эдийн засаг, нийгэм, технологийн хөгжлийн үр дүнд ирэх хэдэн арван жилд эдгээр дарамтуудын заримыг нь багасгаж болно гэж найдаж байгаа боловч зарим нь улам их хэмжээгээр ихсэхээр байна. Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор дэлхийн хөгжингүй орнуудын нэгдэл болох Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага /ЭЗХАХБ/-ын орнууд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийсний үндсэнд ойрын арван жилд зайлшгүй шийдвэрлэвэл зохих олон асуудлуудыг тодорхойлсон байна. Энэ мэдээллийн үндсэнд ЭЗХАХБ-ын байгаль орчны сайд нар 2001 оны 5 дугаар сарын 16-нд Парис хотноо уулзаж, «21 дүгээр зууны эхний арван жилийн хүрээлэн буй орчны стратеги»-ийг тохиролцжээ. Энэхүү стратегийн гол агуулга нь эдийн засгийн өсөлт хүрээлэн буй орчныг доройтуулж болохгүй гэсэн зарчимд үндэслэн байгаль орчны цаашдын бодлогыг тодорхойлсонд оршино.

ЭЗХАХБ-ын орнууд хүрээлэн буй орчны асуудлуудыг шийдвэрлэх тухайлбал, дэлхийн амьд бодьгалийг хэт ягаан туяанаас хамгаалах үүрэг бүхий озоны давхрагын цооролтод нөлөөлөх хлорфлоркарбон /ХФК/-ы хийн гаргалт, гол мөрөн, нуурын усны бохирдлыг бууруулах талаар багагүй туршлага хуримтлуулсан байна. Гэвч энэ бол хангалтгүй, хүний үйл ажиллагаа, үйлдвэрлэл, хэрэглээний зохисгүй зуршлын үр дагавар болох амьд бодьгалийн олон төрөл зүйлийн мөхөл, хүлэмжийн хийн илүү ялгаруулалт, дэлхийн цаг уурын дулаарал зэрэг асуудлууд хүн төрөлхтний амьдрал орших, эс оршихыг шийдвэрлэх эгзэгтэй мөчид хүргээд байна.

Хүрээлэн буй орчны нөөцийн хомсдол, хэт бохирдол /бохирдлыг хүрээлэн буй орчин шингээж, тэнцвэржүүлэх чадавхи г.м./ зэрэг дэлхий нийтийн нийтлэг шинж чанартай тулгамдсан олон асуудлууд байна. Жишээлбэл, дэлхийн далай тэнгисийн загасны нөөцийн дөрөвний нэгийг аль хэдийнээ цөлөмчихсөн, үлдсэн хагасыг нь хязгаарынх нь хэмжээнд барьж байх зорилт тавьж байна. Дэлхийн хэмжээний ойн сүйтгэл нь биологийн төрөл зүйлүүдийг хорогдуулж байгаагийн хувьд ноцтой асуудлын нэг болж байна. Дэлхийн ойн сан 2020 оны үед цаашид 10 хувиар хорогдохоор байна. Агаарт гаргаж буй хорт хийн хэмжээг багасгах талаар зарим санаачлагууд гарч байгаа боловч хүлэмжийн хийн нийт ялгаруулалтын хэмжээ цаашид нэмэгдэхээр байгаа учраас цаг уурын өөрчлөлтийн ноцтой нөлөөллөөс сэргийлэх үр нөлөө бүхий арга хэмжээг яаралтай авах шаардлагатай болжээ.



ЭЗХАХБ-ийн орнуудын хүрээнд дээрхи асуудлуудыг шийдвэрлэхэд үнийн урамшуулал, засгийн газрын зохицуулалтын чиглэлээр зарим ахиц гаргасан байна. Тухайлбал, усны хэрэглээг багасгах зорилгоор усны хэрэглээний татаасыг арилгаж, ус нийлүүлэлтийн нэмэгдэл зардлыг усны үнэд нь тусгасан, үйлдвэрлэлээс гарах бохирдлыг багасгах, бохирдуулсан усыг нь цэвэрлүүлэх, Хлорфторкарбоны хэрэглээг хязгаарлах, эко систем, биологийн төрөл зүйлийг хамгаалах зэрэгт засгийн газрын зохицуулалт, хязгаарлалтын арга хэмжээг хэрэглэж байгаа нь амжилттай болж байна. Ялангуяа хүрээлэн буй орчны мэдээллийг олон нийтэд чөлөөтэй болгож, бодлогын шийдвэр гаргахад тэднийг оролцуулах явдал хувь хүмүүсээс хэрэглээний зөв сонголт хийх, хүрээлэн буй орчны бодлогыг хэрэгжүүлэхэд тэднээс дэмжлэг авахад чухал үүрэг гүйцэтгэж байна.

Хүрээлэн буй орчны талаархи ирээдүйн асуудлууд улам иж бүрэн шинж чанартай болж байгаа учраас тэдгээрийг шийдвэрлэхэд улам ярвигтай харилцан тохиролцоо, олон улсын илүү өргөн хамтын ажиллагаа шаардлагатай болохоос гадна нөөцийн нийт ашиглалт, бохирдуулалт, хог хаягдлыг багасгах зөв урамшуулал үзүүлэхэд бодлогын зөвхөн нэг хэрэгсэл хэрэглэх нь тохиромжгүй болно. Өөрөөр хэлбэл, бодлогын хэд хэдэн хэрэгслүүдийг өөр арга хэрэгслийн хувилбар бүхий зохицуулалтын хүчтэй тогтолцоотой хослуулан хэрэглэх шаардлагатай. Үүнд үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн ариншин хандлага, сайн дурын хэлэлцээр, худалдааны зөвшөөрөл, эко-шошго баталгаажуулалт болон мэдээлэлд үндэслэгдсэн бусад урамшуулал, газар ашиглах зохицуулалт, дэд бүтцийн байгуулалт зэрэгт нөлөөлөх үнийн механизмууд хамаарна. Ялангуяа, хүрээлэн буй орчинд муу нөлөө үзүүлж буй татаасыг арилгах, хүрээлэн буй орчны татвар, хураамж /түлшний кробон агууламжид шилжүүлсэн эрчим хүч ашиглалтын татвар, химийн бодис ашиглалтын татвар г.м./, «үнийг зөв тогтоох» эдийн засгийн бусад хэрэгслүүдийг улам илүү системтэй ашиглах явдал чухал.

Тогтвортой хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлж байгаа улс орнуудын туршлагыг нэгтгэн дүгнэж үзэхэд хөгжиж байгаа орнуудад тогтвортой хөгжлийн дараах нийтлэг асуудлууд байна.

- Улс төрийн тогтворгүй байдал олон орон, бүс нутаг заримдаа ширүүн мөргөлдөөнийг үүсгэж, нийгэм, эдийн засгийн дэвшлийг саатуулж байна. Улс орнуудын дотор болон тэдгээрийн хооронд өсөн нэмэгдэж байгаа орлогын тэнцүү бус байдал, үндэстэн ястан, бусад цөөнхийн амьдралын доройтол нь улс төрийн тогтворгүй байдлын шалтгаан болж байна.
- Хүрээлэн буй орчны доройтол үргэлжлэн байгалийн нөөцийн хомдол /хөрсний элэгдэл, ойн болон биологийн төрөл зүйлийн хомсдол г.м./ нэмэгдэж, ихэнх орнуудад ус, газрын хөрс, агаарын бохирдол ноцтой үр дагавар үзүүлж байна. Одоогийн үйлдвэрлэл, хэрэглээний хэв маяг, хүн амын хэт өсөлт, дэлхийн цаг агаарын

өөрчлөлт, өсөн нэмэгдэж буй хотжилт зэрэг нь дэлхийн одоогийн байгаа байгалийн нөөцийн чадавхаар ирээдүйн хүн амыг тэжээж чадах эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Өнгөрсөн 30 жилд байгалийн нөхөн сэргээгдэх нөөц 33 хувиар буурсан байхад хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнууд дахь түүний хэрэгцээ 50 хувиар өссөнийг сүүлийн үеийн судалгаа гэрчилж байна. Хөгжингүй орнууд дахь усны хэрэглээ 2020 оны түвшинд нэг хүн амд ногдох байдлаар буурах боловч нийт дүнгээрээ үргэлжлэн нэмэгдэх төлөвтэй. Сүүлийн жилүүдэд озоны давхрагын цооролтод голлон нөлөөлөх ХФК-ы хийн ялгаруулалтыг бууруулсан боловч өнгөрсөн хугацаанд хүн төрлөхтний ялгаруулсан хорт хий сав шимийн давхраа мандалд аажмаар шингэх хүртэл озоны давхрага үргэлжлэн нимгэрсээр байх болно. Хүрээлэн буй орчны талаархи өнөөгийн шинжлэх ухааны ойлголт ч хангалтгүй байна. Ялангуяа, үйлдвэрлэлийн явцад ялгарч буй элдэв төрлийн хортой хий, хаягдал хүний эрүүл мэнд, экосистемд хэрхэн нөлөөлөх талаар өнөөг хүртэл тодорхой ойлголтгүй байна. Үүний нэгэн адил орчин үеийн биотехнологийн олон нээлтүүд хүний болон экологийн эрүүл мэндэд яаж нөлөөлөх талаарх ойлголт ч тун дулимагхан байна. Газар тариалан, ойжуулалт зэрэг нөхөн сэргээгдэх нөөцийн эрчимтэй үйлдвэрлэл нь өсөн нэмэгдэж буй хэрэглээний дарамтыг хөнгөвчлөхөл тус болж байгаа боловч аль аль нь орон нутгийн экосистемийн чанарт ихээхэн сөрөг үр дагавар бий болгож байна.

- Хүн амын өсөлт, дээрхи асуудлуудыг улам хүндрүүлэхээр байна. Ирэх 20 жилийн хугацаанд шинээр нэмэгдэх 2 тэрбум хүний 97 хувь нь хөгжиж байгаа орнуудад амьдрах болж байна.
- Амьдралын доройтол. Олон орнуудад эдийн засгийн сул өсөлт, гадаад өрийн дарамт, авилгал, ширүүн мөргөлдөөн, хүнсний аюултай байдал, бусад орнууд дахь худалдааны хамгаалалтын арга хэмжээ, цаг уурын дулааралт зэргээс шалтгаалан хүмүүсийн амьдрал доройтсоор байна.

## **Монгол улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн тулгамдсан асуудал, стратеги бодлогын чиглэлүүд**

Монгол улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн үндэсний стратегийг түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөрийн хамт боловсруулан 1998 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн засгийн газрын тогтоолоор сайшаасан юм. Монгол улс өөрийн орны нийгэм, эдийн засаг, байгаль орчинд тулгамдсан асуудлаар 21 дүгээр зуунд хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулснаар дэлхий нийтийн болон бүс нутгийн өмнө тулгарч байгаа хөгжлийн шийдвэрлэх асуудлуудтай уялдуулан хамтран шийдвэрлэх боломж нөхцлийг бүрдүүлсэн юм. Одоогийн байдлаар яамдын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөрт тогтвортой хөгжлийн зорилтуудын 66 хувь, аймаг хотын засаг дарга нарын мөрийн хөтөлбөрт тухайн аймаг, хотын тогтвортой хөгжлийн

хөтөлбөрийн зорилтуудын орчим 70 хувь нь тусгагдан хэрэгжиж байна. Тогтвортой хөгжлийн хөтөлбөр батлагдснаас хойшхи дөрвөн жилийн хугацаанд хөтөлбөрийн зорилтуудыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн нөхцлүүдийг бүрдүүлж, олон тооны дагалдах хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хэд хэдэн үе шаттай үнэлгээ хийсэн нь уг ажлыг эрчимжүүлэхэд ихээхэн түлхэц болов. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар гадаад хамтын ажиллагаа идэвхтэй явагдаж, НҮБ, бүс нутгийн хүрээнд зохиогдож буй арга хэмжээнүүдэд үр дүнтэй оролцож, энэ онд болох дэлхийн дээд хэмжээний уулзалтад бэлтгэх ажлын хүрээнд олон талт үйл ажиллагаа явуулж байна. Гэвч өнөөгийн байдлаар дэлхийн хэмжээнд тавигдаж буй тогтвортой хөгжлийн стратегийн шинэ агуулга, зарчмын үүднээс авч үзэхэд манай үндэсний стратеги, хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтийн байдалд дараахь дутагдал оршиж байна. Үүнд:

Манай улсын хэмжээнд төрөл бүрийн бие даасан олон хөтөлбөрүүд боловсрогдсон байгаа боловч тэдгээрийг хооронд нь уялдуулан нэгтгэж зохицуулах, түүний үндсэнд засаглалын үйл ажиллагааг байнга сайжруулж байх системт үйл ажиллагаа дутагдаж байна.

Стратеги зорилтуудыг боловсруулах, хэрэгжүүлэхэд засгийн газар, иргэний нийгэмлэг, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн оролцоо хангалтгүй, тэднээс нийгмийн өмнө хүлээх хариуцлага тодорхой бус.

Монголд, дэлхий нийтийн хөгжлийн нэг гол хандлага болох төвлөрлийг сааруулахын оронд төсөв, хөрөнгө, эрх мэдлийг төвлөрүүлэх хандлагатай байна. Иймээс орон нутагт байгаа нөөц, боломжоо ашиглах санаачлага гаргах, ил тод хэлэлцэн тохиролцох, хамтран ажиллах явдал хязгаарлагдмал байна.

Стратеги төлөвлөгөө зөвхөн салбаруудын чиглэлээр боловсрогдож, тэдгээрийг хооронд нь уялдуулан интеграцчлах асуудал үгүйлэгдэж байна.

Хөгжлийн стратеги нь өөрийн дотоод нөөц, боломжийг дайчлахын оронд ихэнхдээ гадаадын зээл, тусламжийг аль болохоор өөртөө илүү олж авах өрсөлдөөний талбар болж байна.

Бид хүн төвтэй хөгжил гэж их ярьж, Монгол улсын 21 дүгээр зууны тогтвортой хөгжлийн үндэсний стратеги, Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрүүдэд хүний чанарыг дэлхий нийтийн дэвшилтэй жишигт хүргэх зорилт дэвшүүлсэн боловч өнөөдөр өсөн нэмэгдэж буй ядуурал, эмзэг бүлгүүдийн амьдралын асуудал үндэсний хэмжээний тулгамдсан асуудал хэвээр байна.

Өнөөгийн байдлаар олон талын оролцогчид хүлээн зөвшөөрөх урт болон дунд хугацааны үзэл баримтлал, зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замын талаар нэгдсэн тохиролцоонд хүрэх нийгмийн тогтолцоо бүрэлдэж чадаагүй байна.

Тогтвортой хөгжлийн стратеги, хөтөлбөрийн зорилтууд улсын төсвийн үйл явцтай бүрэн интеграцчлагдаж чадаагүй байна.

Иймд, үндэсний стратегийг цаашид боловсронгуй болгохын тулд дараахь чиглэлд анхаарах шаардлагатай. Үүнд:

Үндэсний, салбар болон аймаг хотуудын хэмжээний олон хөтөлбөрүүдийг хооронд нь уялдуулан нэгтгэж зохицуулах, түүний үндсэнд засаглалын үйл ажиллагааг байнга сайжруулж байх системт үйл ажиллагааг бий болгох.

Аймгуудын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлагын босоо тогтолцоо, төвлөрлийг сааруулах, аймаг хотыг бүсчлэн хөгжүүлэх, сумдыг бичил бүсээр зохион байгуулах ажлыг яаралтай зохион байгуулах.

Стратеги зорилтуудыг боловсруулах, хэрэгжүүлэхэд засгийн газар, иргэний нийгэмлэг, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшлийн оролцоог хангаж, тэднээс нийгмийн өмнө хүлээх хариуцлага тодорхой болгох.

Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд салбар хоорондын уялдааг сайжруулах, ялангуяа тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцаж, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх.

Олон талын оролцогчид хүлээн зөвшөөрөх урт болон дунд хугацааны үзэл баримтлал, зорилтууд, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замын талаар нэгдсэн тохиролцоонд хүрэх нийгмийн тогтолцоог бүрэлдүүлэх.

Үнэлгээ, судалгааны үр дүнгээс үзэхэд өсөн нэмэгдэж буй ядуурал, хүрээлэн буй орчны доройтол, тогтвортой хөгжлийн талаархи хүмүүсийн мэдлэгийн дутмаг байдал үндэсний хэмжээний тулгамдсан асуудал болоод байна.

**Өсөн нэмэгдэж буй ядуурал:** Ядуурлыг бууруулах чиглэлээр олон хөтөлбөр, арга хэмжээ авч байгаа хэдий ч ядуурал үндэсний тулгамдсан саудал хэвээр байна. Үүнд, тухайлбал, эдийн засгийн өсөлт удаан, ажил эрхлэлт нэмэгдээгүй, хүмүүсийн сэтгэлгээ болон тэдний боловсролд анхаарал бага хандуулсан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна. Ядуурлыг бууруулахын тулд стратегийн дараахь чиглэлд гол анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үүнд:

Жижиг дунд үйлдвэрлэлийг урамшуулан дэмжих, эрх зүйн зохицуулалт, татварын зохистой тогтолцоог нэвтрүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх.

Иргэдийн тогтвортой хөгжлийн талаархи мэдлэг, боловсролыг нэмэгдүүлэх, хүний хүчин зүйлийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг дорвитой нэмэгдүүлэх.

Ядуучуудад боловсрол эзэмшүүлэх, газар тариалан, мал аж ахуй эрхлэхэд нь туслах зээл олгох.

Өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ийн төрөлжсөн байгууллагуудын тусламжийг чиглүүлэх.

**Хүрээлэн буй орчны доройтол:** Хүний шууд болон дам нөлөөлөл, байгалийн хүчин зүйлийн улмаас бидний хүрээлэн буй орчин улам доройтсоор байна. Тухайлбал, 2001 оны үнэлгээний дүнгээс үзэхэд бэлчээрийн 78.4 хувь нь ямар нэг хэмжээгээр талхлагдсны дээр сүүлийн 8-10 жилд доройтсон бэлчээрийн хэмжээ 8-10 хувиар нэмэгдсэн байна. Цөлжилт маш хүчтэй үргэлжилж, ойн нөөц хомсдож, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн байгалийн гамшгийн дохиолдох давтамж, түүний эрчим улам нэмэгдсээр байна. Сүүлийн жилүүдэд ойн түймэр, эмх замбараагүй мод бэлтгэл, хортон шавжийн хөнөөл зэргээс ойн нөөц хомсдон экосистемийн тэнцвэрт байдал алдагдаж, ойн экосистемийн 16 хувь нь өөр төрлийн экосистемд шилжиж, 1974-2000 онд 1.6 сая га ой устаж үгүй болсон байна. Цаг уурын дэлхийн хэмжээний дулаарлын нөлөөгөөр Монгол орны мөнх цэвдгийн бүс 2020 оны үед 24-28, 2050 оны үед 16-25 хувиар багасах тооцоо гарч байгаа бөгөөд үүнээс үүдэн гадаргын усны тэнцэл, хөрсний чийг, агаарын дулааны горим, ургамалын бүрхүүлд өөрчлөлт орж, нийгэм, эдийн засгийн ноцтой үр дагавар авчирч болзошгүй байна. Хүрээлэн буй орчны доройтлыг багасгахын тулд стратегийн дараах чиглэлд гол анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үүнд:

Цөлжилттэй тэмцэх конвенцийг хэрэгжүүлэх хүрээнд Европын холбоо болон цөлжилттэй тэмцэх асуудлыг дэмжиж буй бусад хандивлагчидтай түншлэл байгуулах.

Монгол орныг ойжуулах, говь, хээрийн бүсэд усжуулах цэг бий болгоход санхүүгийн дэмжлэг авах.

Хөрсийг нөхөн сэргээж, хамгаалах, ойжуулах, цэцэрлэгжүүлэх зэргээр газрын чанарыг дээшлүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан иргэд, аж ахуйн нэгжийг татвараас чөлөөлөх буюу санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Цэвэр технологийг дэмжих төв байгуулан үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн болон оюуны хөрөнгө оруулалт хийх.

**Тогтвортой хөгжлийн боловсрол:** Монголын боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагуудын одоогийн үүрэг, байр суурь тулхтай хөгжлийн шаардлагад нийцэхгүй байна. Энэ талаархи нийт ард иргэдийн мэдлэг, мэдээлэл хангалтгүй байгаа нь байгаль орчныг хамгаалах үйлст сөргөөр нөлөөлж байна. Иймд тогтвортой хөгжлийн боловсролыг дээшлүүлэхэд стратегийн дараах чиглэлийг анхаарах шаардлагатай. Үүнд:

Тогтвортой хөгжлийн талаар цэцэрлэг, бага, дунд, их сургуулийн түвшинд боловсрол эзэмшүүлэх, олон нийтийн мэдлэгийг дээшлээлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх

Хүрээлэн буй орчны талаархи мэдээллийг ашиглах үндэсний тогтолцоог бүрдүүлэх

Бүх нийтийн экологийн боловсролыг сайжруулах хөтөлбөрийн үйл ажиллагаанд засгийн газрын болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоог өргөжүүлэх

Хүрээлэн буй орчны бохирдлыг багасгах, бохирдсон газрыг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгууллагуудыг дэмжин, тэдгээрийн чадавхийг дээшлүүлэх, боловсон хүчин бэлтгэхэд нь төрийн зүгээс туслах

Олон нийтийн мэдээллийг сайжруулах

Тогтвортой хөгжлийн сурах бичиг, гарын авлага материалаар хангах, тогтвортой хөгжлийн боловсролын сүлжээг бий болгож, нийтийн хүртээл болгох

Байгаль орчныг хамгаалдаг уламжлалт ёс заншил, байгаль орчны хууль тогтоомжийг ухуулан сурталчлах үйл ажиллагааг идэвхжүүлэх

Тогтвортой хөгжлийн талаар гадаад орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах Монгол улсын стратеги, бодлого нь дараахи чиглэлүүдтэй байвал зохистой. Үүнд:

1. Ядуурлыг бууруулах, ажилгүйдлийг устгах талаар олон улсын туршлага, арга замыг судалж, Монголын нөхцөлд хэрэгжүүлэх арга замыг сонгох.
2. Хүний хөгжил, аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг тогтвортой хөгжлийн асуудлуудтай нягт уялдуулан холбох.
3. Бүс нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн үйл ажиллагаанд оролцож, нийгэм, эдийн засаг, байгаль орчны чиглэлээр нягт хамтран ажиллах.
4. Экологийн тэнцвэрийг хадгалах, ялангуяа цөлжилт, хуурайшилт, ган зудын аюул зэрэг гол тулгамдсан асуудлуудын чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг сайжруулж, санхүүжилт, хөрөнгө оруулалтын асуудлыг эрчимжүүлэх.
5. Хүнс, хөдөө аж ахуйн экологийн цэвэр бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, улмаар дэлхийн зах зээлд гаргах.
6. Эрчим хүчний тогтвортой хөгжлийг хангах, ялангуяа нар, салхи зэрэг сэргээгдэх эрчим хүчийг ашиглах.
7. Байгалийн нөөц баялагийг үр дүнтэй ашиглах, ялангуяа геологи, эрдэс баялагийн боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэх.
8. НҮБ-ийн, ялангуяа "Чадавхи-2015" болон бүс нутаг, олон улсын бусад байгууллагатай тулхтай хөгжлийн асуудлаар нягт хамтран ажиллах, үйл ажиллагаанд нь байнга идэвхтэй оролцож байх.
9. Дэлхийн хөгжиж буй орнуудын хөгжилд даяарчлалаас үзүүлж буй эерэг болон сөрөг үр дагаварын талаар судлаж, Монгол орны нөхцөлд даяарчлалыг үр дүнтэй хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох.

Ашигласан эх сурвалж:

1. Guidance for Strategies for Sustainable Development.  
<http://www.nssd.net/working/guide/guidefv0.htm>
2. Principles for Strategies for Sustainable development

<http://www.nssd.net/working/guide/guidefv2.htm>

3. Lessons from Applying Existing Country Strategies

<http://www.nssd.net/working/guide/guidefv4.htm>

4. "A New Strategy for the Environment" Policy Brief, OECD, Observer, July 2001.

## **11. БАРУУН БҮСИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМУУД**

*Хамтран зохиогч Л.Цэдэндамба - ШУА-ийн Үндэсний  
хөгжлийн хүрээлэнгийн эрдэмтэн  
нарийн бичгийн дарга, доктор*

### **Problems and Ways to resolve of Sustainable Development of Mongolia's Western Region**

Although the Mongolian Action Programme and Aimag Action Programmes for 21st century have practical achievements, there is a need to consolidate the programmes and to intensify their activities, in particular in a regional demension, especially in Mongolian conditions such as the most of the people are living in scarce populated large territoty . The Parliament of Mongolia approved the concept of Mongolia's regional development in 2001 in which the territory of Mongolia divided in 4 regions. The paper considers the possibilities of social, economic and environmental development of the Mongolia's Eastern region in accordance with sustainable development principles.

НҮБ-ын "Байгаль орчин, хөгжил" сэдэвт бага хурал 1992 онд Бразил улсын Рио Де Жанейро хотноо болж байгаль орчин, эдийн засаг, нийгмийн харилцан шүтэлцсэн тогтвортой хөгжлийн үзэл санаа, хөтөлбөрийг баталж даян дэлхийд тунхаглан зарласан билээ. Энэ үйл явдлыг өнгөрсөн зууны сүүлийн арван жилийн гол үйл явдлуудын нэг мөн гэж дэлхий дахинд санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн юм. Монгол улс өнөөдөр даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл санаа, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар тодорхой үр дүнд хүрч байгаа орны тоонд зүй ёсоор орж байна. Үүний тод жишээ нь 1996-1999 оны хооронд "Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр"-ийг нийслэл хот, 21 аймгийн иргэдийн шууд оролцоотойгоор боловсруулан баталж, хэрэгжүүлж эхэлсэн явдал юм. Өнгөрсөн 3 жил орчмын хугацаанд төр, засгийн газрын түвшинд ч, аймаг, орон нутгийн түвшинд ч энэхүү хөтөлбөр нь эдийн засаг, нийгмийн хөгжлийн болон байгалийн нөөцийн ашиглалт, хамгааллын талаар явуулах бодлого, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээний тулгуур үндэслэл, тодорхой

хөтөлбөр болж үр дүнгээ өгсөөр байна. Аймаг, нийслэлийн засаг дарга нарын мөрийн хөтөлбөрүүдийн 50-70 % нь Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаанаас бүрдэж байгаагаас үүнийг харж болно.

Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөр“ ингэж амьдрал практикт хэрэгжиж үр дүнгээ өгч байгаа хэдий ч бас анхаарч үзэж уул хөтөлбөрийг улам боловсронгуй болгох, улмаар энэ талын үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлага ч байна. Хөтөлбөр нь улсын болон аймаг нийслэлийн гэсэн зөвхөн 2 түвшинг л хамарч байгаа билээ. Гэтэл өргөн уудам нутагтай, хүн ам цөөнтэйн зэрэгцээ хүн амын тодорхой хэсэг бэлчээрийн мал аж ахуй эрхлэн нэлээд таруу байршин нутагладаг онцлогтой манай улсад бүс нутгуудын хэмжээнд, өөрөөр хэлбэл аймгуудын оновчтой хамтын ажиллагаанд тулгуурлан тогтвортой хөгжлийн зорилтуудыг дэвшүүлэх, хэрэгжүүлэх шаардлага улам бүр өсч байна. Ийм ч учраас Улсын Их Хурал 2001 онд Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ыг батлан гаргасан билээ. Энэхүү үзэл баримтлалд манай улсыг Баруун, Хангайн, Төвийн, Зүүн гэсэн 4 бүсээр бүсчилэн хөгжүүлэх зорилгыг дэвшүүлсэн юм. Иймд дээр дурьдсан 4 бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага их байна гэж хэлж болно.

Тогтвортой хөгжлийн албанаас эрхлэн 2001 оны хавраас эхлэн Зүүн бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж байна. Одоо хугацаа алдалгүй Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах шаардлагтай байгаа юм. Иймд энэ илтгэлд Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулахдаа анхаарч үзвэл зохих зарим асуудлуудыг хөндөн тавих нь зүйтэй гэж үзэв. Ингэхдээ тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн нийгмийн, эдийн засгийн, байгаль ашиглалт, хамгааллын гэсэн үндсэн 3 хүрээнд авч үзэв. Үүнд:

**Нийгмийн тогтвортой хөгжлийн зарим асуудал:** Баруун бүс нутагт тогтвортой хөгжлийн үзэл санаанд тулгуурлан шийдвэрлэвэл зохих хүн амын өсөлт, хүний хөгжлийн холбогдолтой олон асуудлууд байна. Юуны өмнө хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд энэ бүсэд хэт бага байгаа юм. Баруун бүсийн энэ үзүүлэлтийг улсын дундажтай харьцуулбал даруй 7 дахин бага байна. Мөн 1000 хүнд ногдох төрөлт 1989 оны энэ үзүүлэлттэй харьцуулбал 2000 онд 30 орчим хувиар, 1000 хүнд ногдох ердийн цэвэр өсөлт 1989 оны энэ үзүүлэлттэй харьцуулбал 2000 онд 30 гаруй хувиар тус тус буурчээ. Үүний зэрэгцээ шилжин явагчийн тоогоороо Баруун бүс улсын хэмжээнд тэргүүлж байгаа юм. Өнөөгийн байдлаар жилд дунджаар зөвхөн Увс аймгаас гэхэд л 1 сумын хүн амтай тэнцэх тооны хүн Улаанбаатар болон Төвийн бүс рүү шилжин суурьшиж байна. Хэрэв шилжих хөдөлгөөн энэ янзаараа үргэлжилбэл 15-20 жилийн дараа Увс аймаг эзгүйрэх болно. Төвийн бүс рүү шилжин явж байгаа хүмүүс тэдний амьдралын чухал эх сурвалж болох малаа тууж явах нь түгээмэл үзэгдэл болжээ. Үүнээс өөр арга зам олоход ч бэрх байгаа билээ. Байдал ийм байгаа нь манай улсын төв хэсэгт бэлчээрийн даац хэтэрч, экологийн тэнцвэрт байдал алдагдах,




Баруун бүс нутагт хүн ам хэт цөөрч нутаг орон эзгүйрэх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгож байгаа юм.

Хүний хөгжлийн индекс ч бусад бүсүүдтэй харьцуулбал энд буурах хандлагатай байна.

Баруун бүсэд **ажилгүйдэл, ядуурал** харьцангуй их байна. Тухайлбал, ажилгүйдлийн түвшний улсын дундаж 4,6 байхад энэ бүс нутагт 5,8 байгаа юм. Өөрөөр хэлбэл улсын дунджаас ажилгүйдлийн түвшин 26 хувиар өндөр байна гэсэн үг /Зураг 1/.

Зураг 1



Зарим аймагт, тухайлбал Говь-Алтай аймагт энэ үзүүлэлт 7,6 буюу улсын дунджаас 65%-иар өндөр, Завхан аймагт 7,0, буюу улсын дунджаас 52%-иар өндөр байна. Үүнтэй холбоотойгоор ядуурал ч бас харьцангуй их байгаа юм.

Өнөөгийн өндөр хөгжилд хүрсэн орнууд түүхэн хөгжлийн богино биш замыг туулахдаа тухайн бүс нутаг дахь ажилгүйдлийн түвшин улсынхаа дунджаас зөвхөн 10%-иар л өндөр болоход улс орны эдийн засаг, нийгмийн хөгжил, улс төрийн тогтвортой байдалд аюул занал учруулах болно гэж үзэж уул бүс нутгийг хөгжүүлэх талаар онцгойлон анхаарч тууштай бодлого хэрэгжүүлж эхэлдэг байжээ. Иймд ажилгүйдлийн түвшин дээр хэлсэнчлэн улсын дунджаас 26%-иар өндөр байгаа энэ бүс нутгийг хөгжүүлэх талаар онцгойлсон бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм.

Хүн амын **эрүүл мэндийн салбарт** тулгамдсан асуудлууд олон байна. Тус бүсийн зарим аймгийн төв, сумд дахь эрүүл мэндийн төвүүдийн эмчилгээ, оношлогооны тоног төхөөрөмж ихээхэн хуучирсан байна. Үүнээс үүдэн зарим өвчнийг оношлох, эмчлэх боломж бага байгаа юм. Цөөнгүй тохиолдолд хүнд өвчтэй хүмүүс асарч сувилах хүний хамт Улаанбаатар болон төв хэсгийн томоохон хотуудад ирж, өвчнөө оношлуулах, эмчлүүлэх зэргээр ихээхэн зардал гаргаж

байна. Хүн амын эрүүл мэндтэй шууд холбоотой өөр нэг чухал асуудал бол хүн амын хүнс тэжээлийн хангамжийг сайжруулж, хүнсний аюулгүй байдлыг хангах явдал юм.

**Ерөнхий боловсролын системийн** байдал ч хүнд байна. Олон жилийн өмнө ашиглалтанд орсон сургуулиудын хичээлийн байр олонхи тохиолдолд эвдэрч хуучирсан байна. Үүний зэрэгцээ цахилгаан, дулааны байнгын хомсдол нь урт богино хугацаагаар сурагчдын хичээл тасрах явдалд хүргэж байна. Мөн багшлах боловсон хүчний чанар, хангамж багагүй дорджээ. 10 дугаар анги дүүргэсэн хүүхэд багшлах явдал цөөнгүй байна. Багш нарын цалин хөлс ч бага байгаа юм. Тус бүс нутагт **дээд боловсрол** олгох тогтолцоог ч жинхэнэ утгаар нь бий болгох шаардлагатай байна. Харьцангуй сул хөгжсөн Баруун бүс нутагт ажиллаж амьдарч байгаа төсвийн байгууллагуудын ажилтнуудын цалин хөлс төвийн бүсийнхтэй ижил байгаа нь мэдлэг чадвартай ажилтнуудын тогтвор суурьшилд ч муугаар нөлөөлж байна. Цөөнгүй ийм чиглэлийн ажилтнууд Улаанбаатар болон бусад томоохон хотууд руу шилжих саналтай байна.

**Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зарим асуудал:** Баруун бүс нутагт эдийн засгийн хөгжлийн түвшин ихээхэн доогуур үзүүлэлттэй байгаа юм. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн /ДНБ/ улсын дунджаас ойролцоогоор 2 дахин бага байна /Зураг 2/. Түүнчлэн эдийн засгийн бүтэц ч харьцангуй ихээхэн хоцрогдсон байгаа юм. Жишээлбэл, улсын нийт боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний зөвхөн 1,8% нь энэ бүсэд ногдож байгаа бөгөөд бүсийн эдийн засагт боловсруулах үйлдвэрийн салбарын эзэлж буй хувийн жин улсын дунджаас 3 дахин бага байна.

**Зураг 2**



Орон нутгийн **төсвийн зарлагад орлогын эзлэх хувь** олонхи тохиолдолд тогтмол буурч ирсэн байна. Тухайлвал 1990 оны байдлаар энэ бүс нутгийн 5 аймаг төсвийн зарлагынхаа дундчаар 55.7 хувийг орлогоороо бүрдүүлдэг байв. Бүр зарим аймагт, жишээлвэл Баян-

Өлгий аймагт төсвийн зарлагынхаа 81.2 хувийг орлогоороо бүрдүүлдэг байжээ. Гэтэл одоо эдгээр аймгууд төсвийн зарлагынхаа дундаар дөнгөж 20-25 хувийг орлогоороо бүрдүүлж байна. Үүнээс хамаарч улсын төсвөөс тус бүс нутагт олгодог татаасын хэмжээ ч өсөх болов. Хэрэв төсвийн тодорхой хөрөнгө оруулалтыг эс тооцвол өнөөгийн байдлаар энд орон нутгийн төсвийн зарлагын 80 гаруй хувийг улсын төсвөөс олгож буй татаас эзэлж байна. Энэ бол эдийн засагт оршиж буй одооноос арилгаж эхлэх шаардлагатай ноцтой хэвийн бус үзэгдэл юм. Иймд эдийн засгийн хөгжлийн түвшинг дээшлүүлж, бүтцийг нь шинэчлэх нь Баруун бүсийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн зангилаа асуудлын нэг гэж хэлж болно.

Тус бүс нутагт **аж үйлдвэрийн салбар, түүний дотор жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ** нэн сул хөгжсөн юм. Улсын нийт боловсруулах аж үйлдвэрийн газруудын зөвхөн 12.0% энэ бүсэд байна. Гэтэл улсын хүн амын 20.0 орчим хувь тус бүсэд байгаа билээ. Үүний зэрэгцээ эдгээр таван аймагт урьд өмнө нь ажиллаж байсан үйлдвэрийн газрууд хүчин чадлынхаа дөнгөж 20-30 хувийг ашиглаж байна. Гэтэл энэ бүсэд одоогийн байдлаар улсын нийт малын 30 орчим хувь, хонины нэхий бэлтгэлийн 20 орчим хувь, ямааны арьс бэлтгэлийн 20 гаруй хувь тус тус ногдож байгаа билээ. Мөн хонины ноос бэлтгэлийн 30 орчим хувь, ямааны ноолуур бэлтгэлийн 35 хувийг энэ бүс нутагт бэлтгэж байгаа юм. Ер нь Баруун бүс нутаг улсын нийт хонины ноосны 30 гаруй хувийг, ямааны ноолуурын 40 орчим хувийг бэлтгэх чадавхитай. Мах бэлтгэх нөөц бололцоо ч бас харьцангуй их байна. Энэ нь ийм чиглэлийн жижиг, дунд үйлдвэрийн түүхий эд хангалттай байгааг харуулж байгаа юм. Ийм нөхцөлд мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах экспортын чиглэлтэй жижиг, дунд үйлдвэрлэл бий болгох, түүнчлэн өмнө ажиллаж байсан үйлдвэрүүдийн хүчин чадлыг техник технологийг нь шинэчлэх замаар бүрэн эзэмших нь тус бүс нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжлийн шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг яриангүй мөн.

**Эрдэс түүхий эдийг олборлох, боловсруулах** чиглэлийн үйлдвэрүүд тус бүс нутагт бараг байхгүй байна. Гэтэл харьцангуй сайн судлагдсан цөөн ч гэсэн орд илэрц бас байгаа юм. Тухайлвал Баян-Өлгий аймгийн Асгатын мөнгөний, Завханы фосфоритын, Говь-Алтайн хром магнетитын орд, Ховд, Увс аймаг дахь алтны орд илэрцүүдийг дурьдаж болно. Энэ чиглэлээр үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлэх нь тус бүс нутаг эдийн засгийн хувьд бие даах нөхцлийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

**Газар тариалангийн** үйлдвэрлэлд ч шийдвэрлэвэл зохих олон асуудал хуримтлагджээ. Өнөөгийн байдлаар нийт тариалсан талбай 1990 оны төвшингөөс 70 орчим хувиар буурсан байна. 1 га-гаас авах ургацын хэмжээ ч их буурчээ. Газар тариаланд ашигладаг техник хэрэгслэл ч хуучирч, бүтээмж нь эрс буурсан тал ажиглагдав. Өмнө ашиглаж байсан Говь-Алтай, Ховд аймгийн услалтын системүүдийн үйл ажиллагаа ч зогсжээ. Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгжүүд ялангуяа санхүүгийн хувьд хүнд байдалд байгаа юм.

**Мал аж ахуйн салбарт** ч шийдвэрлэвэл зохих асуудлууд цөөнгүй байна. Малын үүлдэр, удам угсааг сайжруулах, ашиг шимийг нь нэмэгдүүлэх ажил бараг зогсжээ. Фермерийн аж ахуй

эрхлэх явдал ч бусад бүстэй харьцуулбал эхлэлийн төдий байна. Мал сүргийн усан хангамж, хашаа саравчтай холбоотой олон асуудал бий болсон байна. Зах зээлийн эрэлт нийлүүлэлтээс хамаарч сүргийн бүтцэд ч зарим сөрөг өөрчлөлт гарсан байна. Энэ нь бэлчээр ашиглалтанд сөргөөр нөлөөлж эхлэв. Иймд цаашид малын тоо толгойг зохистой хэмжээнд барьж сүргийн бүтэц, чанарыг сайжруулах замаар ашиг шимийг нь нэмэгдүүлэх нь бас л тулгамдсан асуудал болжээ. Энэ үүднээс нутгийн монгол малын доторхи шилдэг омгийн мал (казахын ууцан сүүлт хонь, сартуул хонь, Говь-Алтай хонь, Говь Гурван сайхан ямаа, баяд хонь, казахын цагаан толгойт үхэр, “наран”, “саран” хайнаг г.м)-ыг малын үржил селекцийн ажилд зохистой ашиглах шаардлагатай байна. Мал эмнэлгийн үйлчилгээг сэргээж хөгжүүлэх шаардлага ч их байна.

Баруун бүсийн 5 аймаг **дэд бүтцийн хөгжлөөрөө** ихээхэн хоцорсон нь судалгаанаас харагдлаа. **Үйлдвэрлэлийн дэд бүтцийн салбаруудаас автозамын сүлжээ** үнэхээр хоцрогдож, байгалийн хөрсөн зам зонхилсон байдалтай байна. Судалгааны дүнд бид хүн амын тоо, нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ болон тээвэрлэж байгаа ачааны хэмжээ, төрөл бүрийн замын шилжүүлсэн нийлбэр урт зэрэг үзүүлэлтүүдийг тооцон Баруун бүсийн замын сүлжээний хангамжийн коэффициентийг илрүүлсэн юм. Энэ үзүүлэлтээр Баруун бүс Төвийн бүсийн Сэлэнгэ аймгаас 18.3 дахин, Төв аймгаас 11.4 дахин доогуур байна. Орчин үеийн сайн чанарын замын сүлжээ байхгүй байгаа нь аливаа бараа таваар, үйлдвэрлэл, үйлчилгээний үнэ, өртөг өндөр байх нөхцлийг бий болгож байгаа юм. Иймд Баруун бүсэд төрөл бүрийн замын сүлжээг, түүний дотор сайн чанарын авто замын сүлжээг бий болгох явдал мөн тулгамдсан асуудлын нэг болж байна. Үүнтэй уялдуулан “Мянганы зам” тавихад Баруун бүсийн аймгуудын оролцоо, хамтын ажиллагааг идэвхижүүлэх шаардлага их байна.

**Эрчим хүчний дэд бүтцийн хэмжээнд** ч тулгамдсан асуудлууд олон байна. Одоогийн байдлаар зөвхөн Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн төв болон эдгээр аймгийн цөөн тооны сумдыг ОХУ-ын Красноярскийн эрчим хүчний нэгдсэн системээс гадаад орноос хамааралтай цахилгаан эрчим хүчээр хангаж байна. Цаашид энэ бүсийг Монгол улсынхаа эрчим хүчний нэгдсэн системд холбох нь онцгой ач холбогдолтой юм. Бүсийн бусад хоёр аймаг, олон суманд дизель цахилгаан станц зонхилж байгаа юм. Түүнчлэн цөөнгүй сумдын төвд суурилуулсан дизель станц нь түлш их хэрэглэдэг, нөгөө талаар түлш худалдан авах санхүүгийн чадавхи сул байдагтай холбоотойгоор тэдгээр сумдад эрчим хүчний хомсдол тогтмол үргэлжилж байна. Ийм нөхцөлд техник, тоног төхөөрөмж ажиллуулж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх боломж нэн бага байдаг. Үүний зэрэгцээ тус бүс нутгийн нийт өрхийн дунджаар 50 гаруй хувийг нь эзэлдэг малчдыг цахилгаан эрчим хүчээр хангаж эхлэх шаардлага нэн их байна. Эдгээр нь бас Баруун бүсийн тогтвортой хөгжлийн шийдвэрлэж эхэлвэл зохих тулгамдсан томоохон асуудлын нэг юм. Энэ бүс нутгийн **цахилгаан холбооны** суурь сүлжээг ч иж бүрнээр нь тоон технологид шилжүүлж, орчин үеийн мэдээллийн сүлжээнд аймаг, сумдын төвийг бүрэн холбох шаардлага ч байна.

Баруун бүс нутагт эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх шаардлага ч их байна. Юуны өмнө зарим хилийн гарц, боомтуудыг худалдааны чөлөөт бүс болгох талаар анхаарах хэрэгтэй юм.

**Байгаль ашиглалт, хамгааллын зарим асуудал:** Баруун бүсэд Монгол улсын улаан номонд орсон 23 зүйл хөхтөн, 24 зүйл шувуу, 5 зүйл мөлхөгч, 1 зүйл хоёр нутагтан, 5 зүйл шавьж, 3 зүйл загас, олон зүйл ургамал байдаг. Сүүлийн жилүүдэд энэ бүс нутгийн байгалийн баялгийг зүй бусаар ашиглах явдал эрс ихэслээ. Дэлхийд хов ордсон ирвэс, аргаль, бөхөн, хойлог зэргийг агнаж устгах явдал мэр сэр гарсаар байна. Алтайн тарвага, буга согооны тоо цөөрч зарим газар бараг устаж алга болох аюул тулгараад байна.

Ойг зөвшөөрөлгүйгээр их хэмжээгээр огтолж ашиглах явдал ихсэж аймгийн төв, суурин газрын ойролцоох модны нөөц эрс багасжээ. Уулын сонгино, арц зэргийг маш ихээр түүж хэрэглэж байна. Байгаль хамгаалах хууль тогтоомж хяналт шалгалт амьдрал дээр бараг хэрэгжихгүй байна.

Элсний нүүдлийг зогсоох, цөлжилтөөс хамгаалах явдал мөн энэ нутгийн байгаль хамгааллын чухал асуудлын нэг болоод байна. Баруун бүсийн Их нууруудын хотгорт Монгол орны нийт элсний 50%-иас илүү нь байдаг бөгөөд хамгийн их цөлжилтэнд өртсөн газар болно. Зарим судлаачдын үзэж байгаагаар Их нууруудын хотгорын 41.2% бага зэрэг, 31.9% дунд, 16.7% хүчтэй, 10.2% маш хүчтэй цөлжилтэнд өртсөн байна. Манай орны гандуу бүс нутагт 1940 оноос хойш 3800 км<sup>2</sup> талбай шинээр элсжсэний 870 км<sup>2</sup> нь зөвхөн Монгол элсний урд зах Хүйсийн говийн дагуух нутагт байна. Говь-Алтай аймгийн Хөх морьт сумын төв элсэнд дарагдаж, Монгол элс, Бөөрөг дэл, Бор хяр зэрэг томоохон элстэй нутгийн элсний нүүдэл ихсэх үзэгдэл ажиглагдаж байна. Элсний нүүдэл ихсэх, цөлжилт ихсэх зэрэг үзэгдэл нь дэлхийн цаг уурын өөрчлөлт, дулааралтын үзэгдэлтэй тодорхой хэмжээгээр холбоотой боловч хүний үйл ажиллагааны сөрөг нөлөө их байгаа юм. Увс аймгийн Тэс, Зүүнговь, Завхан аймгийн Завханмандал, Дөрвөлжин, Говь-Алтай аймгийн Хөхморьт сумд нь шаваг, харгана, тэсгийг зүй бусаар ашиглаж, Ургамал сум төвийнхөө түлшний хэрэгцээнд жилд дунджаар 600 тн шаваг хэрэглэж байсан зэрэг нь элсний хөдөлгөөнийг мэдэгдэхүйц нэмэгдүүлж бэлчээрийн нөөцийг ихээр хорогдуулсан байна.

Монгол элсний баруун хэсэгт орших Хомын талд тариаланд ашиглах боломжгүй ихээхэн хэмжээний элсэнцэр говийн бор хөрсийг хөрөнгө хүч зарцуулж хагалаад атаршуулж орхижээ. Үүний үр дүнд хөрсний үржил шимт өнгөн хэсэг нь салхинд хийсэж, улмаар зарим хэсэгтээ хөрсний давсжилт ад өртөөд байна.

Говь-Алтай аймгийн Хөхморьт сум нь манай орны цөлжилтөд хамгийн их өртсөн нутгийн нэг болоод байна. Тус сумын нутгийн ихэнх хэсэг нь Монгол элсэнд орших бөгөөд элсний бэлчээрийг хэт талхалж, элсний шаваг харганыг замбараагүй ихээр түлшинд ашигласнаас элсний нүүдлийг идэвхжүүлж цөлжилтийг ихэсгэх шалтгаан болжээ.

Сүүлийн жилүүдэд малын тоо толгой өсөж нийт нутгийн хэмжээгээр бэлчээрийн даац хүрэлцэхгүй байдал ажиглагдаж байна. Худаг ус тойрсон бага хэмжээний газар их хэмжээний мал төвлөрч бэлчээрийн талхагдлыг ихэсгэж байна.

Баруун бүс нутагт аж үйлдвэрийн хог хаягдал бохирдол бараг байхгүй боловч Монгол орны хэмжээнд нийтлэг үзэгдэл болсон аймгийн төв, сум суурин газрууд нь ахуйн хог хаягдал ихтэй байдаг явдал мөн энэ бүс нутагт ажиглагдаж байна.

Монгол орны Баруун бүсийн байгалийн унаган төрх, шим мандлын тэнцвэрт байдлыг хадгалах, биологийн зарим төрөл зүйл болон түүх соёлын дурсгал бүхий газар нутгийг тусгай хамгаалалтад авах нь байгаль хамгааллын чухал асуудлын нэг юм.

Баруун бүсийн тогтвортой хөгжлийн асуудлуудаас товч дурьдахад ийм байна. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд дээр дурьдсанчилан энэ бүс нутгийн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хугацаа алдалгүй боловсруулан хэрэгжүүлж эхлэх нь онцгой ач холбогдолтой юм.

Илтгэлд Баруун бүсийн тогтвортой хөгжлийн хөтөлбөр боловсруулах чиглэлээр зохион байгуулалтын болон арга зүй, аргачлалын ач холбогдолтой зарим саналыг бас тусгасан болно.

**ХОЁР. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТ БОЛОН  
ТҮҮНИЙ БЭЛТГЭЛ ХОРООНЫ ЧУУЛГАНУУДАД МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧИД  
ОРОЛЦСОН НЬ**

**1. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТЫН  
БЭЛТГЭЛ ХОРООНЫ 2 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГАН**

**Participation in II meeting of Preparatory Committee for WSSD**

Mongolian representatives consisted of 3 people including J.Enkhsaikhan, permanent representative of Mongolia to United Nations, D.Dagvadorj, national coordinator of MAP-21 and D.Zorigt, secretariat of permanent representative of Mongolia in UN participated in the II meeting held between January 26 and February 8, 2002 in the United States. This meeting discussed the progress, achievements and obstacles in achieving the sustainable development for last 10 years and defined the directions of agenda for Johannesburg WSSD. Mongolia and other participants countries have agreed to have a unified positions on issues like combating desertification, afforestation and protection of clean water resources and atmosphere at the Johannesburg WSSD. Mongolian delegation highlighted the importance of international cooperation, especially addressed importance of UNDP Capacity -21 support for educational curriculum for sustainable development, regional sustainable development, ecovillage and ecolabelling of ecological clean production and restoration of energy.

**Чуулганы хуралдааны талаар:** Бэлтгэл чуулган 2002 оны 1-р сарын 26-наас 2-р сарын 08-ны өдрүүдэд Нью Йорк хотноо НҮБ-ын хурлуудын танхимд болов. Чуулганд НҮБ-ын гишүүн бүх орон болон олон улсын байгууллагууд, дэлхийн эмэгтэйчүүд, залуучууд, олон нийтийн байгууллагын эрдэмтэн судлаачдын төлөөлөгчид оролцов. Монгол улсаас НҮБ-д суугаа байнгын төлөөлөгч, элчин сайд Ж.Энхсайхан, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, «XXI зууны тогтвортой хөгжил» хөтөлбөрийн зохицуулагч Проф.Д.Дагвадорж, НҮБ-д суугаа байнгын төлөөлөгчийн газрын нарийн бичгий дарга Д.Зоригт нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцов.

Чуулганаар дэлхий дахины тогтвортой хөгжлийн хөтөлбөр (Agenda 21)- ийн хэрэгжилтийн тухай НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын илтгэлийг хэлэлцэж, энэ талаар сүүлийн 10 жилд олсон ололт, алдаа дутагдал, сургамжийг нэгтгэн дүгнэв.

Чуулганы үеэр урьд өмнө нь тив тус бүрд болсон бэлтгэл уулзалтуудын нэгдсэн дүнг гаргалаа. Чуулганаар Өмнөд Африкт энэ оны 8-р сарын сүүлчээр болох тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтаар хэлэлцэх асуудлуудын чиг хүрээг тодорхойлов. Даян дэлхийн улс орнуудын засгийн газар, олон улсын байгууллагууд, төрийн бус байгууллагын төлөөлөгчид зэрэг нийгмийн өргөн хүрээний төлөөллийн санал, дүгнэлтийг сонсож чуулганы даргын нэр дээр гарсан эцсийн баримт бичгүүдэд тусгалаа. Энэ нь "Даян дэлхийн тогтвортой хөгжлийн хэмжээний уулзалтад бэлтгэх хорооны 2 дахь чуулган", "Орчин ба хөгжлийн тухай НҮБ-ийн бага хурлын дагуу тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэх чиглэлээр олсон ололт амжилт, энэ хөтөлбөрийг ирээдүйд хэрэгжүүлэх талаархи үнэлгээ, түүнийг шүүн хэлэлцсэн тухай чуулганы даргын дүгнэлт", "XXI зуун тогтвортой хөгжил хөтөлбөрийг эрчимжүүлэх санаачлага-хамтын ажиллагааны тухай саналууд", "Олон талын оролцогчдын яриа хэлэлцээний тухай чуулганы даргын дүгнэлт" гэсэн үндсэн баримт бичгүүдээс бүрдэж байна.

Цөлжилттэй тэмцэх, ойжуулалт, цэвэр усны нөөц, агаар мандлыг хамгаалах зэрэг тогтвортой хөгжлийн олон чухал асуудлаар Монгол улс, оролцогч бусад орнууд нэгдсэн байр суурьтайгаар чуулганы даргын баримт бичигт оруулав.

Тогтвортой хөгжлийг олон улсын хэмжээнд удирдах асуудлыг улам тодорхой болгон, үндэсний хэмжээнд болон орон нутагт энэ асуудлыг удирдан зохион байгуулах талаар Монгол улсад нэгэнт бий болсон арга туршлагыг бусад орнуудад, ялангуяа бусад хөгжиж байгаа орнуудад хэрэгжүүлэх талаар НҮБ, донор бусад орнууд тусламж дэмжлэг үзүүлэх тухай саналыг Монгол улсын төлөөлөгчид гаргав. Энэ асуудлыг 3-р сарын сүүлчээр Нью-Йорк хотноо болох 3 дахь удаагийн бэлтгэл чуулганаар нарийвчлан хэлэлцэхээр боллоо.

#### **Бэлтгэл чуулганд Монгол улсын оролцох оролцооны талаар:**

а) **Байр сууриа илэрхийлсэн оролцоо:** 2002 онд Монгол улс НҮБ-ийн төлөөлөн удирдах комиссын гишүүн 34 орны нэг болсон билээ. Ийм ч учраас ТХУЗ-ийн нарийн бичгийн даргын зардлыг (унааны) НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн комисс санхүүжүүлсэн нь энэ ажлыг эх орондоо гардан хариуцаж байгаа мэргэжилтэн биеэр оролцож даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйлсийг хэрэгжүүлж байгаа байгууллага, хүмүүстэй уулзан ажил хэргээ өрнүүлэх сайхан боломж олгов. Миний бие 1-р сарын 31-нд болсон салбар хуралдаанд өөрийнхөө орны тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн ажлын зохион байгуулалт, давуу талын тухай товч үг хэлж оролцов. 2-р сарын 01-нд болсон ерөнхий хуралдаанд Өмнөд Африкийн уулзалтаас Монгол улс ямар үр дүн хүлээж байгаа болон тогтвортой хөгжлийн талаар одоо



хийж байгаа ажил, цаашид хийж хэрэгжүүлэх зүйлийнхээ талаар дэлгэрэнгүй үг хэлэв. Хэлсэн үгтэйгээ холбогдуулан, бусад орны төлөөлөгчдийн тавьсан асуултанд хариулж өөрийн орныхоо дэлхий дахины тогтвортой хөгжлийн үйлсэд оруулж буй хувь нэмрийг таниулав.

Дараагийн өдрүүдэд манай төлөөлөгчид чуулганаас гарах шийдвэрийн талаар хэлэлцсэн хуралдаануудад сууж дэлхийн улс орнуудын тогтвортой хөгжлийн үйлсэд хуримтлуулсан туршлага, сургамжийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болсоны зэрэгцээ хэлэлцэж байгаа асуудлын талаар Ази-Номхон далайн бүс нутгийн болон бусад тив орны төлөөлөгчидтэй зөвлөлдөж байр сууриа илэрхийлж байв.

**б) Арга туршлагын судалгаа:** 2 дахь удаагийн бэлтгэл чуулганы салшгүй хэсэг нь хуралдааны чөлөөт цагаар (өдөр, орой) зохион байгуулж байсан зэрэгцээ үйл ажиллагаа (side event)-нууд байлаа.

Тогтвортой хөгжлийн үндэсний стратеги боловсруулах, энэ хөгжлийн боловсролын тогтолцоог бүрдүүлэх, даян дэлхийн усны нөөц, түүний тогтвортой хөгжилд үзүүлэх нөлөөлөл, экологийн тосгон төслийн хэрэгжилт, НҮБ-ийн үйлдвэрийн хөгжлийн байгууллага (UNIDO)-оос хөгжингүй орнуудад хэрэгжүүлж буй төслийн үр дүн гэсэн зэрэгцээ арга хэмжээнүүдэд оролцож, асуулт асуун танилцаж төсөл хэрэгжүүлэгч олон улсын байгууллагуудтай хэлхээ холбоо тогтоон ажиллах боломжийг судлав.

**в) Шууд уулзалтууд, хэлхээ холбоо:** Чуулганы үйл ажиллагааны гуравдагч бүрэлдэхүүн хэсэг нь тогтвортой хөгжлийн мэргэжилтнүүдийн уулзалт яриа байлаа. ОХУ, Хятад, Азийн ба Латин Америкийн орнууд ЮНЕСКО, НҮБХХ (Чадавхи-21) зэрэг олон улсын байгууллагын 30 орчим төлөөлөгчидтэй чуулганы завсраар уулзан танилцаж, цаашид мэдээлэл солилцох, хамтран ажиллах боломжийн талаар ярилцав.

#### **Нэгдсэн дүгнэлт:**

5. Чуулган даян дэлхийн тогтвортой хөгжлийн асуудлаар өнгөрсөн 10 жилд олсон ажлын ололт, дутагдлыг нэгтгэн дүгнэж улс орнууд энэ чиглэлээр цаашид хийх үйл ажиллагааны хөтөлбөрөө тохиролцон, хамтын үйл ажиллагааныхаа механизмыг бий болгох талаар алхам хийлээ. Монгол улс Азийн орнуудаасаа хамгийн түрүүнд үндэсний илтгэлээ гаргаж хэвлүүлэн, нийтийн хүртээл болгосны зэрэгцээ 2002 оноос НҮБ-ийн тогтвортой хөгжлийн бүрэн эрхт гишүүнээр сонгогдсоны хувьд өөрийн бие даасан байр суурьтай, дуу хоолойтой энэ чуулганд оролцов.
6. XXI зуун тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг бодитой үйл явц болгох чиглэлээр Даян дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтыг угаж хийх ажлынхаа үндсийг тодорхойлсноос гадна НҮБ-ийн тогтвортой хөгжлийн гишүүн орны хувьд ирэх 3 жилд хэрэгжүүлэх, хийх ажлынхаа ерөнхий хүрээг тодорхойлов. (Үүнийг цаашид нарийвчлах юм).

## **Саналууд:**

Манай орон НҮБ-ийн тогтвортой хөгжлийн комиссын гишүүн орон болсон нь XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх гадаад таатай нөхцөл гэж үзэж цөлжилт, ойжуулалт, тогтвортой хөгжлийн үзүүлэлтүүд зэрэг асуудлуудыг НҮБ-ийн хүрээнд ажиллах гол чиглэл болгохоос гадна тогтвортой хөгжлийн боловсролын тогтолцоо, бүс нутгийн тогтвортой хөгжил, экологийн тосгон, экологийн хувьд туйлын цэвэр бүтээгдэхүүний баталгаажуулалт (ecolabelling), сэргээгдэх эрчим хүч зэрэг өргөн хүрээтэй асуудлуудаар НҮБ-ийн гишүүн орнууд, олон улсын хөгжлийн байгууллагуудтай хамтран ажиллах, эдгээр болон бусад асуудлуудыг хэрэгжүүлэх боломжийг цаашид гүнзгийрүүлэн судалж, тодорхой төсөл болгон хэрэгжүүлэх санал боловсруулан НҮБХХ (UNDP)-ийн Чадавхи-21 санд уламжлах.

Даян дэлхийн тогтвортой хөгжлийн чуулга уулзалтыг угтсан үндэсний стратеги төлөвлөгөө боловсруулан Засгийн Газар, Их Хуралд танилцуулан хэрэгжүүлэх, Байгаль Орчны Яам зэрэг уг асуудалд шууд холбогдох төрийн байгууллагууд, түүнчлэн эмэгтэйчүүд, хүүхэд, олон нийтийн бусад байгууллагууд, бизнесийн хүрээнийхнийг татан оруулах, зохион байгуулалтын зөв шийдэрийг олж хэрэгжүүлэх.

Тогтвортой хөгжлийн төслийн хүрээнд одоо хэрэгжиж байгаа ажлууд (бүсийн хөгжлийн хөтөлбөр, байгальд хоргүй технологийн санхүүжилт г.м)-аас Нью-Йоркт болсон энэ чуулга уулзалтаар хэлэлцсэн асуудлын агуулгаар баяжуулж үр дүнтэй хэрэгжүүлэх.

3 дахь удаагийн бэлтгэл чуулганд Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний ба орон нутгийн зөвлөлийн арга туршлагыг тусгасан илтгэл бэлтгэж оролцох талаар холбогдох байгууллагуудад санал тавьж тусгай арга хэмжээний хөтөлбөрт (side event) нь тусгуулан хэрэгжүүлэх.

## **2. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ ХОРООНЫ 3 ДАХЬ УДААГИЙН ЧУУЛГАНД**

### **Participation III meeting of Preparatory Committee for WSSD**

At the III preparatory meeting, held between 25th of March and 5th of April 2002 the participants were J.Enkhsaikhan, permanent representative of Mongolia to United Nations, D.Dagvadorj, national coordinator of MAP-21, Enebish, and D.Zorigt,

secretariat of permanent representative of Mongolia in UN. This time Mongolian representatives participated in the G-77 section session and the countries including in G-77 unified their positions on agenda by linking with sustainable development trends taken by developed countries. The meeting was action oriented and made time-bounded decisions for reaching partnership and type-2 outcome. Head of Mongolian representatives J.Enkhsaikhan noted that consideration is essential of the interests of landlocked countries in the final document of WSSD while Prof. D.Dagvadorj, participating in the roundtable discussion on national governance and sustainable development highlighted the importance of support of United States and other developed countries in achieving sustainable development in developing countries. The roundtable discussion gave to Mongolia a possibility to cooperate with The World Council named "Access Initiative" and The World Conservation Union.

**Чуулганы хуралдааны талаар:** Бэлтгэл чуулган 2002 оны 3-р сарын 25-наас 4-р сарын 5-ны өдрүүдэд Нью Йорк хотноо НҮБ-ын хурлуудын танхимд болов. Чуулганд НҮБ-ын гишүүн бүх орны засгийн газрыг төлөөлсөн ажилтан, тогтвортой хөгжлийн мэргэжилтнүүд оролцов. Монгол улсаас НҮБ-д суугаа байнгын төлөөлөгч, элчин сайд Ж.Энхсайхан, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, XXI зууны тогтвортой хөгжил хөтөлбөрийн үндэсний зохицуулагч док.Д.Дагвадорж, НҮБ-д суугаа байнгын төлөөлөгчийн газрын нарийн бичгийн дарга Д.Зоригт, Энэбиш нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгчид оролцов.

Энэ удаагийн чуулганаар хэлэлцсэн асуудлын чиглэл, зохион байгуулалт, арга зүй өмнө нь болсон 2 дахь удаагийн чуулганахаас өвөрмөц ялгаатай байсан юм. Өмнөд Африкт болох Дээд Хэмжээний уулзалтаар хэлэлцэн гаргах шийдвэрийн талаарх чуулганы даргын баримт бичгийг ажлын 3 бүлэг болон 2 долоо хоногийн турш хэлэлцэв.

Нэг дэх бүлгийн хуралдаанаар дээрх баримт бичгийн эхний 4 бүлэг болох ерөнхий зүйл, ядуурал, үйлдвэрлэл, хэрэглээний зохистой бүтцийг бүрдүүлэн, хөгжлийн зорилгод байгалийн нөөцийг оновчтой ашиглах асуудал, хоёр дахь бүлгийн хуралдаанаар даргын баримт бичгийн сүүлийн 4 бүлэг болох даяаршиж буй дэлхий дахины тогтвортой хөгжил, эрүүл мэнд ба тулхтай хөгжил, хөгжингүй орнуудын жижиг үндэстэн ба Африкийн орнуудын тогтвортой хөгжил, хэрэгжүүлэх арга хэрэгслийг тус тус зүйл анги бүрээр нь шүүн хэлэлцэв. 3-р бүлгийн хуралдаанаар үндэсний, бүс нутгийн, олон улсын хэмжээнд тогтвортой хөгжлийг удирдах асуудлыг бие даан хэлэлцлээ. Чуулганы төлөөлөгчид асуудал бүрд нухацтай хандаж тогтвортой хөгжлийн үйлсийг хоосон уриа лоозон болгох биш, бодит ажил хэрэг болгох талаас нь хандаж байлаа. Ажлын группуудад манай улсын төлөөлөгчид сонирхсон

чиглэлүүдээрээ оролцож ажиллав. Энэ удаагийн хуралдаанд Монгол улс бүрэлдэхүүнд нь багтдаг G-77 гэгдэх хөгжиж буй орнууд хэлэлцэж байгаа асуудлын талаар хамтын байр сууриа нэгтгэн нэгдсэн хуралдаанд оролцож АНУ, Япон, Европын холбоо зэрэг том орнуудын даян дэлхийн тогтвортой хөгжлийн асуудлаар баримталж буй чиг бодлоготой уялдуулж байв.

Чуулган ажил хэрэгч (action oriented) бөгөөд цаг хугацааг нарийн тооцсон (time-bound) шийдвэр гаргаж, улмаар бодит түншлэлд буюу гарц-2 (type-2 outcome)-т хүрэх талаар дэвшилд хүрсэнээрээ ихээхэн ач холбогдолтой боллоо.

**Бэлтгэл чуулганд Монгол улсын төлөөлөгчдийн оролцсон талаар:** Монгол улсын төлөөлөгчид ажлын группуудын хуралдаан, хуралдааны чөлөөт цагаар нэн сонирхолтой асуудлыг шүүн хэлэлцэж арга туршлагаа солилцдог тусгай арга хэмжээнд идэвхитэй оролцож даян дэлхийн тогтвортой хөгжилд Монгол улсын баримталж буй чиг бодлогын талаар байр сууриа илэрхийлж байв. Төлөөлөгчдийн тэргүүн Ж.Энхсайхан G-77-ын бүлгийн хуралдаанд далайд гарцгүй орнуудын тогтвортой хөгжлийн талаар үг хэлж эцсийн баримт бичигт энэ орнуудын эрх ашгийг тусгахыг онцлон дурьдсан бол төлөөлөгчдийн гишүүн проф.Д.Дагвадорж "Үндэсний засаглал ба тогтвортой хөгжил" сэдэвт олон улсын дугуй ширээний ярилцлагад оролцож Азийн бүс нутаг, түүний дотор Монгол улсыг тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гол орнууд болох АНУ болон хөгжингүй орны ижил төрлийн байгууллагуудтай холбон боломжийн талаар үг хэлж, санал бодлоо солилцов. Энэхүү дугуй ширээний ярилцлагад оролцсоноор "Access Initiative" гэж нэрлэгддэг даян дэлхийн холбоотой Монголын ТХҮЗ хамтран ажиллах шинэ боломж нээгдэж байна. Энэ байгууллага нь тогтвортой хөгжил, ялангуяа байгаль орчны талаар шийдвэр гаргахад олон нийтийн сонирхлын бүлгүүдийн оролцоог дэмжих, мэдээлэл солилцон хамтран ажиллах үйл ажиллагаа явуулдаг юм.

Мөн даян дэлхийг хамгаалах эвлэл (The World Conservation Union) зэрэг байгууллагууд Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Албатай хамтран ажиллахаа илэрхийлсэн.

4-р сарын 1-ний өдөр тогтвортой хөгжлийн даян дэлхийн зөвлөлөөс зохион байгуулсан "Тогтвортой хөгжилд оролцогчдын оролцоог өргөжүүлэн гүнзгийрүүлэх нь" /Deepening and Broadening Participation in Sustainable Development / сэдэвт арга хэмжээнд /Side Even/-д миний бие "ТХҮЗ-аар дамжуулан Монгол Улс дахь тогтвортой хөгжлийг удирдаж байгаа нь" /Governance for Sustainable Development Mongolia through NCSD/ сэдэвт илтгэл тавин хэлэлцүүлэв. Илтгэлийг ил үзүүлэн /Power Point/-ээр гаргаж тайлбарласны хамт, Монгол улсын тогтвортой хөгжлийн тайлан /National Report/ зэрэг материалуудыг тарааж ярихад оролцогчид ихэд сонирхсон юм. Ялангуяа "Тогтвортой хөгжил хүүхдийн нүдээр" гэсэн гэрэл

зургийн цомог номыг тэд их сонирхож байв. Оролцогчид монголын хөдөө нутаг дахь тогтвортой хөгжлийн удирдлагын асуудлыг онцгойлон асууж танилцаж байсан.

"Ази тивд тогтвортой хөгжлийн үйлсийн удирдлагыг хамгийн оновчтой зохион байгуулан хэрэгжүүлж бусад орнуудад туршлага болохуйц арга туршлагыг хуримтлуулжээ гэдгийг" хурал даргалагч онцлон тэмдэглэв. Энэ тухай хурлын дараагийн өдөр хэвлэгдсэн бюллетэнд Монголын тогтвортой хөгжлийн "мэдэгдэхүйц туршлагын" /notable development/-н талаар ярив хэмээн онцлон тэмдэглэж илтгэгчийн зурагтайгаар хэвлэгдсэн байлаа. Мөн интернетийн <http://www.iisd.ca/linkages/2002/pc3/enbots/> гэсэн вэйб-сайтад тусгаж нийтийн хүртээл болгосон юм.

Хуралд оролцох явцдаа Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлэх талаар дэлхийн улс орон байгууллагуудын 30 гаруй хүмүүстэй шууд уулзан ярилцаж заримтай нь интернетээр харилцан санал солилцож байсны дотор Даян дэлхийн зөвлөлийн зохицуулагч Dr.Fayend'Evie, Чадавхи-21 сангийн Ази-Номхон далай хариуцсан бүсийн менежер Anito Nirotu нарын хүмүүстэй Монгол Улсын Тогтвортой хөгжлийн ирээдүй, төслийн 3 дахь шатыг эхлүүлэх боломжийн талаар ярилцсан болно. Тэд Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн сургалт, судалгаа болон цэвэр технологийг дэмжин хөгжүүлэх практикийг нэгтгэн удирдах үүрэг бүхий Тогтвортой Хөгжлийн Үндэсний Хүрээлэн /National Institute for Sustainable Development/-г байгуулах бодолтой байгаа тухай бидний саналыг ихэд дэмжиж MAP-21 ийм замаар хөгжихэд бид баяртай байна, Чадавхи-21 сан "Даян дэлхийн зөвлөл" бүх талаар дэмжих болно гэдгээ илэрхийлж байв.

Түүнчлэн хурлын чөлөө цагаар НҮБ-д суугаа Монгол Улсын Байнгын Төлөөлөгчийн Газрын ажилтнуудад "Монгол улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт, ирээдүйн төлөв" сэдвээр мэдээлэл хийж санал бодлоо солилцсон маань ТХҮЗ, НҮБ дахь Байнгын төлөөлөгчийн газраас цаашид үйл ажиллагаа уялдуулан ажиллахад чухал ач холбогдолтой болсон юм.

#### **Нэгдсэн дүгнэлт:**

1. Гурав дахь удаагийн бэлтгэл чуулган Өмнөд Африкт болох дээд хэмжээний уулзалтаар хэлэлцэх асуудлыг бүлэг, зүйл бүрээр нь нарийвчлан хэлэлцэж тодорхой ахиц гарган 5-р сарын сүүлчээр Индонез улсын Бали-д болох 4 дэх удаагийн уулзалтаар хэлэлцэх асуудлаа нарийвчилж чадсан илүү практик үр дүнтэй чуулган боллоо.

2. Энэ чуулганы нэгэн том гарц болох хоёр болон олон талын түншлэлийн хүрээг өргөжүүлж, даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйлсийг хамтран хэрэгжүүлэхэд улс орнуудын олон улсын байгууллагууд, олон талт оролцогчид бие биеэ илүү таньж мэдэн шууд

хамтран ажиллах талаар алхам хийж чадсан түншлэлийг өргөжүүлэх олон улсын томоохон арга хэмжээ боллоо.

3. Энэ удаагийн чуулганд Монгол улсын төлөөлөгчид практик өгөөжтэй оролцож, улс орноо даян дэлхийд таниулах талаар бодитой зүйл хийсний зэрэгцээ монгол улс дахь тогтвортой хөгжлийг санхүүгийн болон зохион байгуулалт арга зүйн талаар дэмжиж ажиллах түншүүдтэйгээ ойртон нөхөрлөсөн нэн ашигтай мөчүүд болж өнгөрсөн юм.

### **Саналууд:**

1. Монгол улс НҮБ-ийн тогтвортой хөгжлийн гишүүн орон болсон байр сууриа ашиглаж цөлжилт, ойжуулалт гэсэн тулгамдсан асуудлаар үр ашигтай яриа хэлэлцээ хийж байгаа өнөөгийн алхмаа улам гүнзгийрүүлж бодитой хөрөнгө оруулалт татах талаар ажиллахын хамт эх орондоо тогтвортой хөгжлийн сургалт судалгааны шинэ тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр дэлхийн хөгжингүй орнууд олон улсын байгууллагуудтай ажиллах хамтын ажиллагаа, санхүүжилтын шинэ боломжийг илрүүлэх.

2. Даян дэлхийн дээд хэмжээний уулзалтанд бэлтгэх олон талт ажлын хүрээнд XXI зуунд Монгол Улсын Тогтвортой Хөгжлийг удирдаж зохион байгуулах шинэ хэлбэрийг бий болгох талаар НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Чадавхи-21 сан, Монгол улсын засгийн газар болон гадаад дотоодын холбогдох байгууллага хүмүүстэй тодорхой яриа хэлцэл хийж үр дүнд хүрэх. Удирдлага зохион байгуулалтын энэ шинэ хэлбэр бол даян дэлхийн ба Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн өнөө ирээдүйг судлан шинжилж түүнийг хүн ардаа хүргэж ойлгуулдаг эрдэм шинжилгээ сургалтын төв, бас байгаль орчинд хоргүй үйлдвэрлэл бизнесийг дэмжин хөгжүүлж санхүүжүүлдэг практик үйлсийг удирдах төв гэсэн давхар үүргийг гүйцэтгэдэг Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үндэсний Хүрээлэн байгуулж ажиллуулах явдал гэдэг нь аяндаа тодорхой байна.

3. Даян Дэлхийн Тогтвортой Хөгжлийн Дээд Хэмжээний уулзалтанд бэлтгэх ажлаа улам эрчимжүүлж энэ асуудлыг ойрын хугацаанд болон ТХУЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэхийн зэрэгцээ Байгаль орчны ТББ-уудын сүлжээ, БОЯ-тай хамтран хийх тогтвортой хөгжлийн стратегийн удирдлага семинарыг бэлтгэл зохион байгуулалттай хийж үр дүнд хүрэх.

4. 5-р сарын сүүлчээр Индонезийн Бали хотноо болох /Сайд нарын төвшний/ бэлтгэл хорооны IV чуулганд оролцохдоо өмнөх уулзалтуудад монгол улсын төлөөлөгчид оролцож ирсэн амжилт туршлагаа улам бататган оролцож, Өмнөд Африкийн уулзалтаар хэлэлцэх эцсийн баримт бичигт өөрийн улсын эрх ашиг байр суурийг тусгуулах талаар илүү эрчимтэй ажиллах. Энэ чуулганд холбогдох сайд болон ТХУЗ-ын нарийн бичгийн даргаас гадна Гадаад Харилцааны Яамны Тогтвортой Хөгжил хариуцсан мэргэжилтнийг төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд оролцуулах бодит шаардлага гарч байна гэдэгт НҮБ-д суугаа Монгол улсын төлөөлөгчдийн газар, ТХУЗ-ийн санал нэг байгааг холбогдох байгууллагуудад уламжилж байна. Учир нь Индонезид болох дөрөв дэх удаагийн энэ чуулган урьдчилж товлосноос 3 хоногийн өмнө буюу 5-р сарын 24-нөөс эхлэн 16 хоног үргэлжлэх бөгөөд чуулганы даргын

баримт бичиг дээр ажлын хэсгүүдэд хуваагдан ажиллах шаардлага гарч байгаа юм. Түүнчлэн Монгол Улсын Засгийн Газрын гишүүн сайд чуулганы сүүлчийн өдрүүдэд цөөхөн хоногоор оролцох боломжтой байгаагаас энэ асуудал урган гарч байгаа юм.

2002 оны 4-р сарын 12

### **3. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛ ХОРООНЫ 4 ДЭХ УДААГИЙН БЭЛТГЭЛ ЧУУЛГАНД**

#### **Participation in IV meeting of Preparatory Committee for WSSD**

The fourth meeting held between 26th of May and 7th of June 2002 in Bali city of Indonesia. This meeting discussed the political platform of WSSD and came to the agreement on the common principles of mutual cooperation at the WSSD. In this meeting participants of Mongolian representatives consisted of Prof. D.Dagvadorj, national coordinator of MAP-21, Ts.Oyunchimeg, officer of UNDP in Mongolia and D.Baljinnyam, head of Mongolian women's NGO's network. The fourth meeting developed the action plan to implement WSSD decisions, which consists of 9 sections and 158 provisions. However, 80 per cent of the plan was agreed and the political platform was not in full consensus, as it was the most vulnerable issue touching interest of many countries. Mongolian delegation noted that it is important to strength the Capacity-21, which has a crucial role for national capacity building for developing countries and expressed that Mongolia supports 135th provision of action plan for implementing WSSD decisions. Prof. D. Dagvadorj has given much emphasis to Anito Niroty's speech, officer of the Capacity-21, taking responsibility for Asia and Pacific, who informed that Mongolia and Nepal were selected as a case for Capacity-2015. It was the most notable event for Mongolia.

**Чуулганы хуралдааны талаар:** Дөрөв дэх удаагийн бэлтгэл чуулган 2002 оны 5-р сарын 26-наас 6-р сарын 7-ны өдрүүдэд Индонези улсын аялал жуулчлалын тусгай бүс нутаг Бали хотноо хуралдсан юм. Чуулганд урьдын адилаар НҮБ-ын гишүүн бүх орны засгийн газрыг төлөөлсөн ажилтан, тогтвортой хөгжлийн мэргэжилтнүүд оролцсоноос гадна чуулганы эхний хоёр өдөр дэлхий дахины эмэгтэйчүүд, залуучууд, үйлдвэрчний эвлэл, уугуул нутгийнхан,

эрдэмтдийн бүлгийн төлөөллийг оролцуулсан олон талын зөвлөлдөх уулзалт хийж, Дээд хэмжээний уулзалтаар эцэслэн тохирох олон талт хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг тохиролцсон болно. Энэ чуулганы өөр нэг онцлог бол чуулганы сүүлийн гурван өдөр дэлхийн 100 гаруй орны байгаль орчны сайд нар оролцсон сайд нарын төвшиний уулзалт болж дээд хэмжээний уулзалтаас гарах улс төрийн тунхаглалыг шүүн хэлэлцсэн юм.

Монгол улсаас Байгаль орчны сайд У.Барсболд төлөөлөгчдийг албан ёсоор тэргүүлэх байсан боловч ажлын шаардлагын улмаас хүрэлцэн очиж чадаагүй билээ. Иймд миний бие уг чуулганд Монгол улсын төлөөлөгчдийн тэргүүний үүрэгтэйгээр оролцсон болно. Монголын эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын сүлжээний тэргүүн Д.Балжинням төрийн бус байгууллагуудын олон талт уулзалт ярилцлагад оролцож, Өмнөд Африкийн Дээд Хэмжээний Уулзалтанд Монгол Улсын ТББ-уудын оролцох чиг хандлагыг судалж ирсэн болно. Мөн НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн ажилтан Ц.Оюунчимэг хоёр дахь долоо хоногийн хуралдаан, Side event-уудад оролцсоны хамт тогтвортой хөгжлийн чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг судалж тодорхойлох ,технологи шилжүүлэх , цэвэр технологийг хөгжүүлэх чиглэлээр UNIDO зэрэг олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй холбоо тогтоох ажилд идэвхи санаачлагатай оролцож ажиллав.

Энэ удаагийн чуулганаар хэлэлцсэн асуудлын чиглэл, зохион байгуулалт, арга зүй өмнө нь болсон 2,3 дахь удаагийн чуулганахаас өвөрмөц ялгаатай байсан юм.

Урьдын адилаар Өмнөд Африкт болох Дээд Хэмжээний уулзалтаар хэлэлцэн гаргах шийдвэрийн талаарх чуулганы даргын баримт бичгийг ажлын 3 бүлэг болон 2 долоо хоногийн турш хэлэлцэв.

Энэ хэлэлцүүлгийн дүнд чуулганы даргын оруулсан баримт бичгийг нарийвчлан боловсруулж "Даян дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл"-ийг 9 бүлэг, 158 зүйлтэйгээр боловсруулан гаргалаа.

Ажлын бүлгүүдийн хуралдаан маш эрчимтэй болж дээрхи 158 зүйлийн 80 гаруй хувийг эцэслэн тохирч, дээрхи баримт бичигт тусгасан юм. Харин төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэрэгсэл (арван нэгдүгээр бүлэг) зэрэг зарим бүлэг зүйл анги шийдвэрлэх асуудлын цар хүрээ бүтцийн хувьд ихээхэн нарийн төвөгтэй байсан тул Иоханнесбургийн уулзалтаар эцэслэн тохирохоор тогтож, тусгай тэмдэглэлтэйгээр энэ баримт бичигт оруулсан. Дэлхийн бүх орны төлөөлөгчид тогтвортой хөгжлийн үзэл баримтлал арга зүйн талаар нэгдмэл байр сууринд хүрч, ирэх арван таван жилд хийж гүйцэтгэх ажлынхаа үндсэн хүрээ, хүрэх зорилгоо цаг хугацааны баримжаатайгаар, боломжтой хэсгийг нь тоон үзүүлэлтээр тодорхойлон гаргаж чадсан нь энэ чуулганы чухал ололт болсон гэж үзэж болно. Энэ бол чуулганы



төлөөлөгчид асуудал бүрд нухацтай хандаж тогтвортой хөгжлийн үйлсийг хоосон уриа лоозон болгох биш, бодит ажил хэрэг болгох талаас нь хандсаны тодорхой үр дүн болсон юм.

Ажлын группуудад манай улсын төлөөлөгчид сонирхсон чиглэлүүдээрээ оролцож ажиллав. Энэ удаагийн хуралдаанд Монгол улс бүрэлдэхүүнд нь багтдаг G-77 гэгдэх хөгжиж буй орнууд хэлэлцэж буй асуудлын талаар хамтын байр сууриа нэгтгэн нэгдсэн хуралдаанд оролцож байлаа.

Балийн сайд нарын төвшиний чуулганаар эцэслэн гаргах байсан улс төрийн тунхаглалыг сүүлийн гурав хоног дэлхийн улс орнуудын байгаль орчны сайд нар тал бүрээс нь шүүн хэлэлцсэн боловч бүрэн зөвшилцөлд хүрч чадаагүй бөгөөд дээд хэмжээний уулзалт хүртэлх үлдэж буй 2 сар гаруй хугацаанд улс орнууд байр сууриа харилцан солилцож, Иоханесбургийн уулзалтаас гарах тунхаглалыг нарийвчлан тохирохоор болов. Энэ бол хэлэлцсэн асуудал хир зэрэг нарийн төвөгтэй дэлхийн олон орны эрх ашгийг хөндсөн эмзэг бөгөөд тулгамдсан асуудал гэдгийг баталсан хэрэг боллоо. Гэвч чуулганыг хааж бэлтгэл чуулгануудын дарга профессор Emil Salim хэлсэн үгэндээ "Бид олон талаас нь маш нарийн хэлэлцэж, улс төрийн тунхаглалын 80 орчим хувийг тохирлоо" гэж дурьдсан юм.

**Бэлтгэл чуулганд Монгол улсын төлөөлөгчдийн оролцсон талаар:** Монгол улсын төлөөлөгчдийн тэргүүний хувьд ажлын группуудын хуралдаан, хуралдааны чөлөөт тусгай арга хэмжээ (side event)-үүдэд оролцож даян дэлхийн тогтвортой хөгжилд Монгол улсын баримталж буй чиг бодлогын талаар байр сууриа илэрхийлж байв. Миний бие G77-ийн бүлгийн 5-р сарын 29-ны хуралдаанд оролцохдоо хөгжиж буй орнуудын тогтвортой хөгжлийн үндсэн чадавхийг нэмэгдүүлэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн UNDP Чадавхи-21 санг бэхжүүлэх тухай, тус сангаар дамжуулан хөгжиж байгаа орнуудын тогтвортой хөгжлийн чадавхийг нэмэгдүүлэх тухай Дээд Хэмжээний уулзалтын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 135 дугаар зүйлийг Монгол улс бүрэн дэмжиж байна гэдгээ илэрхийлсэн юм.

5-р сарын 30-нд "Хөгжиж буй орнууд ба нийгмийн хариуцлагын бизнес" (Developing Countries and Corporate Social Responsibility) гэсэн дугуй ширээний ярилцлагад оролцов. Энэхүү дугуй ширээний ярилцлагад дэлхийн 60 гаруй орны төлөөлөгчид оролцож, засгийн газар, бизнес, иргэний нийгмийн түншлэл тогтвортой хөгжлийн үндэс болохыг, чухамхүү алсыг харсан бизнес нь нийгмээ цогцолбороо хөгжүүлэх хэрэгсэл болохыг тал бүрээс нь ярилцав. Дугуй ширээний ярилцлагын үеэр улс орнууд арга туршлагаа солилцох үед Монгол Улсын ТХҮЗ олон талын түншлэлийг хөгжүүлэх өвөрмөц хэлбэр болж буйг мэдээлэхэд хуралд оролцогчид Монгол төр, Засгийн Газар бизнестэйгээ хэрхэн хамтарч ажиллаж буй талаар сонирхон асууж лавлаж байв. Энэ уулзалт 6 цаг гаруй үргэлжилж тогтвортой хөгжлийн

механизмын талаар цоо шинэ мэдээлэлтэй болсон бөгөөд олон улсын эрдэмтэд, бизнесийн хүрээнийхэнтэй хамтран ажиллах талаар ярилцлаа.

5-р сарын 31-нд өөр нэгэн нэн чухал үйл явдалд оролцов. Даян дэлхийн зөвлөл, Индонези улсын байгаль орчны яам хамтран зохион байгуулсан "Тогтвортой хөгжлийн төлөө олон талын оролцогчидтой засаглалын механизмыг хүчтэй болгох нь" (Strengthening Multi-stakeholder Governance Mechanisms for Sustainable Development) сэдэвт олон улсын уулзалт ярилцлагад дэлхийн 45 орны ТХҮЗ-ийг төлөөлсөн мэргэжилтнүүд оролцсон юм. Энэ хуралд даян дэлхийн зөвлөлийн Ази-Номхон далайн бүсийн менежер Ella Antonina дэлхий дахины ТХҮЗ-үүдийн үйл ажиллагааны талаар гол илтгэлийг хэлэлцүүлж, бусад орнууд арга туршлага мэдээлсний дотор миний бие "Монгол улсын ТХҮЗ-ийн менежмент" гэсэн агуулгатай, кодоскопын үзүүлэнтэйгээр товч илтгэл хийв. Үндэсний хэмжээнд болон орон нутгийн хэмжээнд зүгширсэн бүтцийг бий болгож чадсан манай орны ТХҮЗ дотоод, гадаадын холбогдох байгууллага, мэргэжилтнүүдтэй байнгын холбоотой ажиллаж мэдээлэл авч байдаг бөгөөд UNDP/ Чадавхи-21 сан, даян дэлхийн зөвлөлийн ажилтнуудын байнгын дэмжлэг тусламж нь үндэсний хэмжээнд тогтвортой хөгжлийн олон талын түншлэлийг бий болгох таатай нөхцөл болж байдгийг илтгэлдээ онцлон дурьдсан. Товч илтгэл бусад орнуудын мэргэжилтнүүдийн анхаарлыг татаж, уулзалтын явцад болон дараа нь тэдэнтэй уулзаж хамтран ажиллах талаар ярилцсан болно.

Хуралд оролцох явцдаа Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлэх талаар дэлхийн улс орон байгууллагуудын 50 гаруй хүмүүстэй шууд уулзан ярилцаж заримтай нь интернетээр харилцан санал солилцож байсны дотор Даян дэлхийн зөвлөлийн Ази номхон далайн бүсийн зохицуулагч Ella Antonina, Чадавхи-21 сангийн Ази-Номхон далай хариуцсан бүсийн менежер Anito Nirotu, Michiyo Kakagowa, UNIDO-ийн аж үйлдвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн Ouseph Padickakudi нарын хүмүүстэй Монгол Улсын Тогтвортой хөгжлийн ирээдүй, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар ярилцсан болно.

Балийн чуулганы үеэр манай улсын тогтвортой хөгжлийн ирээдүйд нэн чухал ач холбогдолтой нэгэн чухал үйл явдал болсныг зориуд дурьдахад таатай байна. Хөгжиж байгаа орнуудын тогтвортой хөгжлийн үйл явцыг дэмждэг UNDP-гийн Чадавхи-21 сан ирэх 15 жилд Чадавхи-2015 болон үйл ажиллагаагаа өргөжүүлэхээр болж албан ёсны нээлтээ 6-р сарын 6-нд хийлээ. Энэ сан ирэх арван таван жилд "Орон нутгаас үндэсний хэмжээнд, улмаар даян дэлхийд" (Local to National to global) гэсэн зорилгын дор хөгжиж байгаа орнуудын тогтвортой хөгжлийн үйл явцыг дэмжих өргөн хүрээтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм. Ингэхдээ өмнөх 10 жилд тогтвортой хөгжлийн талаар улс орнуудын олсон амжилганд тулгуурлахын зэрэгцээ шинэ шинэ боломжийг ашиглан хөгжих юм. Saracity-2015-ийн хүрээнд жишээ болон багтааж байгаа орнуудын тоонд Азиас 2 орон хамгийн түрүүнд сонгож

авсны нэг нь Монгол Улс болсон (нөгөө нь Балба) тухай Чадавхи-21 сангийн Ази-Номхон далай хариуцсан бүсийн менежер Anito Niroty надад мэдээлсэн нь манай орны хувьд нэн тэмдэглэлтэй үйл явдал болсон гэж үзэж болно.

Нэгэн зүйлийг нэмж тэмдэглэхэд чуулганд оролцохоор очих замдаа миний бие 5-р сарын 23-нд Тайландын нийслэл Бангкок хотноо Тайландын вант улсын ТХҮЗ-ийн нарийн бичгийн дарга ноён Chalermkarn Wanichsambat-тай 'lunch meeting' хийв. Энэ уулзалтанд Чадавхи-21 сангийн Ази-Номхон далай хариуцсан бүсийн менежер, Michiyo Kagakawa, Anito Niroty нар оролцов. Бид Азийн бүс нутагт тогтвортой хөгжлийн талаар хэрэгжүүлж буй ажлын тухай харилцан мэдээлэл солилцсоны хамт Тайланд Монголын ТХҮЗ-ийн ажлын арга туршлагын талаар ярилцаж хоёр орны хооронд шууд хамтран ажиллах (мэдээлэл солилцох, семинар симпозиум зохиох гэх мэт) боломжтой байгааг тэмдэглэв.

Мөн Дээд хэмжээний уулзалтын Бэлтгэл Чуулганы дууссан өдөр буюу 6 сарын 08 ны Бямба гаригт Зүүн Хойт Азийн орнуудын шар шуурганы /Yellow sand/ асуудлаар Монгол, Солонгос, Япон, Хятадын Байгаль орчины Сайд нарын уулзалтанд Монгол улсаа төлөөлөн оролцов. Энэ уулзалтанд мөн UNEP, ADB-ийн удирдлагууд оролцсон юм. Сайд нар шар шуурганы асуудлаар харилцан санал бодлоо илэрхийлж үг хэлэх үед Монгол улсын байр суурийн талаар би 2 ч удаа үг хэлж Монгол улс эн тэнцүү оролцогч болж чадсан бөгөөд надтай хамт уг уулзалтанд оролцсон UNDP-ийн мэргэжилтэн Ц.Оюунчимэг чухал үүрэг гүйцэтгэсэн. Дөрвөн орны байгаль орчины сайд нарын уулзалт нэгдмэл байр суурьтай шийдвэр гаргаж шар шуургатай тэмцэх GEF ийн томоохон төслийг хэрэгжүүлэхээр тогтон түүний бэлтгэл болгож санхүүжилтийн PDF-В хэлбэрээр санал боловсруулж 6 сарын 17-18 нд Улаанбаатарт болох дээрхи 4 орны мэргэжилтнүүдийн хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзэв. Энэ төслийн саналаар бол эн тэргүүнд Хятад, Монгол улсын шар шуургатай тэмцэх асуудлыг нарийвчлан боловсруулах, чадавхи бүрдүүлэх зорилгоор UNEP, ADB-ээс нэг сая орчим ам.долларын санхүүжилт хийх ажээ. Ийнхүү Монгол төдийгүй Зүүн Хойт Азийн орнуудын элсний нүүдэл, шар шуургатай тэмцэх олон улсын хамтын томоохон үйлсийн эхлэлийг тавьсан түүхэн уулзалтанд эх орноо төлөөлөн оролцсондоо сэтгэл ханамжтай байна.

#### **Нэгдсэн дүгнэлт:**

1. Дөрөв дэх удаагийн бэлтгэл чуулган Өмнөд Африкт болох дээд хэмжээний уулзалтаар хэлэлцэх асуудлыг бүлэг, зүйл бүрээр нь нарийвчлан хэлэлцэж, тогтвортой хөгжлийн даян дэлхийн дээд хэмжээний уулзалтаас гарах шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний төслийг үндсэнд нь бэлэн болгосон практик үр дүнтэй чуулган боллоо.

2. Энэ чуулганы бас нэгэн том гарц болох 2 болон олон талын түншлэлийн хүрээг өргөжүүлж, даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйлсийг хамтран хэрэгжүүлэхэд улс орнууд,

олон улсын байгууллагууд, олон талт оролцогчид бие биеэ илүү таньж мэдэн шууд хамтран ажиллах талаар алхам хийж чадсан түншлэлийг өргөжүүлэх олон улсын зарчмуудыг томъёолж бэлэн болгосон томоохон арга хэмжээ боллоо.

3. Энэ удаагийн чуулганд Монгол улсын төлөөлөгчид өмнөх хоёр, гурав дахь чуулганд оролцсоны адилаар практик өгөөжтэй оролцож, улс орноо даян дэлхийд таниулах талаар бодитой зүйл хийсний зэрэгцээ монгол улс дахь тогтвортой хөгжлийг санхүүгийн болон зохион байгуулалт арга зүйн талаар дэмжиж ажиллах боломж бүхий Чадавхи-2015 сан албан ёсоор нээлтээ хийсэн туйлын ач холбогдолтой арга хэмжээ болсон юм.

### **Саналууд:**

7. 1. Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар хийж байгаа практик алхамуудаа өргөжүүлэхийн зэрэгцээ Чадавхи-2015 сангийн хүрээнд ирэх он жилүүдэд хийж гүйцэтгэх ажлынхаа чиг бодлогыг тодорхойлж, холбогдох талуудтай зөвшилцөх.
8. 2. Монгол улсын Засгийн Газар, төрийн бус байгууллагууд, бизнесийн байгууллагууд тогтвортой хөгжлийн чиглэлээр хамтран ажиллах шинэ арга хэлбэрийг сонгон авч, олон талын түншлэлийг бүрдүүлэх чиглэлээр дорвитой алхам хийх.
9. 3. Дээд хэмжээний чуулга уулзалтанд оролцох Монгол улсын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо даян дэлхийд энэ чиглэлээр ажиллаж байгаа хүмүүстэй уулзаж, монгол улсад хэрэгтэй шинэ мэдээлэл, хамтын ажиллагааны шинэ боломжийг олж гаргаж чадахуйц эх орондоо авчирч чадах мэргэжилтний чадварлаг группийг байгаль орчин, санхүү эдийн засаг, үйлдвэрлэл худалдаа, дэд бүтэц, нийгмийн хамгаалал, гадаад харилцаа, шинжлэх ухаан боловсролын, төрийн захиргааны төв байгууллагуудаас бүрдүүлж томилон явуулах.
10. Даян дэлхийн дээд хэмжээний уулзалтанд бэлтгэх Монгол улсын бэлтгэл хорооны (ТХҮЗ) хуралдааныг хийж хуралдаанаар Иохенесбургийн уулзалтанд оролцох Монгол улсын оролцоо, түүнээс гарах урьдчилсан үр дүнгийн талаар хэлэлцэж, энэ чиглэлд төр олон нийт, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зангидаж мэдээллийн хэрэгслийн хүчийг өргөнөөр ажиллах.

2002 оны .6-р сарын 15

## **5. ДАЯН ДЭЛХИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ДЭЭД ХЭМЖЭЭНИЙ ЧУУЛГА УУЛЗАЛТАД МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨЛӨГЧИД ОРОЛЦСОН НЬ**

### **Participation of Mongolian Delegation at the World Summit for Sustainable Development**

The Summit was convened from 26 August to 4 September at the Sandton Convention Centre in Johannesburg, South Africa. The Summit was the largest ever international meeting on

sustainability and brought together thousands of participants, including heads of State and Government, business leaders and representatives of civil society, to promote sustainable development. The Johannesburg Declaration was approved at the Summit on September 2-4 attended by 109 heads of State and Government. Mr.N.Bagabandi, President of Mongolia made a speech at the Summit and met with heads of over 10 States and Governments and negotiated on bilateral cooperation. There is a good opportunity to have support to Mongolian sustainable development from our Parliament that Mr.B.Shiirevdamba and Mr.R.Sandalhaan, both members of Mongolian Parliament participated at 2 days Summit on the strategy and policy issues to support the sustainable development by Parliaments of countries of the world. Mr.U.Barsbold, Minister of Nature and Environment of Mongolia, Mr.Ykhanbai and Enkhbayar, both Director of the Department of MONE, Mrs.Narantuya, Officer of MNE participated at the meetings on environmental issues.Mr.B.Ganbold, State Secretary of MOFA, Mr.G.Batjargal, Deputy Director of the Department for Multilateral Cooperation, Mr.G.Jargalsaikhan, Chief of Division and Mr.D.Zorigt, Secretary of Resident Representative of Mongolia at UN are organized bilateral and multilateral meetings during the Summit. Mr.D.Dagvadorj participated number of side events beside the Summit and worked in direction to strengthen the links established with delegations of international organizations such as UNDP and UNIDO on further cooperation in framework of Capacity 2015, development of clean production etc.

Даян дэлхийн тогтвортой хөгжлийн Дээд Хэмжээний Чуулга уулзалт 2002 оны 8-р сарын 26-наас 9-р сарын 4-ны өдрүүдэд Өмнөт Африкийн аялал жуулчлал, бизнесийн төв Иоханнесбург хотноо хуралдсан юм.

Чуулга уулзалтын эхний долоо хоногт болсон хуралдаануудад НҮБ-ын гишүүн бүх орны засгийн газрыг төлөөлсөн сайд нар, тогтвортой хөгжлийн болон гадаад харилцааны мэргэжилтнүүд оролцсоноос гадна дэлхий дахины эмэгтэйчүүд, залуучууд, үйлдвэрчний эвлэл, уугуул нутгийнхан, эрдэмтдийн бүлгийн төлөөллийг оролцуулсан ерөнхий хуралдаанууд хийж дараах 5 гол асуудлыг ойрын ирээдүйд дэлхий даяараа хэрхэн шийдвэрлэх арга замын талаар зөвлөлдөв. Үүнд:

1. Усны хямралыг даван туулах
2. Эрчим хүчний зохистой бүтцийг бий болгох
3. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах
4. Хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэх
5. Байгалын төрөл зүйл ба онгон байгалыг хамгаалах

Дээд хэмжээний чуулга уулзалтын 2 дахь долоо хоног буюу 9 сарын 2 ноос 4-нд дэлхийн 109 орны төр засгийн тэргүүн нар оролцсон Дээд хэмжээний уулзалт болж даян дэлхийн тогтвортой хөгжлийн талаархи улс төрийн тунхаглалыг батлан гаргав. 9 сарын 3 буюу энэхүү

дээд хэмжээний уулзалтын 2 дахь өдрийн хуралдаан дээр Монгол улсын ерөнхийлөгч Н. Багабанди үг хэлсэн юм. Үүний хамт манай Ерөнхийлөгч 10 гаруй орны төр засгийн тэргүүнүүдтэй уулзаж хоёр талын хамтын ажиллагааны талаар тохиролцсон билээ. Монгол Улсын Их Хурлын гишүүн Б. Шийрэвдамба, Р.Сандалхаан нар 8 сарын 29, 30-д дэлхийн улс орнуудын парламентаас даян дэлхийн тулхтай хөгжлийг дэмжих стратеги, бодлогын асуудлаар болсон 2 өдрийн хуралдаанд оролцсон нь цаашид Монгол улсын тогтвортой хөгжилд УИХ-ийн зүгээс дэмжлэг үзүүлж ажиллах сайхан боломжийг олгосон юм.

Мөн Байгаль орчны сайд У.Барсболд, тус яамны газрын дарга Ыханбай, Энхбаяр, мэргэжилтэн Нарантуяа нар сүүлийн долоо хоногт ирж байгаль орчны асуудлаар болсон арга хэмжээнүүдэд оролцсоны дээр сайд У.Барсболд Япон улсын Байгаль орчны сайд болон бусад өндөр албаны хүмүүстэй уулзаж шууд хамтын ажиллагааны талаар ярилцсан болно.

Мөн Гадаад хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга Б.Ганболд, Олон талт хамтын ажиллагааны газрын орлогч захирал Г.Батжаргал, хэлтсийн дарга Г.Жаргалсайхан, НҮБ-д суугаа байнгын төлөөлөгчийн газрын нарийн бичгийн дарга Д.Зоригт нарын хүмүүс Дээд хэмжээний чуулганы үеэр болсон хоёр ба олон талын уулзалтуудыг зохион байгуулахын зэрэгцээ гадаадын бусад орны холбогдох хүмүүстэй өөрсдөө уулзан ярилцаж чухал үүрэгтэй ажилласныг тэмдэглэхэд таатай байна.

Миний бие чуулганы ерөнхий хуралдаануудын зэрэгцээ олон тооны тусгай арга хэмжээнүүдэд оролцсоны хамт тогтвортой хөгжлийн чиглэлээр цаашид хэрэгжүүлэх ажлын чиглэлийг судалж тодорхойлох, орон нутгийн хамтлагийг хөгжүүлэх талаар 2015 сангийн хүрээнд хамтран ажиллах, цэвэр технологийг хөгжүүлэх зэрэг асуудлаар UNDP, UNIDO гэх мэт олон улсын байгууллагын төлөөлөгчидтэй тогтоосон холбоогоо гүнзгийрүүлэх чиглэлээр ажиллав.

Дээд Хэмжээний уулзалтаар хэлэлцэн гаргах шийдвэрийн талаарх баримт бичгийн Балид тохирч амжилгүй үлдсэн 25 хувийг ажлын хэд хэдэн бүлэг болон эхний долоо хоногийн турш хэлэлцэв. Энэ хэлэлцүүлгийн дүнд "Даян дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээний чуулга уулзалтын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г 10 бүлэг, 153 зүйлтэйгээр боловсруулан баталж гаргалаа. Ийнхүү дэлхийн бүх орны төлөөлөгчид тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, арга зүйн талаар нэгдмэл байр сууринд хүрч, 2015 хүртэл хийж гүйцэтгэх ажлынхаа үндсэн хүрээ, хүрэх зорилгоо цаг хугацааны баримжаатайгаар, боломжтой хэсгийг нь тоон үзүүлэлтээр тодорхойлон гаргаж чадсан нь энэ чуулганы чухал ололт болсон гэж үзэж болно.

Энэ бол чуулганы төлөөлөгчид асуудал бүрд урьдын адилаар нухацтай хандаж, тогтвортой хөгжлийн үйлсийг хоосон уриа лоозон болгох биш, бодит ажил хэрэг болгох талаас нь хандсаны тодорхой үр дүн болсон юм.

Чуулганы дарга, ӨАБНУ-ын ерөнхийлөгч чуулга ууулзалтыг хааж хэлсэн үгэндээ "Бид олон талаас нь маш нарийн хэлэлцэж, улс төрийн тунхаглалын баталлаа" гэж дурьдсан юм.

**Чуулганд уулзалтанд биечлэн оролцсон үр дүнгийн талаар:** Монгол улсын төлөөлөгчдийн гишүүн, ТХҮЗ-ийн нарийн бичгийн даргын хувьд Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын их хурлын гишүүд болон байгаль орчины сайдад ажлын хэсгүүдийн хуралдаан, хуралдааны чөлөөт цагаар арга туршлагаа солилцдог тусгай арга хэмжээнүүдэд болон тив, дэлхийн хэмжээний ТХҮЗ-үүдийн зохийн байгуулсан бага хурал семинаруудад оролцсон талаараа мэдээлэл өгч байв.

8-р сарын 30-нд Солонгос улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх ТХҮЗ, Япон улсын ТХҮЗ-өөс хамтран зохион байгуулсан Ази Номхон далайн орнуудын ТХҮЗ-үүдийн хуралдаан/Asia-Pacific NCSD Meeting/-д оролцож Монгол улсын ТХҮЗ-өөс дэлхийн дээд хэмжээний уулзалтыг угтан сүүлийн 2 сард зохион байгуулсан ажлын тухай мэдээлж, Азийн орнуудтай улам нягт хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлэв.

Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлүүдийн Азийн уулзалт зөвлөлгөөнийг цаашид тогтмолжуулах талаар ярилцаж, 2003 оны зун ийм хуралдааныг Монгол улсад зохион байгуулж өгнө үү гэсэн саналыг манай ТХҮЗ-д тавив. Би энэ саналыг хүлээн авч Дээд хэмжээний уулзалтад оролцохоор хүрэлцэн ирж буй Монголын ТХҮЗ-ийн орлогч дарга, Байгаль орчины сайд Барсболд-д уламжлаад хариу өгье гэсэн бөгөөд маргааш нь сайдтай зөвлөөд уг хуралдааныг Монголын ТХҮЗ зохион байгуулахад бэлэн байгаагаа мэдэгдсэн юм. Азийн орнуудын ТХҮЗ-үүд энэ шийдвэрийг талархан хүлээн авч, шаардлагатай бол Солонгос, Японы ТХҮЗ-үүд санхүүгийн дэмжлэг үзүүлж болно гэдгээ амалсан билээ. Ийнхүү Азийн орнуудын хэмжээнд Монгол улсын ТХҮЗ өөрийн гэсэн байр суурийг эзэлж тэдний талархал дэмжлэгийг хүлээж буй нь манай улсын гадаад нэр хүндийг нэмэгдүүлэхэд үлэмж ач холбогдолтой алхам боллоо.

Япон улсын ерөнхий сайд асан Хашимото тэргүүлдэг Ази Номхон далайн орчин ба хөгжлийн Форумаас "Мэдлэгт тулгуурласан шинэ түншлэлийг бүрдүүлэх нь" сэдэвт бага хурал зохион багуулав. Энэ форумын гишүүнээр манай Ерөнхий Сайд ажилладаг юм. Энэ Форум урьд өмнө нь Бангкок, Жакарта-д хуралдаан зохион байгуулж байсан бөгөөд даян дэлхийн энэхүү чуулганд Ази Номхон далай орнуудын тогтвортой хөгжлийн гол асуудлууд болох ус, эрчим хүч, худалдаа, санхүү, хотжилтын асуудлын талаар Чуулга уулзалтын шийдвэрт

тусгуулахаар нэгдмэл санал оруулсан юм. Мөн өдөр Ази Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисс/ESCAP/, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийн Ази Номхон далайн товчоо/Regional Bureau for Asia and the Pacific UNDP/ хамтран "Ази Номхон далай дахь Тогтвортой хөгжлийн төлөөх байгаль орчины удирдлага" сэдэвт арга хэмжээ зохион байгуулав.

Азийн орнуудын байгаль орчныг удирдаж буй үйл явцын үр дүнгийн тайланг тусгайлан ном болгон хэвлүүлсэнээ танилцуулав. Түүнд сайн засаглалын гол зүйл нь байгаль орчны зохистой удирдлага гэдгийг харуулаад, улс орнуудын тогтвортой хөгжлийн удирдлагыг нэгтгэн дүгнэсэн байна. Уг номонд Монгол улс 21-р зууны тогтвортой хөгжлийг үндэсний зөвлөлөөрөө дамжуулан амжилттай удирдаж байгаа, ялангуяа аймаг орон нутгийн хөгжлийн бодлого тогтвортой хөгжлийн хөтөлбөрт суурилан хэрэгждэг тухай онцлон тэмдэглэсэн байна. Энэ бүхэн бол Ази тив тогтвортой хөгжлийн удирдлагаар манлайлж байгааг харуулсан чухал алхамууд болсон юм.

8 сарын 31-ээс 9 сарын 2-ны өдрүүдэд Тогтвортой хөгжлийн даян дэлхийн зөвлөл/Earth Council/-өөс "Тогтвортой хөгжлийн засаглал ба олон талт хамтын ажиллагааны тогтвортой бодлогыг томъёолох нь" сэдэвт 3 өдрийн бага хурал, семинар хийв. Энэ хуралд дэлхийн 50 гаруй орны тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн голлох мэрэгжилтнүүд, үндэсний зөвлөлүүдийн нарийн бичгийн дарга нар оролцов. Сүүлийн өдрийн хуралдаанд нь Бельгийн Ерөнхий Сайд болон зарим орны Байгаль орчины сайд нар оролцсон билээ.

Эхний өдрийн Ерөнхий хуралдааны дараа тив бүрийн салбар хуралдаан болсны дотор Ази тивийн тогтвортой хөгжлийн Үндэсний зөвлөлүүдийн ажлыг уялдуулах талаар нарийвчлан зөвлөлдсөн бөгөөд миний бие Монголын ТХҮЗ-ийн үйл ажиллагааны онцлогийн талаар үг хэлэв.

Сүүлчийн өдрийн хуралдааныг "Тогтвортой хөгжлийн төлөө олон талын оролцогчидтой хамтран засаглалын механизмыг хүчтэй болгох нь" сэдвээр хийж Дээд хэмжээний чуулга уулзалтын дараа дэлхий дахины Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлүүд хамтран ажиллах стратеги бодлогоо тодорхойлов. Дэлхийн зарим улс орнууд тогтвортой хөгжлийн удирдлага, зохион байгуулалтын талаар асар их анхаарч Финланд, Уганда зэрэг нэлээд орон ТХҮЗ-ийнхээ дэргэд 10 орчим хүнтэй албыг засгийн газраасаа санхүүжүүлэн ажилладаг бол Филиппин улс 20 сая ам. долларын хэмжээний тогтвортой хөгжлийн сантай юм байна.

Дээд хэмжээний чуулга уулзалтанд оролцох явцдаа миний бие Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлэх, ТХҮЗ-ийн гадаад хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар дэлхийн улс орон, байгууллагуудын 60 орчим хүнтэй шууд уулзан ярилцаж, саналаа



солилцож байсны дотор Даян дэлхийн зөвлөлийн Ерөнхийлөгч Франс Ван Харен /France van Haren/, НҮБХХ-ийн ахлах эксперт Алваро Умано /Alvaro Umano/, НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн комиссын дарга асан Сиалито Хабито /Cielito F.Habito/, Орчин ба хөгжлийн олон улсын хүрээлэнгийн Стратеги, төлөвлөлт, үнэлгээний захирал Барри Далай Клайтон /Barry Dalai Clayton/ , НҮБ-ийн аж үйлдвэрийн байгууллага /UNIDO/-ын аж үйлсвэрийн бодлого хариуцсан мэргэжилтэн Оусеф Падикакуди /Ouseph Padickakudi/ нарын хүмүүстэй Монгол Улсын Тогтвортой хөгжлийн ирээдүй, шинэ төсөл хэрэгжүүлэх боломжийн талаар ярилцсан болно.

Балид болсон IV дэх удаагийн бэлтгэл чуулганы үеэр сууриа тавьсан Чадавхи -2015 сан ирэх арван таван жилд "Орон нутгаас үндэсний хэмжээнд, улмаар даян дэлхийд" (Local to National to global) гэсэн зорилгын дор хөгжиж байгаа орнуудын тогтвортой хөгжлийн үйл явцыг дэмжих өргөн хүрээтэй хөтөлбөрийг хэрэгжүүлэх юм. Ялангуяа нэг нутгийнхан, нэг голынхон, тодруулж хэлбэл нийгмийн хэсэг, бүлэг, хамтлагийн тулхтай хөгжлийг дэмжихэд ирэх он жилүүдэд анхаарч ажиллах ажээ. Бид ч нүүдэлч малчдын бүлгүүдийг дэмжих, Монголд тогтвортой хөгжлийн төв буюу хүрээлэн байгуулах чиглэлээр төсөл боловсруулан НҮБХХ-ийн Ази Номхон далайн товчоонд уламжлаад байгаа болно.

#### **Нэгдсэн дүгнэлт:**

1. Өмнөд Африкт болсон Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний чуулга уулзалт нь дэлхийн 109 орны төр засгийн тэргүүнүүд оролцож, улс төрийн тунхаглал батлан гаргасан үнэхээр даян дэлхийн хэмжээний цараатай үйл явдал боллоо.

2015 он хүртэлх хугацаанд дэлхийн улс орнууд тогтвортой хөгжлийн талаар шийдвэрлэх асуудал, хэрэгжүүлэх үйлсийг нарийвчлан хэлэлцэж тогтвортой хөгжлийн даян дэлхийн дээд хэмжээний уулзалтаас гарах шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гүйцээн боловсруулж батлан гаргасан практик үр дүнтэй чуулган боллоо.

2. Энэ чуулганы нэгэн том гарц болох хоёр болон олон талын түншлэлийн хүрээг өргөжүүлж, даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйлсийг хамтран хэрэгжүүлэхэд улс орнууд, олон улсын байгууллагууд, олон талт оролцогчид бие биеэ илүү таньж мэдэн шууд хамтран ажиллах талаар томоохон алхам хийж чадсан олон улсын түншлэлийн томоохон арга хэмжээ боллоо.

3. Энэхүү дээд хэмжээний чуулга уулзалтанд Монгол улсын ерөнхийлөгч, Улсын их хурлын зарим гишүүд , Байгаль орчины сайд, зарим мэргэжилтэн, Гадаад хэргийн яамны өндөр албаны хүмүүс үр дүнтэй, практик өгөөжтэй оролцож, хоёр болон олон талын уулзалтууд хийж, улсынхаа тулхтай хөгжлийн ирээдүйн талаар зөвшилцөн ярилцаж, Монгол улс даян

дэлхийн тогтвортой хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж ажиллах чин эрмэлзэлтэй байгаагаа харуулав.

### Саналууд:

1. Монгол улсын хөгжлийн ирээдүй, цаашдын чиглэлийг даян дэлхийн тулхтай хөгжлийн талаар тохиролцсон улс төрийн тунхаглал, үйл ажиллагааны хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэх, энэ талар төр засгийн байгууллагууд ба иргэний нийгмийн гүйцэтгэх үүргийг нарийн тодорхой болгосон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх
2. Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн эхний шатны /1999-2002 оны/ үр дүнг даруй гаргаж, төслийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэхийн хамт төслийн хэрэгжилтийн 2 дахь шатанд НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Чадавхи-2015 сангийн хүрээнд болон бусад сонирхогч талуудтай хамтран ажиллах төслүүдээ илүү нарийвчилж, тодорхой болгон холбогдох талуудтай зөвшилцөх.
3. Монгол улсын Ерөнхийлөгчийн алба, Улсын Их Хурал, Засгийн Газар, төрийн бус байгууллагууд, бизнесийн байгууллагууд, түүнчлэн улс төрийн намууд улсынхаа тулхтай хөгжлийн чиглэлээр нягт хамтран ажиллах оновчтой арга хэлбэрийг олж хэрэгжүүлэх, олон талын түншлэлийг бүрдүүлэх чиглэлээр дорвитой алхам хийх.
4. Монгол улсын Тогтвортой хөгжлийн үндэсний бага хурлыг хийж, Иоханнесбургийн уулзалтанд Монгол улсын төлөөлөгчдийн оролцсон үр дүн, цаашдын зорилт, ирээдүйд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан энэ чиглэлд төр, олон нийт, нийгмийн янз бүрийн бүлгүүдийн үйл ажиллагааг нэгтгэн зангидаж ажиллах, олон нийтэд тогтвортой хөгжлийн боловсрол олгох тогтолцоо бүрдүүлэх.
5. Монголынхоо тогтвортой хөгжлийн асуудлыг бие даан зохицуулдаг, эрдэм шинжилгээ судалгаа, сургалт, боловсролын тогтолцоог нэгтгэн удирдах тулхтай хөгжлийн удирдлага, төлөвлөлт, санхүүгийн оновчтой бүтэц бүхий үндэсний төвтэй болох.

2002 оны .9-р сарын 16

## **ГУРАВ. ДАЯН ДЭЛХИЙН БОЛОН МОНГОЛ УЛСЫН ТУЛХТАЙ ХӨГЖЛИЙН ТАЛААР ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЭЛД ӨГСӨН ЯРИЛЦЛАГА**

### **1. "ТУЛХТАЙ" ХӨГЖИЛ БА МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ**

ТХҮХ-ийн талаар Монгол Улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга тус хөтөлбөрийн үндэсний зохицуулалгч доктор профессор Д. Дагвадоржтой ярилцсан юм.

**- "XXI зууны тогтвортой хөгжил" чухам юу бэ ? Социализмын үед байгаагүй шинэхэн ойлголт уу ?**

- 1992 онд Рио де Жанейро хотноо "Хөгжил ба орчин" сэдвээр хуралдсан НҮБ-ийн чуулганаас дэлхийн хөгжлийн чиг хандлага, нийт үндэстэн бүрийн хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон "Байгаль, эдийн засаг, нийгмийн асуудлыг хослуулан хөгжүүлэх даян дэлхийн хэмжээний асуудал юм. Дэлхийн улс орнуудад XXI зуунд хэрхэн хөгжих вэ ?" гэдэг гэдэг талаас шинэ төсөөлөл уур амьсгалаар боловсрогдсон стратегийн асуудал гэж ойлгож болно. Социализмын үед ийм байгууллага байж үйл ажиллагаа явуулж байгаагүй. Шинэхэн ойлголт, энгийн үгээр хэлбэл: Дэлхийн улс орнууд хөгжихдөө нийгэм, экологийн талаа орхигдуулж иосэн. Үүнээс болж байгаль, экологийн хор хохирол нь удаан хугацаанд нөхөгдөж, заримдаа эс нөхөгдөж, хөгжлийн хурдаар олсон үр ашгаасаа илүү эрсдэл хохирол нь давамгайлж ирсэн. Ийм ч учраас "Байгаль орчин, хөгжил" гэдэг асуудал тавигдаж бид энэ хөтөлбөрт татагдаж орсон. Удирдах төв нь НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн комисс юм. Манай улс 2002 онд энэ комиссын гишүүн болсон.

**- XXI зууны тогтвортой хөгжлийн үйл ажиллагаанд Монгол Улс аль хэр хүртээлтэй оролцож байна даа?**

- Монгол Улс энэ хөтөлбөрт татагдан орсноос хойш шинэ зууны босгон дээр тогтвортой хөгжлийн гол тулгуур болох эдийн засаг, нийгэм, байгаль орчны нягт шүтэлцээг ойлгон ухамсарлаж, түүнд тохиолдох нийтлэг шинжтэй саад бэрхшээлийг даван туулах асуудлаар НҮБ-ын байгууллагаас зохион байгуулж байгаа бүх үйл ажиллагаа, хурал, семинарт оролцдог. Монгол улс тогтвортой хөгжлийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллага тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийг Ерөнхий сайдаараа толгойлуулан байгуулсан цөөн орны нэг. 1996 оноос эхлэн Монгол Улсын 21-р зууны тогтвортой хөгжлийн үндэсний хэмжээний хөтөлбөр, аймаг, хотуудад хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэхэд НҮБ-ийн Хөгжлийн хөтөлбөр, Чадавхи-21 сан үнэлж баршгүй дэмжлэг үзүүлж байгааг онцлон дурдахад таатай байна. Бид энэ он гэхэд Нью-Йорк хотноо болсон Даян дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтын хоёр удаагийн бэлтгэл чуулган, мөн Индонези улсын Бали хотод болсон дөрөв дэх удаагийн чуулганд оролцсон. Илтгэл тавин санал бодлоо илэрхийлж байдлаа танилцуулж, дуу хоолойгоо хүргэж байв. Одоо наймдугаар сарын сүүлээр Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад дэлхийн улс орнуудын төр засгийн тэргүүн нар оролцсон дээд хэмжээний чуулган болох бөгөөд үүнд манай ерөнхийлөгч оролцоно.

**- Тогтвортой хөгжлийн стратегийн онцлог нь юу бэ ? Социализмын үед ч тийм төлөвлөгөө стратеги байсан шүү дээ?**

- Социалист системийн орнуудын интеграцын хүрээнд Монгол Улсын хөгжлийн алс хэтийн төлөвлөгөө зохиож байсан. Гэхдээ амьдралаас төдийлөн ургаагүй гол төлөв дээрээс, гаднаас зохиож байсан учир амьдралд даацтай хэрэгжээгүй байсан. Одоогийн бидний төсөл байгаль, нийгэм, эдийн засагийн хүрээг хамран суурь, баг, сум, аймгаас төслөө боловсруулж төвөөс мэргэжлийн удирдлага, зөвлөгөө өгч хэрэгжүүлж байгаагаараа онцлог юм. Дэлхийн хамтын нийгэмлэгийн зарчмаар бол

Чадавхи -21 сангийн хүмүүс доороосоо дээшээ явах зарчмыг тогтвортой хөгжлийн үндсэн арга гэж үздэг юм билээ. Тогтвортой хөгжил бол цогц ухагдахуун юм. Монголчууд "тулхтай эр хүн" гэж ярьдаг даа, түүн лугаа бидний ярьж буй хөгжлийг тулхтай хөгжил гэж ойлговол үнэнд илүү ойр байна. Учир нь аль нэг бус нутаг юм уу салбар, зөвхөн нийслэл Улаанбаатар хот, аймгийн төв гэж явцуурахгүйгээр хүний амжиргааны олон хэмжээсийг тухайлбал нийгэм, эдийн засаг, экологи, улс төр, соёл сэтгэл зүйн асуудлыг хамардаг. Аль нэг асуудлыг нөгөөхөөс нь давуу илүүгээр авч үздэггүй . Эдгээр хэмжээ бие биедээ харилцан нөлөө үзүүлэхээс гадна, нийлээд цогц байдлаар хүмүүсийн амжиргааны чанарыг тодорхойлно.

**- Тогтвортой хөгжилд байгаль, экологийн асуудал шийдвэрлэх үүрэгтэй юмаа даа ?**

- НҮБ-ийн ерөнхий нарийн бичгийн дарга Кофи Анан "Паспортгүй орон зай гэж " гэж нэг тодорхойлолт хэлсэн байдаг. Үйлдвэрлэл эдийн засгийн гаж буруу үйл ажиллагаа, бодлогоос үндэслэн улсын хил хязгаарт захирагдахгүйгээр дайн самуун, гал түймэр, мансууруулах бодис, хар тамхи, мафийн сүлжээ мэт аюулт зүйл байгаль экологид муугаар нөлөөлдөг. Монголчууд олон зууны туршид хүн, байгаль, аж ахуйн шүтэлцээт байдлыг эрхэмлэж, түүнд зохицсон нүүдлийн хэмээх өвөрмөц аж ахуй, соёл иргэншлийг бүтээж хөгжүүлж ирсэн. Монгол Улсын шинэ үндсэн хууль өөрийн орны өвөрмөц байдлыг дэлхийн хөгжлийн түгээмэл хандлагатай зохистой хослуулж, энэ үндсэн дээр хүн амаа эрүүл, аюулгүй хангалуун амьдрах нөхцлийг хангах эрхийг баталгаажуулсан билээ. Түүнчлэн энэ нь Монгол Улс, ардчилал, зах зээлийн шинэ харилцаанд шилжсэн үеэс XXI зууны тогтвортой хөгжлийн түгээмэл чиг хандлагыг тодорхой хэмжээгээр тусгасан хөгжлийн баримтлалууд боловсруулсан. Тухайлбал УИХ-аар 1994 онд баталсан Монгол Улсын үндэснийн аюулгүй байдлын үзэл баримтлал, 1996 онд баталсан Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг дурьдаж болно. Тогтвортой хөгжлийн үндэснийн хөтөлбөрийг 1998 онд засгийн газрын хуралдаанаар сайшаан баталсан юм. Одоо даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн төрөөс баримтлах бодлогын үндсийг боловсруулж, УИХ- аар батлуулах зорилготой ажиллаж байна. Энэ бүхний дагуу байгаль орчны таагүй өөрчлөлтийн гол хандлага, цөлжилт, элсний нүүдэл, ой, ус, бэлчээрийн нөөцийн хомсдолтой тэмцэх, улс орныхоо хөгжлийг дэлхийн уур амьсгалын ерөнхий өөрчлөлтийн хандлагад дасан зохицох чадвартай болгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах болно.

- **Тулхтай хөгжлийн асуудлаар болсон олон улсын хурал чуулганд оролцсон байдлаасаа ярихгүй юу?**

- Индонезийн аялал жуучлалын тусгай бүс нутаг Балид өнгөрсөн V сард болсон бэлтгэл чуулганд оролцож их юм дуулж мэдсэнээ дурьдахад таатай байна. НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрийнхөн, Чадавхи-21 сан Монголыг их анхаардаг, дэмждэг нь эхнээсээ анзаарагдсан. Манай байгууллагын үйл ажиллагаа юунд чиглэх вэ? гэвэл Даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйл явцын дунд Монгол Улсыг зохих байр суурь эзлүүлэх, Монголын байдлыг тэдэнд мэдүүлж, дуу хоолоогоо хүргэж байх явдал олон талын хэлхээ холбоо тогтооход чухал ач холбогдолтой. Өнгөрсөн дөрвөн удаагийн чуулганд Монголын төлөөлөгчид нилээд ажил хэрэгч оролцсон гэж үздэг. Тулхтай хөгжлийн хөтөлбөрт хамрагдаад байгаа 130 гаруй орны төлөөлөгчид Төв Азийн цэвэр усны хагалбар дээр байгаа Монголын өргөн уудам газар нутаг, унаган байгаль, цэвэр ус, цэнгэг агаар, ан амьтан, нүүдлийн соёл иргэншил зэргийг их сонирхдог. Ер нь Монгол Улсын тулхтай хөгжлийн хөтөлбөрийг зөв дэмжин хөгжүүлж чадвал энэ нь хөгжиж байгаа орнуудад сайн загвар туршлага болно гэж үздэг юм билээ. Монгол Улсын тогтвортой хөгжлийн удирдлагын зохион байгуулалт үндэсний хэмжээнд болон аймаг, орон нутгийн хэмжээнд их оновчтой болсон гэж гадаад орнууд үздэг. Жишээлбэл: Улс төрийн сонгуулийн дүнд гарч ирсэн аймаг, хотын засаг дарга гэхэд тухайн орон нутгийг хөгжүүлэх хөтөлбөрөө боловсруулахдаа энэ тэргүүнд тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг иш үндэс болгодог. Энэ утгаараа амьдралд хэрэгжиж байна гэсэн үг. Мөн хөтөлбөрийг боловсруулах хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн ба төрийн бус байгууллага, нийгмийн бүх бүлгүүд оролцсон болохоор монголчууд хамтран ажиллаж олон талын түншлэл бүрдүүлэх талаар өнгөрсөн он жилүүдэд зохих туршлага хуримтлуулсан билээ.

- **Тогтвортой хөгжилд боловсрол чухал үүрэгтэй биз?**

- Хүмүүсийн боловсролын түвшингээс шалтгаалан тухайн улсын хөгжлийн түвшин тодорхойлогддог. Боловсролын түвшин доогуур улс орнуудад эрчим хүч, хэрэглээний бараагаа гадаадаас авдаг. Боловсрол нь ХАА-н бүтээмж дээшлэх, эмэгтэйчүүдийн аж байдал сайжрах, хүн амын хэт өсөлтийг багасгах, байгаль орчны хамгаалалыг сайжруулах зэргээр улс орны хөгжилд нөлөөлдөг. Тогтвортой хөгжлийн боловсролыг 3 үндсэн чиглэлээр хэрэгжүүлнэ гэж үздэг.

I. Ерөнхий боловсролыг сайжруулах

II. Одоо мөрдөгдөж байгаа боловсролын системийг тогтвортой хөгжлийн асуудалтай уялдуулах

III. Олон нийтийн мэдээллийг дээшлүүлэх, зайны сургалт явуулах чиглэлүүд орно.

- **Одоо бидний хийх ажил гол нь юунд чиглэгдэх бол? ямар бэрхшээл тохиолдож байна. Сэтгэл эмзэглүүлэх зүйл байна уу?**

- Тулхтай хөгжлийн асуудалд олон талын оролцоо, түншлэл, тусалцаа их рольтой. Одоо манайд төр, иргэнийн нийгэм, бизнесийн хүрээнийхний хамтын ажиллагаа дутагдаж байна. Хийх ажил их, явах зам хол байна. Унаган байгаль, хөрс шороо газрын баялаг, хүн амьтнаа яаж хойч үедээ хэвээр нь үлдээх вэ? гэдэг асуудал тулгамдсан зүйл болж байна. Жижиг газар нутагтай улс орнууд газраа, ургамал усаа, байгалийн баялгаа маш их хайрладаг хамгаалдаг юм байна. Бид газар нутаг баялгаа амьдралын их булаг, манай мөнхийн өмч гэдэг үүднээс хандаж, бүх хүрээнд ажиллах цаг болжээ. Хангай дэлхийгээ, уул усаа, мод ургамлаа, ан амьтнаа хайрлан хамгаалж, өсгөж үржүүлж ирсэн Монголчуудын уламжлал, зан үйлийг авч үлдэх ажлыг улс даяар өрнүүлэх хэрэгтэй болжээ. Техникийн өрсөлдөөн, хэт шохоорхол байгаль орчинд муугаар нөлөөлж байгааг олон хүмүүс ярьдаг. Одоо УИХ-аар яригдаж байгаа "Газар өмчлөх" хуулийг маш нухацтай хэлэлцэж маш зөв шийдэл гаргах ёстой. Энэ бол бид бүхний сэтгэл эмзэглүүлсэн зүйл. Энд ямар нэг нам эвсэл, улс төрийн хүчнүүд талцах, хөгшин залуу эрдэм боловсрол, салбар аж ахуйн чиглэлээр явцуурч болохгүй.

Өөр нэг анзаарах зүйл бол Азийн онцлогтой хөгжлийн нууц нь төр засаг, бизнес, иргэний нийгэмийнхэн бие биентэйгээ өрсөлдөхгүйгээр зөвхөн хөгжил, боловсрол, сайн сайхан амьдралын төлөө бодлогын бүх үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхэд хүн бүхэн чин сэтгэлээрээ тэмцдэгт оршдог билээ. Үүнийг би өгшөрсөн жил Солонгос улсын Сөүлийн Их сургуульд ажиллаж байхдаа хийсэн харьцуулсан судалгаанаасаа мэдсэн. Бид ингэж ажилламаар байна.

Аялал жуучлал бол Монголын эдийн засагт нөлөөлөх ирээдүйтэй салбар билээ. Азийн орнууд энэ чиглэлээр хөгжиж байна. Манайд ч тийм болож бий. Тэгэхдээ ахуй хангамж, соёл, үйлчилгээ гэдэг гайхалтай сайн байдаг аж. Би Балигаас нисэхдээ тэр ард түмнийн тухай "Хаашаа ч харсан цацартал инээсэн Баличууд, халуун дулаан сэтгэлээр тосон үйлчилсэн Баличууд" гэж тэмдэглэлийн дэвтэртээ бичиж байлаа.

Ярилцсан Ц. Навагчамба /Өдрийн сонин. 2002 оны 6 дугаар сарын 29. Дугаар 159/

## **2.МОНГОЛ УЛС АЗИ ТИВД ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫГ ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА ГЭДГИЙГ ЧУУЛГАНЫ ДАРГА ОНЦЛОН ТЭМДЭГЛЭСЭН**

Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, XXI зуун тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн үндэсний зохицуулагч доктор Д. Дагвадорж саяхан Нью-Йорк хотноо болсон "Даян дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээнийн уулзалтын бэлтгэл хорооны гурав дахь удаагийн бэлтгэл чуулганд оролцоод иржээ. Уг чуулган 2002 оны 3-р сарын 25-наас 4 сарын 5-ны өдрүүдэд НҮБ-ын хурлуудын танхимд болсон байна. Чуулганд НҮБ-ийн гишүүн бүх орны засгийн газрыг төлөөлсөн ажилтан, тогтвортой хөгжлийн

мэргэжилтнүүд оролцжээ. Монгол улсаас НҮБ-д суугаа байнгын төлөөлөгч, элчин сайд Ж. Энхсайхан, НҮБ- д суугаа байнгын төлөөлөгчийн газрын нарийн бичгийн дарга Д. Зоригт, Т.Энэбиш нар мөн оролцжээ. Ингээд бид уг чуулганы талаар ярилцсан юм.

**- Өмнөх чуулганд та илтгэл тавьж хэлэлцүүлсэн гэсэн. Энэ удаагийн чуулганы онцлог юу байна?**

- Энэ удаагийн чуулганы хэлэлцсэн асуудлын чиглэл, зохион байгуулалт, арга зүй өмнө нь болсон хоёр дахь удаагийн чуулганахаас өвөрмөц ялгаатай байсан юм. Өмнөд Африкд болох дээд хэмжээний уулзалтаар хэлэлцэн гаргах шийдвэрийн талаарх чуулганы даргын баримт бичгийг ажлын гурван бүлэг болгон хоёр долоо хоногийн турш хэлэлцэв. Чуулганы төлөөлөгчид асуудал бүрт нухацтай хандаж, тогтвортой хөгжлийн үйлсийг хоосон уриа лоозон болгох биш, бодит ажил хэрэг болгох талаас нь хандаж байлаа. Ажлын группуудад манай улсын төлөөлөгчид сонирхсон чиглэлүүдээрээ орлцож ажиллав. Чуулган ажил хэрэгч бөгөөд цаг хугацааг нарийн тооцсон шийдвэр гаргаж, улмаар бодит түншлэлд буюу гарц-2-т хүрэх талаар дэвшилд хүрснээрээ ихээхэн ач холбогдолтой боллоо.

**- Монгол улс G-77гэгдэх хөгжиж буй орнуудын бүлэгт хамаарагддаг гэсэн. Уг бүлгийн хуралдаан ямар асуудлыг онцлон хэлэлцэв?**

- Бид ажлын группуудын хуралдаан, хуралдааны чөлөөт цагаар тусгай арга хэмжээнд идвэхтэй оролцож, даян дэлхийн тогтвортой хөгжилд Монгол улсын баримтлаж буй чиг бодлогын талаар байр сууриа илэрхийлж байв. Төлөөлөгчдийн тэргүүн Ж. Энхсайхан G-77-ийн бүлгийн хуралдаанд далайд гарцгүй орнуудын тогтвортой хөгжлийн талаар үг хэлж, эцсийн баримт бичигт энэ орнуудын эрх ашгийг тусгахыг онцлон дурьдсан бол минийн бие "Үндэсний засаглал ба тогтвортой хөгжил" сэдэвт олон улсын дугуй ширээний ярилцлагад оролцож Азийн бүс нутаг, түүнийн дотор Монгол улсыг тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэгч гол орнууд болох АНУ болон хөгжингүй орны ижил төрлийн байгууллагуудтай холбох боломжийн талаар үг хэлж, санал бодлоо солилцов. Энэхүү дугуй ширээний ярилцлагад оролцсоноор "Access Initiative" гэж нэрлэгддэг даян дэлхийн холбоотой Монголын ТХҮЗ хамтран ажиллах шинэ боломж нээгдэж байна. Мөн даян дэлхийг хамгаалах зөвлөл (The world Conservation Union) зэрэг байгууллагууд Монгол улсын тогтвортой хөгжлийн албатай хамтран ажиллахаа илэрхийлсэн.

**- Өөр ямар арга хэмжээнүүд болсон бэ?**

- 4 сарын 1-ний өдөр тогтвортой хөгжлийн даян дэлхийн зөвлөлөөс зохион байгуулсан "Тогтвортой хөгжилд оролцогчдын оролцоог өргөжүүлэн гүнзгийрүүлэх нь" сэдэвт арга хэмжээнд би "ТХҮЗ- аар дамжуулан Монгол улс дахь тогтвортой хөгжлийг удирдаж байгаа нь" сэдэвт илтгэл тавин хэлэлцүүлсэн. Оролцогчид Монголын хөдөө нутаг дахь тогтвортой хөгжлийн удирдлагын асуудлыг онцгойлон асууж танилцаж байсан.

**- Монгол улсын тогтвортой хөгжлийн талаар явуулж буй бодлого үйл ажиллагааг бусад орнуудтай харьцуулахад ямар түвшинд байна вэ?**

Монгол улс "Ази тивд тогтвортой хөгжлийн үйлсийн удирдлагыг хамгийн оновчтой зохион байгуулан хэрэгжүүлж, бусад орнуудад туршлага болохуйц араг туршлагыг хуримтлуулжээ" гэдгийг хурал даргалагч онцлон тэмдэглэв. Энэ тухай хурлын дараагийн өдөр хэвлэгдсэн бюллетеньд Монголын тогтвортой хөгжлийн "мэдэгдэхүйц" туршлагын талаар ярив хэмээн онцлон тэмдэглэж илтгэгчийн зурагтайгаар хэвлэсэн байлаа. Мөн интернэтийн <http://www.iisd.ca/linkages/2002/pc3/endbots/> гэсэн вэб-сайтад тусгаж нийтийн хүртээл болгосон юм. Хуралд оролцох явцдаа Монгол улсын тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг өргөжүүлэх талаар дэлхийн улс орон, байгууллагуудын мэрэгжилтнүүдтэй шууд уулзан ярилцаж, заримтай нь интренэтээр харилцан санал солилцож байлаа.

**- Та уг бэлтгэл чуулганаас олз омог дүүрэн иржээ. Чуулганы ач холбогдолыг товч дүгнэн хэлбэл?**

- Гурав дахь удаагийн бэлтгэл чуулган, Өмнөд Африкд болох дээд хэмжээний уулзалтаар хэлэлцэх асуудлыг бүлэг зүйл бүрээр нь нарийвчлан хэлэлцэж тодорхой ахиц гарган тавдугаар сарын сүүлчээр Индонези улсын Балид болох 4 дэхь удаагийн уулзалтаар хэлэлцэх асуудлаа нарийвчилж чадсан илүү практик үр дүнтэй чуулган боллоо. Энэ чуулганы хоёр дахь том гарц болох хоёр болон олон талын түншлэлийн хүрээг өргөжүүлж, даян дэлхийн тогтвортой хөгжлийн үйлсийг хамтран хэрэгжүүлэхэд улс орнууд, олон улсын байгууллагууд, олон талт оролцогчид бие биеэ илүү таньж мэдэн шууд хамтран ажиллах талаар алхам хийж чадсан түншлэлийг өргөжүүлэх олон улсын томоохон арга хэмжээ боллоо. Уг чуулганд Монгол улсын төлөөлөгчид практик өгөөжтэй оролцож, улс орноо даян дэлхийд таниулах талаар бодитой зүйл хийсний зэрэгцээ Монгол улс дахь тогтвортой хөгжлийг санхүүгийн болон зохион байгуулалт, арга зүйн талаар дэмжиж ажиллах түншүүдтэйгээ ойртон нөхөрлөсөн нэн ашигтай мөчүүд болж өнгөрсөн юм.

Ярилцлага хийсэн: Д.Батжаргал /Нийслэлийн сонин бичиг. 2002 оны ... дугаар сарын ... Дугаар .../

### **3. ЛИДЕР ЭДИЙН ЗАСАГЧ БАЙЯ ГЭВЭЛ БАЙГАЛЬ, НИЙГМЭЭ СУДАЛ**

**Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, XXI зууны тогтвортой хөгжил хөтөлбөрийн үндэсний зохицуулагч, доктор, профессор Д. Дагвадоржоос тогтвортой хөгжил гэж юу болох талаар тодрууллаа.**

- Тогтвортой хөгжил гэдэг ойлголт нь байгаль орчноо хамгаалах, эдийн засгийн өсөлтийг хангах, нийгмийн хамгааллын гэсэн гурван гол асуудлын цогц хэрэгжилтийн тухай юм. Өөрчлөгдөн байгаа дэлхий ертөнцөд хувь хүн, улс орон хэрхэн ухаалаг амьдрах вэ гэдэг үзэл баримтлал, үйл ажиллагааг агуулсан, нэг ёсны даян дэлхийн хөдөлгөөн нь тогтвортой хөгжил юм. Үүнийг би хувьдаа сүүлийн үед тулхтай хөгжил гэж ярьдаг болоод байгаа. Яагаад гэвэл хөгжлийн тухай баримтлалуудын суурийг энэ ойлголт агуулж байна.

**- Дэлхийн хөдөлгөөн гэдгийн учир нь?**



- Ирэх наймдугаар сарын сүүлчээр ӨАБНУ-д тулхтай хөгжлийн асуудлаар дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт болно. Ойрын 10-20 жилийн тулхтай хөгжлийн стратеги бодлогыг тодорхойлох болно.

### **Манай улс дахь тулхтай хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт зохион байгуулалтыг хэр зэрэг гэж үнэлдэг бол?**

Азийн орнуудад ялангуяа хөтөлбөрийн хэрэгжилтээр манайх сайн гэж үнэлэгддэг. Манай Үндэсний зөвлөлийн бүтцийг нилээд оновчтой гэж үздэг. Улсын хэмжээнд Ерөнхий сайд, аймгуудад Засаг дарга нар толгойлдог.

#### **- Энэ чиглэлээр ажиллахад юуг анхаарах вэ?**

- Эрдэмтэд хамтын хүчээр судлах, эрдэмтдийн ололт бүтээлийг тулхтай хөгжлийн чиглэлд ашиглах шаардлагатай. Байгальд хоргүй технологи боловсруулах. Тухайлбал, фосфоритыг. Хэрэв ирээдүйгээ харсан эдийн засагч байя гэвэл байгаль, нийгэмтэй уялдаа холбоотой судалгааны ажил хийх хэрэгтэй. Бизнес менежментийн тухайд байгальд болон хүн ардад хоргүй үйлдвэрлэл, бизнес эрхлэх нь зүйтэй. Цэвэр усаа дэлхийн зах зээлд үр ашигтай экспортлох асуудал чухал болоод байна. Экологийн цэвэр бүтээгдэхүүнийг хэнээс ч илүү үйлдвэрлэх угийн бололцоотой орон бол манайх.

#### **- Тогтвортой хөгжлийн ирээдүйтэй холбогдсон эмзэг гэмээр зүйлээс тодруулахгүй юу?**

Үйлдвэрлэл, хэрэглээний зохистой байдлыг хангах. 2000 оны байдлаар дэлхийн хүн ам зургаан тэрбум болсон. 2025 онд найман тэрбумд хүрнэ. Өндөр орлоготой орнуудад дэлхийн хүн амын 15 хувь амьдарч, нийт хэрэглээний 56 хувийг эзэлдэг. Гэтэл хүн амын 40 хувийг эзэлдэг ядуу орнуудад нийт хэрэглээний арван нэгэн хувь нь ногддог. Хөгжиж байгаа зарим орны иргэд өдөрт нэг ам. доллараас хэтрэхгүй хэрэглээтэй байна. Дэлхий дээр 1.1 тэрбум хүн цэвэр ус хүртэх бололцоогүй байна. Хоёр тэрбум гаруй хүн сайн цэвэрлээгүй ус уудаг. 2025 он гэхэд дэлхийн хүн амын гуравны хоёр хувь нь цэвэр усны гачаалд өртөх тооцоо бий. Тэгвэл бид усаа ядахдаа цэвэр байлгаад байгууштай. Өнгөрсөн зуунд нефтийг "хар алт" гэдэг байсан шиг XXI зуунд ус "цэнхэр алт" хэмээгдэх болоод байна. Энэ бүхэн нь тогтвортой хөгжилтэй амин чухал холбоотой.

/Нийслэлийн сонин бичиг. 2002 оны 4 дүээр сар. Дугаар04/

## **4.ЦЭРЭГ ДАЙНЫ ЗАРДЛАА БАГАСГАЖ, БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛАХАД ЗОРИУЛАХ ТУХАЙ ЯРИЛЦЛАА**

Монгол улсын XXI зууны тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн үндэсний зохицуулагч, ТХҮЗ -ийн нарийн бичгийн дарга Д. Дагвадорж Нью-Йорк хотноо хуралдсан НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн комиссын дэргэдэх Бэлтгэл хорооны чуулганд оролцоод иржээ. Түүнтэй ярилцлаа.

**- Тогтвортой хөгжилийн бэлтгэл хороо гэдэг ямар үйл ажиллагаа явуулдаг байгууллага вэ?**

Энэ оны наймдугаар сард ӨАБНУ- д Даян дэлхийн тогтвортой хөгжилийн асуудлаар дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалт болно. Энэ уулзалт улс төрийн амлалт, түншлэлд үндэслэн, бодит шинэ санаачилгаар дамжуулан тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны хэрэгжилтийг тодорхойлоход гол анхаарлаа хандуулах юм. Миний оролцоод ирсэн чуулган дээд хэмжээний чуулганы бэлтгэл ажлын явцыг хэлэлцэх асуудлаар ярилцлаа. НҮБ-ийн Тогтвортой хөгжлийн комисс гэж байдаг. Тэр комиссоос наймдугаар сарын дээд хэмжээний уулзалтын бэлтгэлийг хангуулах зорилгоор энэ хороог байгуулсан юм билээ.

**- Энэ чуулганд манай улс ямар үүрэгтэй оролцов. Ер нь НҮБ-ийн тогтвортой хөгжлийн комисст манайх ямар байр суурьтай байдаг юм бол.**

- Нэг баярлууштай нь манай улс оны эхээр НҮБ-ийн энэ комиссын бүрэн эрхт гишүүн 50 гаруй орны нэг болсон явдал. Ингэснээр манай оронд тогтвортой хөгжилийг өрнүүлэхэд гадаад талдаа маш таатай нөхцөл бүрдэж байгаа юм. Энэ чуулганд тухайн улс орнуудын Засгийн газрын төдийгүй, эмэгтэйчүүд, залуучууд, эрдэм шинжилгээ, бизнесийн байгууллага, бүр цөөнхийн төлөөлөгчид ч оролцлоо. Монгол Улсаас НҮБ-д суугаа Байнгын төлөөлөгч Ж. Энхсайхан бид хоёр оролцсон л доо. Би үг хэлж, цөлжилт, ойжуулалт, цэвэр усны нөөцийн талаар Монгол Улс дэлхийн улс орнуудтай нэгдсэн байр суурьтай байгааг илэрхийлсэн.

**- Манай улсын XXI зууны тогтвортой хөгжлийн Хөтөлбөрийг ер нь гайгүй болсон гэж дэлхий нийт үнэлдэг тухай сонсож байсан.**

- Манай улс Азийн орнуудаас анх үндэсний илтгэлээ бэлтгэж Даян дэлхийн зөвлөлийн Азийн бүсийн зөвлөлийн чуулганд тавьж хэлэлцүүлсэн юм. Энэ илтгэл НҮБ-ын веб сайтад орсон байгаа. Азийн олон орон манай хөтөлбөрийг сонирхож судалж байна. Хөтөлбөр маань ч сайн болсон гэж сайшаагдсан. Хятад улс л гэхэд одоо үндэсний илтгэлээ бэлтгэж байгаа. Тэдний хөтөлбөр, зохион байгуулалт нь маш тодорхой хийгдэж байгаа юм билээ. Манай Үндэсний зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлдэг маань тогтвортой хөгжлийн асуудлын ач холбогдлыг улам дээшлүүлж байдаг. Монгол улсын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн туршлагыг НҮБ болон донор орнууд дэмжих байр суурь барьдаг.

**- Ямар туршлагыг тэр вэ?**

- Манай улсын онцлог нь хот, аймаг бүр тогтвортой хөгжлийн хөтөлбөртэй. Мөн бүсүүд ч хөтөлбөртэй болох эхлэл тавигдлаа. Зүүн бүс гэхэд өөрийн хөтөлбөртэй болж байна. Манай энэ өвөрмөц зохион байгуулалтыг дэмжих, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын комисс дэмжих байр суурьтай төдийгүй бусад оронд ингэж зохион байгуулах тухай ч яригдаж байдаг. Гэвч бидэнд хөтөлбөрөө, асуудал бүрийг тодорхой болгох. Дотооддоо хэрэгжүүлэх, олон нийтэд хүргэхэд илүү анхаарах гэхчилэн эрчимтэй ажиллах шаардлага бий.

**- Бусад улс орнуудаас суралцах юм их байгаа даа.**

- Тэгэлгүй яахав. НҮБ-ын хуралдааны танхимд хэдэн өдөр чуулсан төлөөлөгчид даян дэлхийн тогтвортой хөгжилд ямар хувь нэмэр оруулав, цаашид юу хийж чадах вэ гэдгээ шүүн ярилцлаа. Тэд бүгд л эх дэлхийгээ яаж цэвэр ариун байлгах вэ, одоо алдаад байгаа экологийн тэнцвэрийг яаж эргүүлж тогтворжуулах вэ гэдэг нэгдмэл санаатай байлаа. Өнөөдөр дэлхий нийтэд тогтвортой хөгжлийн боловсролын тогтолцоонд их анхаарч байгаа юм байна. Улс орнуудын төлөөлөгчид даян дэлхийн хөгжлийн асуудлаар удирдлагын хувьд ч, санхүүгийн болон бусад асуудлаар ч бие биеэ ойлгож хамтран ажиллая, цэрэг дайны зардлаа багасгаж, тэнд зарах хөрөнгийг байгаль орчноо хайрлан хамгаалахад зориулъя гэдэг асуудлаар санал нэгтэй нутаг нутгийн зүг жолоо заллаа. Дээд хэмжээний чуулга уулзалтаас өмнө НҮБ-ын тогтвортой хөгжлийн бэлтгэл хорооны чуулган дахин хоёр удаа чуулна.

/Өдрийн сонин. 2002 оны 2 дугаар сарын 28. /

## **5.ТУЛХТАЙ ХӨГЖИЛ ДАЯН ДЭЛХИЙН № 1 АСУУДАЛ**

Иоханнесбургийн Дэлхийн дээд хэмжээний уулзалтад оролцсон Монголын төлөөлөгч, Монгол улсын Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, XXI зууны тогтвортой хөгжил хөтөлбөрийн үндэсний зохицуулагч Профессор Д. Дагвадоржтой ярилцлага хийсэн юм.

### **Албархуу ярианаас зайлсхийж хурлын ерөнхий дүр төрхөөс яриагаа эхлэх үү ?**

ӨАБНУ бол маш баян тансаг, дэлхийн хүмүүсийн чихийг дэлдийлгэх асар сонин орон. Дэлхийн хэмжээний алтны 53 %-ийг олборлодог гээд л бод ! 40 сая хүнтэй, хүчирхэг эдийн засагтай, аялал жуучлал их хөгжсөн, том орон. Биднийг очиход хавар эхэлж байсан.

Тус хуралд 200 гаад орны 40,000 төлөөлөгч, 109 орны төр засгийн тэргүүн нар оролцлоо. Хурлын уур амьсгал маш ажил хэрэгч, илэн далангүй, хурал, уулзалт зөвлөлөгөөн маань хэд хэдэн томоохон хотхон шиг газар болсон. Даян дэлхийн тулхтай хөгжлийн их чуулганд Монголын төлөөлөгчид (20-оод хүнтэй ) бүрэн бүрэлдхүүнээр оролцлоо. Дээд хэмжээний уулзалт 8 дугаар сарын 26-наас долоо хоног болж, их чуулган 9 дүгээр сарын 2-ноос 4 -нд болж өндөрлөлөө.

### **Энэ чуулганы бэлтгэл ажил гэж нүсэр юм байсан биз ?**

Өмнөх их чуулган арван жилийн тэртээ Рио Де Жанейро хотноо болж тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, түүнд хүрэх арга замыг тодорхойлсон. Тэгвэл Иоханнесбургийн уулзалт нь тогтвортой хөгжлийн жинхэнэ бодит үйл ажиллагаа, хэрэгжилтэнд чиглэсэн тодорхой алхам болсон юм. Уулзалтын бэлтгэл гурван удаагын чуулганд би оролцсон учраас хийж амжуулсан үйлс нь илүү тодохой байгаа юм. Ингэснээр Их чуулганы ерөнхий цар хүрээ алсын зорилтыг мэдэх бололцоо, завшаан надад тохиолдлоо гэж боддог. Энэхүү дээд хэмжээний чуулга уулзалт нь дэлхий нийтээрээ тогтвортой ирээдүйд хүрэх, нөгөөтэйгүүр хүн төрөлхтөн хүрээлэн байгаа орчиндоо хор хөнөөл учруулахгүйгээр өөрийн хэрэгцээг хангах боломжийг олгох юм.

Иоханнесбургийн уулзалт нь тогтвортой хөгжлийн чиглэлээр болж буй дэлхийн хамгийн том олон улсын арга хэмжээ болох бөгөөд энд олон орны улзагчдаас гадна бизнесийн манлайлагчид, иргэний нийгмийн төлөөлөгчид оролцож дуу хоолойгоо нэгтгэлээ.

### **Дэлхийн дээд хэмжээний уулзалтыг хаанаас яаж зохион байгуулсан бэ?**

НҮБ-ийн тогтвортой хөгжлийн хороо Дэлхийн дээд хэмжээний чуулганыг зохион байгуулах ажлыг ерөнхийд нь удирдан гүйцэтгэсэн.

### **Нээлтийн ажиллагаа их өвөрмөц болсон гэл үү?**

Тийм ээ. Дэлхийн 100 гаруй орны төр засгийн тэргүүнүүд оролцсон дээд хэмжээний уулзалтын нээлт маш өвөрмөц болсон.

Тайзан дээр дэлхийн бөмбөрцөгийг тавьж дээр нь хүний гавлын яс гарч, дэлхий дээр болсон байгалийн гамшиг, өлсгөлөн, ДОХ- оор өвдсөн хүүхэд, дэлбэрэлт зэрэг зургуудыг үзүүлсэн. Бөмбөрцөг дээрхи хүний гавлын яс унахад 500 бөмбөрчин, бүжигчин, дуучид гарч ирж дуулж, бөмбөрдсөн. ӨАБНУ- ын ерөнхийлөгч Т. Мбекин хэлсэн үгэнд нэг анхаарал татсан зүйл бол: " . . . Бид өлсгөлөн, тэгш бус байдал, экологийн бохирдолтод автсан дэлхийд амьдрасаар байна. Ядуучууд улам бүр хэцүүдсээр байхад цөөхөн тооны баячууд улам бүр баяжсаар байна" гэж онцлон тэмдэглэсэн.

### **Монгол Улсын хувьд ямар үүрэг рольтой оролцов даа?**

1. Монгол Улсын хувьд гол гол асуудалд оролцсон. Улсын ерөнхийлөгч, Их хурлын гишүүд, Байгаль орчны сайд энэ чуулганд оролцоноороо Монгол улс Даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг бүрэн дэмжиж өөрийн гэсэн хувь нэмрээ оруулах эрмэлзэлтэй байна гэдгээ харуулсан томоохон үйлс болсон гэж үзэж болно. Дээд хэмжээний чуулга уулзалтын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон улс төрийн тунхаглал батлан гаргахад манай төлөөлөгчид биечлэн оролцлоо. Дэлхийн улс орнуудын Парламентийн төвшний тулхтай хөгжлийн чуулганд Монгол Улсын их хурлын гишүүн Шийрэвдамба, Сандалхаан нар оролцсон юм. Миний хувьд бол тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлүүдийн сүлжээ үүсгэх олон талт арга хэмжээнд оролцсон. Тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлүүдээс зохион байгуулж байгаа үйл ажиллагааг гурван хэсэг болгон үзэж болно. Үүнд: Нэгдүгээрт. Азийн орнууд дэлхийн бусад тивийн орнуудтай харьцуулхад тогтвортой хөгжлийг удирдах талаар илүү зохион байгуулалтанд орсон нь харагдаж байсан. Японы ерөнхий сайд асан Хашимотогийн даргалдаг "Ази номхон далайн орнуудын орчин ба хөгжлийн форум" гэж байдаг. Эндээс мэдлэгийн сүлжээ ба чадавхийг бий болгох хамтын ажиллагааны санаачлага гэсэн нээлттэй арга хэмжээ зохион байгуулсан. Энэ форумын удирдах зөвлөлийн гишүүнээр манай ерөнхий сайд Н. Энхбаяр ажилладаг.

Энэ хуралдаанаас усны нөөц, сэргээгдэх эрчим хүч, худалдаа санхүү, сайн засаглал, хотжилт хөдөөгийн хөгжил гэсэн асуудлуудын талаар дээд хэмжээнийн чуулганы шийдвэрт тусгуулах тодорхой санал оруулсан.

2. Өөр нэгэн томоохон арга хэмжээ бол Даян дэлхийн зөвлөлөөс зохион байгуулсан дэлхийн улс орнуудын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлүүдийн хоорондын хамтын ажиллагааны сүлжээ бий болгох, хамтран ажиллах арга хэлбэрээ тогтоох асуудлыг 3 өдөр дараалал хэлэлцсэн хуралдаан байлаа. Энд 50 гаруй орны ТХҮЗ- гийн голлох мэргэжилтнүүд оролцсон. Хурлыг Даян дэлхийн зөвлөлийн ерөнхийлөгч Франс ван Харен өөрөө удирдаж явуулсан. Мөн түншлэлийн үйл ажиллагааны асуудал маш өргөн хүрээнд тавигдсан.

3. Ази тивийн орнуудын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлүүдийн 2 дахь удаагийн хуралдаан (анхных нь Сеүлд 2002 оны 7 сард болсон юм), Иоханнесбургт болсон бөгөөд дараагийн уулзалтыг 2003 оны зун Улаанбаатарт зохион байгуулжаар тохиролцсон. Энэ бол Монгол орны нэр хүнд өсөж, байр суурь нь бэхжиж байгааг харуулж буй хэрэг л дээ.

Мөн НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих асуудлаар тусгай арга хэмжээ зохион байгуулсан. Ер нь Даян дэлхийн тогтвортой хөгжлийн цаашдын чиглэл бол орон нутгаас үндэсний хэмжээнд, улмаар даян дэлхийд байгаль, эдийн засаг, нийгмийн асуудлыг цогцоор авч үзэж хөгжүүлэхэд оршиж байна.

Монголчууд олон зууны туршид хүн, байгаль, аж ахуйн шүтэлцээт байдлыг эрхэмлэж, түүнд зохицсон "Нүүдлийн" хэмээх өвөрмөц ахуй, соёлыг бүтээж хөгжүүлж ирсэн уламжлалт ард түмэн. Монгол улс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн жилүүдээс эхлэн Даян дэлхийн XXI зууны тогтвортой хөгжлийн үндэсний болон аймгийн хэмжээний төлөвлөөгө боловсруулан хэрэгжүүлж байгаа билээ. Цаашид түүнийгээ улам гүнзгийрүүлж бүс нутгийн хэмжээнд болон нэг гол нутаг, усныхныг өөрөөр хэлбэл анхан шатны хамтлагуудын тулхтай хөгжлийг дэмжих чиглэлээр тодорхой төсөл хэрэгжүүлэх нь ач холбогдлоо өгнө гэдэг нь харагдаж байлаа.

### **Хурлын үеэр маш өвөрмөц үзэсгэлэн гаргасан гэсэн, түүний онцлогоос ярихгүй юу ?**

Иоханнесбургийн Убунту-Виллэж дүүрэгт маш том үзэсгэлэнгүүд гаргасан. Япон, ӨАБНУ зэрэг томоохон орнууд бие дааж үзэсгэлэнгээ гаргасан. Энэ үеэр шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ, бизнесийн байгууллагын төлөөлөгчид уулзаж, тогтвортой хөгжлийг шинжлэх ухаан, технологээр яаж дэмжих вэ? гэдгийг голлон авч үзсэн. Шинжлэх ухааныг байгаль орчинд зохицсон амьдрал руу аль болох хандуулах, тэгэхдээ хүнд хоргүй, эрүүл ахуйн шаардалга хангасан бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох асуудлыг онцлон тавьсан. Шинжлэх ухааны үр дүнг ядууралтай холбож үзсэн. Мэдлэгт хязгааргүй, харин ядууралд хязгаар байх ёстой гэдгийг онцолж байв. 2030 онд эдийн засаг, экологи, нийгэм, соёлын асуудлыг хамтаар нь шийдвэрлэж, ядуурлыг арилгах бололцоотой гэдгийг тал бүрээс нь ярилцаж байлаа. Энэ хурал дээр анхаарал татсан нэг гол асуудал бол нийгмийн нөөц баялаг ядуугаас баян руу яваад, харин бохирдол баянаас ядуу руу урсаж байна гэж үзсэн. Одоо дэлхийн хүн амын 1/3 нь өлсгөлөн буюу өлөн зэлмүүн байна. Үүнийг яаж өөрчлөх вэ ? гэдэг асуудал дэлхий дахины анхаарлын төвд байгааг онцлон тэмдэглэж байв. Өмнө нь үйлдвэрлэл, арилжаанд суурилсан нийгэм байлаа. Одоо мэдээлэл гололсон нийгэм хөгжиж байна. Цаашид мэдлэгийн сүлжээнд суурилсан нийгэм байгуулах хэрэгтэй гэж үзэж байна. Энэ их чухал бөгөөд эрдэмтдийн хүчийг энэ зүгт хандуулья гэж уриаллаа. Үзэсгэлэн уулзалтын үеэр дэлхийд нэрд гарсан 100 гаруй томоохон компанийн төлөөлөгчид оролцсон байгаль орчиндоо халгүй бизнес эрхлэх, нийгмийн хариуцлагын бизнесийг хөгжүүлэх, тодруулж хэлбэл тулхтай хөгжлийг бизнесээр дэмжих асуудлаар нэг өдрийн арга хэмжээ болсон. Энэ бүхэн бол чуулга уулзалтын далайц, хүрээ хэр өргөн болсоныг гэрчлэх боловуу гэж болож байна.

### **Дэлхийн дээд хэмжээний уулзалтын гол үр дүнг багцалж хэлэхгүй юу?**

Нэгдүгээрт: Тогтвортой хөгжилд хүрэх тэргүүлэх үйл ажиллагааг тодорхойлон бодит, хэрэгжихүйц хэрэгжилтийн төлөвлөгөө боловсруулан баталж, улс төрийн хувьд нэгдсэн зөвшилцөлд хүрсэн, хоёрдугаарт: дэлхийн нийт хүн амын амьжиргааг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой асуудлыг шийдвэрлэхийн төлөө засгийн газрууд, иргэний нийгэм, бизнесийнхний хамтын түншлэлийг бүрдүүлж чадсан. Гуравдугаарт: тулхтай хөгжилд ахиц гаргах 5 гол асуудал болох. Ус ба эрүүл орчин, эрчим хүч, эрүүл мэнд, ХАА-н бүтээмж, биологийн төрөл зүйл ба экосистемийн менежментийн асуудлыг ялган тодорхойлж нарийвчлан хэлэлцэж шийдвэр гаргасан.

/Өдрийн сонины 2002 оны 9 дүгээр сарын 19-ны 227 дугаар/

**ДӨРӨВ. АНГЛИ ХЭЛЭЭР БЭЛТГЭЖ, ТАВЬСАН ИЛТГЭЛҮҮД**

**1. CURRENT STATUS OF THE NCSD IN MONGOLIA**

(Prasentation at East Asia “National Council for Sustainable Development” Workshop, July 8-9 2002, Seoul Korea)

Co-author: Ch. Erdenechimeg

**Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үндэсний  
Зөвлөлийн өнөөгийн дүр төрх, үйл ажиллагаа**

/Солонгосын Сөүл хотод 2002 оны 7 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд  
болсон Зүүн Азийн бүсийн "Тогтвортой хөгжлийн үндэсний  
зөвлөл" сэдэвт семинарт тавьсан илтгэлийн тойм/

Энэхүү семинар дээр Зүүн Азийн орнуудын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөлүүд харилцан туршлага солилцох зорилготой байсан бөгөөд илтгэлийн сэдэв нь ирсэн байсан тул илтгэгч уг чиглэлээр илтгэлээ бэлтгэсэн болно. Илтгэгч ТХҮЗ-ийн нарийн бичгийн даргаар ажилладгын хувьд үндэсний зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны зорилт, чиглэл, хийгдэж байгаа ажил, цаашдын зорилтын талаар дэлгэрэнгүй илтгэлийг хэлэлцүүлсэн юм. Түүнчлэн ТХҮЗ-ийг үндэслэн орон нутгийн тогтвортой хөгжлийн хороод хэрхэн ажилладгыг мөн хэлэлцүүлсэн байна. Илтгэлийн гол санааг цухас танилцуулбал, тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл /ТХҮЗ/ Монголд 1996 онд байгуулагдсанаас хойш тогтвортой хөгжлийг дэмжин дэлгэрүүлэх, тогтвортой хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү ТХҮЗ -ийн дарга нь Монгол Улсын Ерөнхий сайд бөгөөд Санхүү эдийн засаг, байгаль орчин болон үйлдвэр худалдааны сайд нар орлогч даргаар нь тус тус ажилладаг. Зөвлөл нь нийт 34 хүний бүрэлдэхүүнээс бүрддэг бөгөөд олон талын оролцоог бүрэн хангасан. Зөвлөлд Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, дэд сайд, яамдын газар, хэлтсийн дарга, төрийн бус байгууллагын тэргүүн, хувийн хэвшлийн төлөөлөгч нар орсон юм. Орон нутгийн тогтвортой хөгжлийн зөвлөлүүд Засаг даргаар ахлуулсан, 9-12 хүнийн бүрэлдэхүүнтэй, мөн олон талын оролцоог хангасан. Гэвч үндэсний болон орон нутгийн зөвлөлүүдийн олон талын оролцооны үүрэг, үйл ажиллагаа төдийлөн хангалтгүй, зарим тал дээр дутмаг, тодорхой бус байдгыг тэмдэглээд ТХҮЗ-өөс одоо хийгдэж байгаа үйл ажиллагааг тодорхой дурдахын хэрээр цаашид хэрхэн сайжруулах бодлого барьж байгааг хамруулсан байна.

**Introduction:** Mongolia has supported the sustainable development strategies and opportunities since the 1992 United Nations Conference on Environment and Development, which gave to Mongolians a new inspiration to development strategies. At that time the economic and social conditions of the country were demanded a crucial change, as it was the very beginning of transitional period from the central planned economy to a market oriented economy. The Government focused on the reforming of the state and thus, the first new development strategies were manifested in 1994 National Security Concept and 1996 National Development Concept. The sustainable development strategies of Mongolia for the 21st century were reflected in 1998 Mongolian Action Programme for the 21<sup>st</sup> Century (MAP 21) and 2001 Regional Development Concept.

**Organization and Composition of the NCSD:** The MAP 21 became a fundament for the creation of National Council for Sustainable Development (NCSD) as its implementation mechanism. Even

before the official start of MAP 21 document preparation, the Mongolian Government created NCSD chaired by the Prime Minister in April 1996 to oversee the development and implementation of Mongolia's sustainable development strategies. There were 13 members, mostly high-level government officials, including 6 Cabinet Ministers, 3 vice-ministers, 3 Local Governors and Director of International Organization Department of the Ministry of External Relations.

Membership or composition of the NCSD was developed in such a way that it would not change even if there are to be changes in the Government of Mongolia as, for example, the Prime Minister of Mongolia is automatically appointed as the Chairman of the NCSD.

The NCSD has been revised with the reorganization of the Government structure. Also the NCSD has reorganized itself by purpose to extend multi-stakeholder participation in implementation of NCSD decisions incorporating NGOs, private sector, academicians, and different level of government officials. Mongolia has experienced different approaches to extend multi-stakeholder participation in implementation of MAP 21. The multi-stakeholder participation in NCSD continues to be extended during the implementation stage of MAP 21. Incorporation of NGOs, private sector and academics was needed in the work of the NCSD at both national and local levels. There was also need to extend multi-stakeholder participation in the implementation of NCSD decisions not only incorporating NGOs, private sector and academicians, but also involving different level government officials.

The organizational structure of NCSD has changed four times since its creation, including its first structure:

- i. in May 1998, the NCSD has been changed after the reorganization of the Government. There were 18 members including representatives from the Parliament, NGOs and private sector (3 Chairs of Parliament Standing Committees, 6 Cabinet Ministers, 4 local Governors, Head of Cabinet Secretariat, Director of International Organization Department of the Ministry of External Relations, Sustainable Development Advisor of UNDP CO, Head of Business Council for Sustainable Development, and representative from NGOs),
- ii. in February 1999, the MAP 21 National Coordinator also became a secretary of NCSD,
- iii. in May 2002, NCSD presents the current structure and has 34 members including representatives from NGOs, private sector, local governors and scientific institutions.

Thus, if in previous modifications the NCSD appeared to be almost a replication of the Cabinet, according to the last changes the membership of NCSD have been enlarged inviting representatives from Parliament, NGOs, private sector and scientific institutions.



**The Current NCSD:** The current NCSD was organized in May 2002 and it has a full multi-stakeholder participation. The NCSD is comprised of different stakeholders from the government, NGOs, public and private sector and scientific institutions.

The NCSD has 34 members, including 4 chairpersons. The Prime Minister of Mongolia chairs the NCSD of Mongolia. Ministers of Finance and Economy, Nature and Environment and Trade and Industry hold the position of Deputy Chairs of the NCSD (see Appendix I).

In the composition of the NCSD include 4 Parliament members, Senior Advisor on economic issues to the Prime Minister, 6 Cabinet Ministers and the others, representing public, private, local and non-governmental organizations (see Appendix II).

The four heads of the Standing Committees of the Parliament who have become members of the Council are the chairs of Economic Policy Standing Committee, Budget Policy Standing Committee, Social Policy Standing Committee and Environment and Rural Development Standing Committee. These appointments have been the strongest points in the composition of the NCSD due to their direct involvement in the implementation of sustainable development in Mongolia. On the other hand, appointment of the four chairs of the Parliament Standing Committees to the membership of the NCSD gives an opportunity to integrate economic, social and environmental issues and is helpful to reflection of decisions of the NCSD at the decision making level.

Representatives of the following ministries are members of the NCSD: Finance and Economics, Nature and Environment, Social Welfare and Labor, Agriculture and Food Industry, Infrastructure, Health, Education, Culture and Science, Justice, External Relations to provide sectoral link. There are also representatives of NGOs which present environmental organizations, women's groups, youth association, children's organization, and trade unions.

**Local Committees for Sustainable Development:** Committees for SD at the local level are based on geographical and topical differences. At the local level all 21 aimags<sup>1</sup> have Economic, Social, Environmental Committees /ESECs/ headed by aimag governors (see Appendix I). Fulfilling the NCSD's decision the Aimag Sustainable Development Actions (ASDAs) facilitated setting up of the NCSD local branches headed by the Aimag and Capital City Governors - Economic, Social and Environmental Committees (ESECs) to guide the implementation of Aimag/ Capital City Action Programmes. The ESECs were established by the resolution of local Citizens' representatives that have also approved the membership of the committees. The ESECs are composed of members of local government, local parliament, local NGOs and business representatives. Under each ESEC there are three or four working groups specializing on the four

---

<sup>1</sup> Administrative (Provincial) units

Agenda 21 issues - economic, social, environment and civil society participation. Most of the NGO members of the Committees and the working groups include environmental organizations, women's groups, youth association, children's organization, trade unions, the National Poverty Programme, the Association of the Unemployed, Seniors' Association. Both national and local working groups include leading experts in relevant fields.

A typical ESEC is comprised of 9-12 members of the local administration and 1-5 representatives of NGO's and the private sector depending on aimag specifics. Most NGOs and the private sector are represented mostly in the working groups but not in all ESEC with the decision-making status. It is due to the lack of experience and commitment from the government representatives at both local and national levels in involving NGOs in decision-making process. NGOs have spring up freely only since 1990. Therefore, government agencies have no tradition and skills of working with recently established independent NGOs.

**Status of the NCSD:** The NCSD is a non-staff multi-stakeholder participatory body. The NCSD does not have its own Secretariat, the MAP 21 Project Implementation Unit (PIU) headed by the Secretary of NCSD and National Programme Coordinator serves as a Secretariat of NCSD. Mongolian NCSD is an executing agency of Mongolian Action Programme for the 21 century (MAP 21) responsible for creating favourable conditions for implementation of sustainable development activities in Mongolia. The Minister of Trade and Industry holds the position of the National Program Director of the Mongolian Action Program for the 21st Century.

